АЦБАБТ-ний зорилт	Бохир усыг усалгаанд ашиглан ургуулсан бүтээгдэхүүний хэрэглээтэй холбоотой өвчнөөс урьдчилан сэргийлэх, тариалан эрхлэгчдийн аюулгүй байдлыг хангах Эрсдэлийн үнэлгээ болон удирдлагын асуудлыг үндэсний бодлого, хууль тогтоомжид тусгах талаар үндэсний ба бус нутгийн хэлэлцүүлэг өрнүүлэхийг хөхиүлэн дэмжих
Байршил	Ойр орчмын суурин газрын оршин суугчдын ялгадас, бохир усаар бохирлогдсон голын баруун эрэг орчмын газар. Үүнд ногоон байгууламж, хувийн орон сууц, ногооны талбай болон бохирлогдсон голын усаар усалдаг 1100 га орчим тариалангийн талбай хамаарч байна
АЦБАБТ-ний хил хязгаар	АЦБАБТ-ний хэрэгжих боломжийг харгалзан тухайн нутаг дэвсгэрийн 3 байршлыг сонгон АЦБАБТ-ний хил хязгаарыг тогтоосон байна. Үүнд: 300 гаруй газар эзэмшигчийн мэдлийн 23 га, 330 га, 250 га талбайг хамарсан 3 байршил байв.
Тэргүүлэх байгууллага	Гол мөрөн ашиглагчдын зөвлөл (тухайн нутаг дэвсгэр дээрх усжуулалтын системийг ажиллуулдаг зөвлөл), зөвлөлд мэргэжил аргагүйн дэмжлэг үзүүлэх эрдэм шинжилгээний байгууллага

ЖИШЭЭ 1.6

Хотын ариутгах татуургын систем, өтгөн лагийн боловсруулалт ба ХАА дэх хэрэглээ, Кампала, Уганда

АЦБАБТ-ний зорилт	<ul style="list-style-type: none"> • Ариутгах татуургын системийн ажилчид, бохирын урсгал дагуух суурин газрын оршин суугчид, тариаланчид, хэрэглэгчдийн эрүүл мэндийг хамгаалах • Виктория нуурын ундны усны сав газрыг хамгаалах
Байршил	Кампала, Уганда
АЦБАБТ-ний хил хязгаар	Хил хязгаарыг тогтоох дараах 3 хувилбарыг харьцуулсан. Үүнд: (1) сав газар, (2) ариутгах татуургын операторын хариуцах асуудлын хүрээ, (3) хотын засаг захиргааны нэгжийн хил хязгаар. Сав газрын хил хязгаараар АЦБАБТ-ний хил хязгаарыг тогтоохыг зорих нь зүйтэй гэж үзсэн хэдий ч туршилтын шатанд хил хязгаарыг арай хязгаарлагдмал байдлаар тодорхойлсон байна. Туршилтын шатны хил хязгаарт бохирын шугам хоолойны сүлжээ, цэвэрлэх байгууламж, Накивумбо намагшсан газрын суваг (энэ нь цэвэрлэсэн бохир усыг газар тариаланд ашигладаг нутаг дэвсгэр бөгөөд Кампала хотын ундны эх үүсвэр болсон Виктория нуур руу цэвэрлэсэн бохир усыг асгахын өмнөх хэсэгт байрладаг)-ийг хамарсан газар нутгийг багтаан авч үзсэн (Зур. 2)
Тэргүүлэх байгууллага	Үндэсний ус, ариутгах татуургын корпораци (энэ нь Уганда улсын ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээ эрхэлдэг байгууллага юм) ба Кампала нийслэл хотын засаг захиргаа

ЗУРАГ 2.



ЖИШЭЭ 1.7

Сонирхогч талуудын дүн шинжилгээ, Перу: томоохон цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламжийн усалгаанд цэвэрлэсэн бохир усыг шууд хэрэглэх нь

Удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох эхний шалгуур нь ахуйн бохир усыг ашигладаг бүх салбарын оролцоог хангах явдал байв. Иймд Үндэсний усны газраар ахлуулсан Удирдах хорооны бүрэлдэхүүнд ариутгах татуурга, эрүүл мэнд, орчин, ХАА, ногоон байгууламжийн асуудал эрхэлсэн газар, ариун цэврийн хяналтын байгууллагын төлөөллийг багтаасан байна. Лима хотод мөн хотын засаг захиргааны төлөөллийг оруулсан болно. Түүнчлэн судалгаа шинжилгээний ажлын чанарыг хянах, сургалтын хөтөлбөрт АЦБАБТ-ний асуудлыг тусгах зорилгоор Удирдах зөвлөлд их сургуулийн төлөөллийг стратегийн түнш болгон оруулсан.

Удирдах зөвлөл АЦБАБТ-г нэн тэргүүнд хэрэгжүүлэх газруудыг сонгож, бохир усыг дахин ашиглах талаар эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлыг хэлэлцэх чиг үүрэгтэй ажилласан.

ЖИШЭЭ 1.8

АЦБАБТ-ний багийн гишүүдийн жишээ

Ариун Цэврийн Алхам	АЦБАБТ-ний багийн гишүүдийн жишээ
Сав газар	Зайлуулах сувагт бохир нийлүүлдэг буй томоохон үйлдвэрлэгчдийн төлөөлөл
Бохирын эх үүсвэр	Үйлдвэрлэгчдийн холбоо
Бохир цуглуулах ба цэвэрлэх	Ариун цэврийн системийн операторууд Цэвэрлэх байгууламжийн операторууд (ж.нь, хотын цэвэрлэх байгууламж, бордооны үйлдвэрийн операторууд, био-тулшний үйлдвэрийн олон нийтийн удирдах хороо)
Бохирын тээвэрлэлт	Бохирын цооног сордуулдаг машинч, операторууд, бохирын шугам хоолойн операторууд
Бохирын ашиглалт	Тарилгачдын төлөөлөл, ажилчдын төлөөлөл, оршин суугчид
Бүх алхам	Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн буюу албан тушаалтан

ЖИШЭЭ 1.9

Баг бүрдүүлсэн туршлага, Португал

Сурь мэдээлэл: 160000 хүн амтай, 3300 км² газар нутгийг хамарсан 7 хот суурин газрын ус хангамж, ариун цэврийн системийг харихуудад ажилладаг компанийн ариутгах татуурлын АЦБАБТ-г боловсруулсан

Зорилт: Компанийн АЦБАБТ-нийхүүрээнд дараах зорилтыг дэвшүүлсэн. Үндэ:

- Эрсдэлийг долоор нь үнэлж, удирдах
- Эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулах, үр ашигтай, тогтвортой үйлчилгээний чанарыг сайжруулах боломжуудыг тодорхойлох
- Ус хангамж, ариутгах татуурлын үйлчилгээний найдвартай байдлыг нэмэгдүүлэх
- Цэвэрлэсэн бохир ус болон өгөн лагийн хэрэглээг хөхүүлэн дэмжих
- Орчны хамгааллыг сайжруулах.

Нэгэлтээр Португал улсад АЦБАБТ-г хэрхэн хөгжүүлж, хэрэгжүүлэх талаар үндэсний хэмжээнд хэлэлцүүлэг өрнүүлэх ерөнхий зорилт дэвшүүлсэн байна.

АЦБАБТ-г боловсруулах 3 баг бүрдүүлсэн. Үндэ:

- Төслийн зохицуулах баг
- АЦБАБТ-ний баг
- Сонирхогч талуудын баг

Төслийн зохицуулах баг нь 3 хүний бүрдэлдхүүнтэй бөгөөд төслийг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх, гол гол асуудлуудыг цаг хугацаанд нь шийдвэрлэхэд анхаарч ажилласан.

АЦБАБТ-ний баг нь усны компанийн бүх нэгжийн төлөөлөлөөс бүрдсэн байв. Үндэ: удирдах зөвлөл, чанарын алба, цэвэрлэлтийн алба, шугам сүлжээний удирдлагын алба, хэрэглэгчидтэй харилцах алба, мэдээллийн технологи/газарзүйн мэдээллийн системийн алба, санхүү ба хүний нөөцийн алба.

АЦБАБТ-ний багийн зохицуулагчаар сонирхогч талуудтай нягт хамтран ажилладаг, компанийн УАБТ-ийн төслийн багийн ахлагчар ажиллаж байсан туршлагагай компанийн чанарын менежерийг томилсон.

ЖИШЭЭ 1.10

АЦБАБТ-ний баг, Хотын зөвлөл, Энэтхэг

Сонирхогч талуудын баг нь төслийг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж чалах сонирхогч талуудын төлөөлөөс бүрдсэн байв. Армун цэврийн системтэй холбоотой үйл ажиллагаанд нөлөөлөх боломж, эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэхэд гүйцэтгэх үүрэг зэргийг хөргөлзөн сонирхогч талуудыг сонгосон байна. Эдгээр нь бодлогын үндэслэлд, технологийн "ноу-хау", туршлагын хувьд олон мэргэжлийг төлөөлөхүүш байсан болно.

Тус багт орчин, ХАА, хяналтын байгууллагын төлөөлөл, сав газрын удирдах газар, эрүүл мэндийн газар, хотын захиргаа, иргэний хамгаалал, онцгой байдлын алба, ТББ, эрдэм шинжилгээний байгууллага, тариаланчдын нийгэмлэг, усны нийгэмлэг зэргийн төлөөлөл багтсан.

Зөвлөх нь АЦБАБТ-г удирдан чиглүүлэх, мэргэжил аргазүйн зөвлөгөө өгөх чиг үүрэгтэй ажилласан. Тэрээр уулзалтуудыг төлөвлөж, удирдан чиглүүлэх, АЦБАБТ болон сонирхогч талуудын багтай хамтран ажиллах, мэдээлэл цуглуулан баталгаажуулах, аюулт хүчин зүйл/үзэгдлийг тодорхойлох, эрсдэлийг үнэлэхэд мэргэжил аргазүйн зөвлөгөө өгөх аюулдыг харууцаж байв.

АЦБАБТ-ний багийн гишүүн	Мэдлэг/ур чадвар/АЦБАБТ-ний багт гүйцэтгэх үүрэг
Мужийн ус хангамж, бохир ус зайлуулах асуудал эрхэлсэн зөвлөл – ахлаг менежер	<p>Мэдлэг/ур чадвар: ус хангамж, ариутгах талууртын нөхцөл байдлын талаар болон мэргэжлийн мэдлэг, ур чадвартай</p> <p>АЦБАБТ-ний багт гүйцэтгэх үүрэг:</p> <ul style="list-style-type: none"> • Багийн ахлагч • АЦБАБТ-ний Удирдах зөвлөлтэй үйл ажиллагааг уялдуулах, талаарын үйл ажиллагааг зохион байгуулах • АЦБАБТ-ний бүхий л үйл ажиллагааг ерөнхийд нь харууцах • Хотын армун цэврийн үйлчилгээнд хөрөнгө хуваарилуулахад АЦБАБТ-ний сайжруулалтын төлөвлөгөөг ашиглах
Хотын зөвлөл – Орчны инженер ба эрүүл мэндийн ахлагч байцагч	<p>Мэдлэг/ур чадвар: орчны, эрүүл мэндийн талаар мэргэжлийн мэдлэг, ур чадвартай, орон нутгийн нөхцөл байдал болон хотын захиргааны зохион байгуулалтын талаар мэдлэгтэй</p> <p>АЦБАБТ-ний багт гүйцэтгэх үүрэг:</p> <ul style="list-style-type: none"> • Мэдээ цуглуулах • АЦБАБТ-г боловсруулах (аюулт хүчин зүйл ба эрсдэлийн үнэлгээ) • Сайжруулалтын ба хяналт-шинжилгээний төлөвлөгөөг боовсруулах
Анагаах ухааны коллеж	<p>Мэдлэг/ур чадвар: тархвар судлал/эрүүл мэнд</p> <p>АЦБАБТ-ний багт гүйцэтгэх үүрэг:</p> <ul style="list-style-type: none"> • Эрүүл мэндтэй холбоотой асуудлаар мэргэжил аргазүйн дэмжлэг үзүүлэх, Хотын зөвлөлийн багт шаардлагатай бол сургалт зохион байгуулах • АЦБАБТ-нд эрүүл мэндийн эрсдэлийн үнэлгээний аюулдыг тусгах
Зөвлөх	<p>Мэдлэг/ур чадвар: орчны инженерчлэл</p> <p>АЦБАБТ-ний багт гүйцэтгэх үүрэг:</p> <ul style="list-style-type: none"> • Мэргэжил аргазүйн болон зохион байгуулалтын дэмжлэг, чиглэл, удирдажгаар хангах

Жишээ 1.3-с суурь мэдээллийг харна уу


ЖИШЭЭ 1.11

Перугийн АЦБАБТ-ний баг: ХАА-н салбар дах
бохир усны шууд бус хэрэглээ

АЦБАБТ-ний багийн гишүүн	Мэдлэг/ур чадвар/АЦБАБТ-ний багт гүйцэтгэх үүрэг
Гол мөрөн ашиглагчдын зөвлөл	<p>Мэдлэг/ур чадвар: гол орчмын ХАА-н бус нутаг дах усжуулалтын системийн удирдлага</p> <p>АЦБАБТ-ний багт гүйцэтгэх үүрэг:</p> <ul style="list-style-type: none"> Багийн ахлагч Бохир усны ашиглалт, тогтсон практик болон бусад мэдээллийг багийн гишүүдэд өгөх
Сургалт, эрдэм шинжилгээний байгууллага	<p>Мэдлэг/ур чадвар: усны хэрэглэгч, мэргэжлийн үйл ажиллагааны тухай мэдээлэл</p> <p>АЦБАБТ-ний багт гүйцэтгэх үүрэг:</p> <ul style="list-style-type: none"> Мэргэжлийн үйл ажиллагааны тухай мэдээлэл Ус, хөрс, өвснөөс сорьц авах
Газар тариалан эрхлэгчид	<p>Мэдлэг/ур чадвар: тариалангийн газар, усан сан эзэмшигчид</p> <p>АЦБАБТ-ний багт гүйцэтгэх үүрэг:</p> <ul style="list-style-type: none"> Бохир ус ашиглах тогтсон практикийн талаар багийн гишүүдэд мэдээлэл өгөх Ус, хөрс, хүнсний ногоо, загаснаас сорьц авах зөвшөөрөл олгох Хяналтын арга хэмжээг хэрэгжүүлэх (ж.нь, хэрэглээнд хязгаарлалт тогтоох, бохир ус ашигласнаас хойш үр тариаг хэрэглэх хүртэлх хадгалалтын наад захын хугацааг мөрдөх)

ЭМҮ, Үндэсний орчны эрүүл мэндийн агентлаг	<p>Мэдлэг/ур чадвар: хэрэглэгчдийн эрүүл мэндийг хянах, мэдээлэх</p> <p>АЦБАБТ-ний багт гүйцэтгэх үүрэг:</p> <ul style="list-style-type: none"> Эрүүл мэндтэй холбоотой асуудлаар мэдээлэл өгөх Хүнсний аюулгүй байдлын талаар сургалт, тандалт зохион байгуулах
НҮБ-ын Олон улсын нийгмийн эрүүл мэндийн төрөлжсөн байгууллага (АЦБАБТ-г санхүүжүүлэгч)	<p>Мэдлэг/ур чадвар: эрүүл мэндийн салбарт хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх</p> <p>АЦБАБТ-ний багт гүйцэтгэх үүрэг:</p> <ul style="list-style-type: none"> Мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх

Жишээ 1.5-с суурь мэдээллийг харна уу



МОДУЛЬ 2

АРИУН ЦЭВРИЙН
СИСТЕМИЙН
ЗУРАГЛАЛГАРГАХ НЬ

МОДУЛЬ 2

АРИУН ЦЭВРИЙН СИСТЕМИЙН ЗУРАГЛАЛГА ГАРГАХ НЬ

МОДУЛЬ

- 2.1 Системийн газрын зураглал гаргах нь
- 2.2 Бохирын бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлох нь
- 2.3 Өртөж болзошгүй бүлгүүдийг тодорхойлох нь
- 2.4 Нөхцөл байдлын талаар мэдээлэл цуглуулах нь
- 2.5 Системийн зураглалыг баталгаажуулах нь

ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ ҮР ДҮН

- Системийн газрын зураг, тайлбар зураглалыг гаргаж, баталгаажуулна
- Өртөж болзошгүй бүлгүүдийг тодорхойлсон байна
- Бохирын найрлага, бохиртой холбоотой эрүүл мэндэд хор хөнөөл учруулах аюулт хүчин зүйлийн талаар ойлголттой болно
- Системийн гүйцэтгэл, өртөмтгий байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар ойлголттой болно
- Мэргэжлийн, эрх зүйн болон зохицуулалтын холбогдох бүх мэдээллийг нэгтгэсэн байна

Тойм

Модуль 2-ын үндсэн зорилго нь Модуль 1-ийн хүрээнд тодорхойлсон хил хязгаар доторх ариун цэврийн системийн бүрэн зураглалыг гаргахад оршино. Ариун цэврийн системийн бүх бүрэлдэхүүн хэсэг, гүйцэтгэлд нь тавих шаардлагын талаар нарийн ойлголттой болох нь цаашид эрсдэлийг үнэлэхэд чухал ач холбогдолтой юм.

Модуль 2.1 нь бохирын эх үүсвэр, урсгалын талаар ойлголттой болоход туслана. Энэ нь цаашид өртөмтгий бүлгүүдийг тодорхойлоход чухал юм.

Модуль 2.2 нь бохирын микробиологийн, физикийн, химийн найрлага, системийн гүйцэтгэл, өртөмтгий байдалд нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлно.

Модуль 2.3 нь өртөмтгий бүлгүүдийг тодорхойлж, системийн хаана, хэрхэн өртөл явагдаж байгааг тогтооно. Үүнийг Модуль 2.1-ийн хүрээнд гаргасан зураглалын дагуу бүртгэнэ.

Модуль 2.4 нь хууль, тогтоомжоор ариун цэврийн системд тавих шаардлага, өмнө нь хийгдэж байсан хяналтын тайлан мэдээ, тухайн нутаг дэвсгэрийн уур амьсгал, газрын ашиглалт, соёл уламжлал, хүн ам зүйн онцлог, бохирдуулагч болон эмгэг төрөгчийн эх үүсвэр, үүнтэй

холобогтой эрсдэлийг бууруулахад ариун цэврийн систем үр дүнтэй байж чаддаг эсэх талаар баримт мэдээллийг цуглуулахад анхаардаг. Тэгвэл шаардлага болон эрүүл мэндийн эрсдэлийн хооронд зөрүүтэй зүйл ажиглагдавал Удирдах зөвлөлийн сонорт хүргэж, бодлогыг тодотгон сайжруулах үйл ажиллагааг эхлүүлэх шаардлагатай.

Модуль 2.5 нь системийн зургаллын бүрэн бүтэн байдлыг хангахад анхаарна. Үүний тулд орхигдсон асуудлуудыг (ж.нь, бодлогын "цорхой") тодорхойлдог.

Модуль 2 нь АЦБАБТ-ний багт ариун цэврийн системийн сул талыг тодорхойлох, хяналтын арга хэмжээний үр дүнтэй байдал (хяналтын арга хэмжээг Модуль 3-д тодорхойлно) болон системийн гүйцэтгэлийг багатгаажуулахад шаардлагатай мэдээллийг өгч чаддаг.

Ариун цэврийн системийн эрүүл мэндийн буюу орчны нөлөөллийн үнэлгээ өмнө нь хийгдсэн тохиолдолд энэхүү Модулийн хүрээнд цуглуулах мэдээллийн ихэнх нь бэлэн байх давуу талтай. Ийм тохиолдолд эдгээр үнэлгээний мэдээллийг дараа дараагийн Модулийн хүрээнд ашиглах боломжтой юм.

2.1 Системийн газрын зураглал гаргах нь

АЦБАБТ-ний систем болгон өөрийн гэсэн онцлогтой байдаг тул систем тус бүрийн хувьд онцлогийг нь тусгаасан газрын зураг, тэйлбар зураглал гаргах шаардлагатай.

Газрын зураглал гаргах аргыг сонгохдоо системийн хамрах хүрээ, нарийн төвөгтэй байдлыг харгалзана. Зарим тохиолдолд системийн урсгалын бүдүүвч гаргах аргыг ашиглах нь зүйтэй. Харин АЦБАБТ-ний хил хязгаар нь тодорхой суурин газар, сав газрыг хамарсан тохиолдолд газрын зураг гаргах нь оновчтой юм.

Системийн урсгалын бүдүүвч нь системийн бүрэлдэхүүн хэсгүүдийг хооронд нь холбосон английн инженерийн бүдүүвч (Жишээ 2.1-ийг харна уу), эсхүл үйл явцын урсгалын стандарт тэмдэглэгээг ашиглан зурсан системийн үйл явцын бүдүүвч (Жишээ 2.2 ба 2.3-ыг харна уу) байж болно. Томоохон системийн хувьд хялбаршуулсан ерөнхий бүдүүвч гаргаж, илүү дэлгэрэнгүй үйл явцын бүдүүвчийг үйл явц тус бүрээр тусд нь гаргаж хавсаргах нь зохимжтой юм.

Системийн зураглал нь бохир үүсэх цэгээс эхлэн, түүнийг ашиглах буюу зайлуулах цэг хүртэлх үйл явцыг хамарсан байна. Ариун цэврийн жижиг оврын тусгаарлагдмал системээс төвлөрсөн систем хүртэл олон төрлийн системийн жишээ зураглалыг Stenstjцтц нарын (2011) номоос харна уу.

Зураглалыг аль болох үнэн зөв, нарийвчлалтай гаргах ёстой тул газар дээр нь заавал очиж ажиллах шаардлагатай. Тухайлбал, Модуль 2.4-ийн хүрээнд нөхцөл байдлын талаар ямар мэдээлэл шаардлагатайг мэдэхийн тулд систем, бохирын бүрэлдэхүүн хэсэг, өртөмтгий бүлгийн талаар бүрэн ойлголттой байх нь чухал. Ийм ч учраас зураглал гаргах болон дараа дараагийн Модулиудад шаардлагатай мэдээллийг

цуглуулах зорилгоор газар дээр нь очиж нөхцөл байдлтай танилцах хэрэгтэй.

Бохирын урсгалын хурд, цэвэрлэх системийн бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн багтаамж зэрэг бохирын урсгалын талаар тоон мэдээллийг цуглуулна. Мөн системийн ажиллагаанд нөлөөлж болохуйц гэнэтийн өөрчлөлтийн талаар ойголт авах нь чухал юм (ж.нь, хүчтэй бороо, үер бусан үед системийн ачаалал хэрхэн өөрчлөгддөг). Систем бүхэлдээ буюу түүний бүрэлдэхүүн хэсгүүдийн ажиллагаа найдвартай байгаа тохиолдолд энэхүү гэнэтийн өөрчлөлтүүд системийн гүйцэтгэлд нөлөө багатай байна.

Чиглүүлэх зөвлөмж 2.1-ийг Модуль 2.1-ийн хяналтын хуудас болгон ашиглах боломжтой.

2.2 Бохирын бүрэлдэхүүн хэсгүүдийг

тодорхойлох нь

Модуль 2.1-ийн хүрээнд гаргасан зураглал нь бохирын янз бүрийн бүрэлдэхүүн хэсгийн ариун цэврийн систем дэх урсгалыг тодорхой болгодог.

Тэгвэл Модуль 2.2-ийн хүрээнд бохирын бүрэлдэхүүн хэсгүүдийн найрлагыг тодорхойлно. Энэ нь Модуль 3.1-д аюулт хүчин зүйлийг тодорхойлоход шаардлагатай бэлтгэл ажиллагаа юм. Мөн системийн гүйцэтгэл, нэн ялангуяа цэвэрлэлтийн үе шатны гүйцэтгэлд нөлөөлж болзошгүй хүчин зүйлийг тодорхойлоход чухал ач холбогдолтой байна. Бохирын найрлагыг мэдсэн тохиолдолд түүнийг ашиглахтай холбоотой учирч болох эрүүл мэндийн эрсдэлийн талаар мэдээ цуглуулах (Модуль 2.4-ийн хүрээнд) АЦБАБТ-ний багийн үйл ажиллагаа илүү хялбар болно.

Бохирын бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлох үйл ажиллагааны хүрээнд ариун цэврийн систем дэх бохирын ямар урсгал байгааг нарийвчлан тогтооно. Тухайлбал, бохир гэдэг нэр томъёо өргөн утгатай бөгөөд ахуйн хэрэглээнээс гарсан бохир ус, өтгөн, шээс, борооны ус, үйлдвэрийн хаягдал ус зэргийг багтаасан ойголт юм. Иймд бохирын урсгал ямар үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдээс тогтож байгааг тодорхойлох шаардлагатай (Жишээ 2.4, Чиглүүлэх зөвлөмж 2.2 ба 2.4-өөс бохирын бүрэлдэхүүн хэсэг болон харгалзах хүчин зүйлийн талаар дэлгэрүүлнэ үү).

2.3 Өртөж болзошгүй бүлгүүдийг тодорхойлох нь

Өртөж болзошгүй бүлгүүдийг тодорхойлох гэдэг нь тухайн аюулт хүчин зүйлд өртөх боломжтой хүмүүсийг тогтоох үйл ажиллагаа юм. Ингэх нь эрсдэлийн үнэлгээ хийх (Модуль 3) хүрээнд хяналтын арга хэмжээний тэргүүлэх чиглэлийг тодорхойлох боломж олгодог байна.

АЦБАБТ-нд ашигладаг өртөмтгий бүлгийн ерөнхий ангиллыг Арга хэрэгсэл 2.1-д харуулсан бөгөөд энэхүү ангиллыг Модуль 2.1-ийн хүрээнд гаргасан системийн зураглал дээр нэмж болно. Ийнхүү ерөнхий байдлаар тодорхойлсон өртөмтгий бүлгүүдийг Модуль 3.2-т нарийвчилж, дэд бүлгүүдэд ангилан, эрсдэлийн үнэлгээнд ашиглана.

2.4 Нөхцөл байдлын талаар мэдээлэл цуглуулах нь

АЦБАБТ-г боловсруулах, хэрэгжүүлэхэд шаардлагатай нөхцөл байдлын талаарх мэдээллийг цуглуулж, тоймлон нэгтгэнэ. Тоо мэдээ, үндэсний стандарт, техникийн үзүүлэлт зэрэг шаардлагатай мэдээлэл байхгүй тохиолдолд асуудлыг Удирдах зөвлөлд танилцуулж, зөвлөлийн зүгээс энэ талаар арга хэмжээ авах эсэх талаар шийдвэр гаргана. Дараах мэдээллийг цуглуулахад анхаарна. Үнд:

- Холбогдох чанарын стандарт, гэрчилгээ авах болон аудитад хамрагдахад тавих шаардлага
- Системийн удирдлага, гүйцэтгэлтэй холбоотой мэдээлэл
- Хүн ам зүйн онцлог, газар ашиглалтын байдал
- Цаг уур, улирлын онцлогоос хамаарч гардаг буюу гарч болзошгүй өөрчлөлт

Мэдээлэл цуглуулахдаа системийн онцлогоос хамаарч зарим мэдээлэл шаардлагагүй байж болохыг анхаарч Чиглүүлэх зөвлөмж 2.3-г ашиглана уу.

Модуль 2.2-д бохирын бүрэлдэхүүн хэсгийг тодорхойлсны үндсэн дээр эрүүл мэндийн ямар эрсдэл учирч болзошгүй талаар ойлголт бий болно. Чиглүүлэх зөвлөмж 2.4-ийг ашиглан аюулт хүчин зүйлсийг нарийвчлан тодорхойлоход тархварзүйн ба орчны холбогдолтой тоо мэдээ шаардлагатай болно. Тухайлбал, цагаан хорхойтой холбоотой эрүүл мэндийн эрсдэл байж болзошгүй гэж үзсэн бол цагаан хорхойн ямар төрлүүд тухайн орон нутагт хэр их тархсныг тогтоох нь зүйтэй. Хүчин зүйл тус бүрийн хувьд шаардлагатай мэдээний чанар, мэдээллийн эх үүсвэр ялгатай байж болно. Биологийн, химийн ба физикийн аюулт хүчин зүйлийн талаарх мэдээллийг тодорхойлох, цуглуулахад Чиглүүлэх зөвлөмж 2.5, 2.6, 2.7 тус дөхөм болно. Цуглуулсан мэдээлэл нь Модуль 3.1-ийн хүрээнд эрүүл мэндэд хор уршиг учруулах аюулт хүчин зүйлийг тодорхойлоход ач холбогдолтой юм.

2.5 Системийн зураглалыг баталгаажуулах нь

Модуль 2.5-ийн хүрээнд газар дээр нь ажиллах, бусад шаардлагатай судалгаа хийх замаар системийн зураглалыг баталгаажуулна. Модуль 2.1-2.4-ийн хүрээнд бүрэн гүйцэд, үнэн зөв мэдээлэл цуглуулахад анхаарна. Системийн зураглалыг баталгаажуулахдаа системийн техникийн болон гүйцэтгэлийн үзүүлэлт (ж.нь, цэвэрлэлтийн зэрэг)-ийг давхар баталгаажуулах нь зүйтэй.

Системийн зураглалыг баталгаажуулахад олон аргыг ашиглаж болно, тухайлбал ариун цэврийн хяналт, тандалт, зорилгот бүлгийн хэлэлцүүлэг, үндсэн мэдээлэгч нараас ярилцлага авах, сорьц цуглуулж лабораторийн шинжилгээ хийх (Жишээ 2.5-с харна уу). Эдгээрээс ямар аргыг ашиглах нь ариун цэврийн системийн хэмжээ, төрлөөс хамаарна. Цэвэрлэлтийн зэргийн үзүүлэлтийг баталгаажуулахын тулд техникийн лавлагаа бичиг баримтуудыг ашиглахаас гадна туршилт, шинжилгээ хийж болно. Баталгаажуулалт хийсний дагуу системийн газрын зураг, зураглал, бохирын бүрэлдэхүүн хэсэг, системийн гүйцэтгэл, өртөмтгий байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаарх мэдээллийг шинэчлэх нь зүйтэй.

ЧИГЛҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ 2.1

Системийн зуралдал гаргахдаа анхаарах асуудлуудын жэгсаалт

- Бохирын бүх эх үүсвэрийг тусгах, үүнд цэглэн ба цэгэн бүс (ж.ш. борооны ус) эх үүсвэр хамарна
- Бохирын урсгалын бүх кэсгийг хэрхэн ашигласан буюу зайлуулсныг тооцох (ж.ш. газар тариалан буюу усны аж ахуйд ашигласан, хорьсон/ашигласан, гадаргууны буюу гүний ус руу зайлуулсан)
- Бүх хөрөг каалтыг тодорхойлох, ж.ш. бохирын цоолог, үлдэц/руулах цөөрөг
- Урсгалын хурд мэдэгдэж байсан тусгах
- Бүрэлдэхүүн кэсгүүдийн багтаамж, хүчин чадал мэдэгдэж байгаа тусгах (ж.ш. Цэн эрхэс бэлтгэх/ашигласны урсгал буюу багтаамжийн дээд хязгаар, дамжин өнгөрүүлэх системийн хүчин чадал)
- Ариун цэврийн системийн үйл ажиллагаанд хамаралтай бол уяндаа усны эх үүсвэрүүдийг тусгах

ЧИГЛҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ 2.2

Бохирын бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлоход анхаарах хүчин зүйлс

- Бохирын эх үүсвэр
- Бохирын шингэн ба хатуу бүрэлдэхүүн хэсгүүд (Чиглүүлэх зөвлөмж 2.3-с харна уу)
- Бохиртой санамсаргүй байдлаар холилдсон эрсдэлт бүрэлдэхүүн хэсгүүд (ж.нь, өтгөн лаг дотор сахлын хутга, зай холилдох)
- Бохир доторх химийн ба физикийн бохирдуулагч, эмгэг төрөгч бичил биетний агууламж

ЧИГЛҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ 2.3

Системийн зураглал гаргахад шаардлагатай нийцлийн ба нөхцөл байдлын тухай мэдээлэл

Эрүүл мэндэд хор учруулж болзошгүй аюулт хүчин зүйл, хүн амзүйн онцлог, орчны хүчин зүйлсийн талаар мэдээлэл цуглуулахад дараах асуудалд анхаарвал зохино. Үнд:

a) Холбогдох чанарын стандарт, гэрчилгээ авах болон аудитад хамрагдахад тавих шаардлага

Жишээлбэл:

- Холбогдох хууль, дотоод журам
- Бохир усны гаргалгаа буюу үнэрт тавих шаардлага
- Хотын суурьшлын бүс, газар тариалан/бэлчээрийн газрын байршлыг харгалзан төлөвлөлт хийхэд тавих шаардлага, хязгаарлалтууд
- ХАА-н бүтээгдэхүүнтэй холбоотой үндэсний тусгайгласан хууль тогтоомж
- Гамшгийн бэлэн байдал, төлөвлөлттэй холбоотой үндэсний удирдамж
- Чанарын хяналт-шинжилгээ, тандалт, системийн аудит (санхүүгийн бүс)-тай холбоотой журмууд
- ХАА-н бүтээгдэхүүнд гэрчилгээ олгоход тавих шаардлага

b) Системийн удирдлага, гүйцэтгэлтэй холбоотой мэдээлэл

Үүнд дээрх [a] хэсэгт дурьдсан шаардлагудын биелэлтийг хянах, хэрэгжилтийг хангахтай холбоотой баримт мэдээлэл хямаарна. Үнд дараах зүйлийг анхаарна:

- Өмнө нь хийгдсэн хяналт-шинжилгээ, тандалттай холбоотой тоо мэдээ
- Баримтжуулалтын давтамж
- Илрүүлсэн зөрчлийг арилгасан эсэхийг эргэн хянасан байдал
- Тархварзүйн тоо баримт
- Бүтээгдэхүүний төрөл, хэмжээ

c) Хүн ам зүйн онцлог, газар ашиглалтын байдал

Дараах асуудлыг анхаарна:

- Газрын ашиглалтын төлөв байдал, хүн амын суурьшлын бүс (үүнд мөн зөвшөөрөлгүй суурьшлын бүс хямаарна), ариун цэврийн системд нөлөөлж болзошгүй хүн ам ба тодорхой үйл ажиллагаа
- Тэгш байдал (явс үндэс, машин шүтлэг, шилжин суурьшигчид, өртөгтгий бүлэгтэй холбоотой)

d) Цаг уур, улирлын онцлогоос хамаарч гардаг буюу гарч болзошгүй өөрчлөлт

Дараах асуудлыг анхаарна:

- Цэвэрлэх байгууламжийн ачааллын дундаж хэлбэлзэл (жилийн хугацаанд)
- Газар тариалангийн ажилтай холбоотой ашиглалтын улиралчлал
- Бороо ихтэй үед бий болдог нэмэлт урсгал ба цэвэрлэлтийн үйл ажиллагаанд үзүүлэх нөлөө (ж.нь, нэмэлт хадгалалтын цөөрөм хэрэгтэй болох)
- Усны хомсдолтой үед хэрэглээний төлөв байдалд ордог өөрчлөлт.

ЧИГЛҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ 2.4

Бохирын бүрэлдэхүүн хэсэг ба эрүүл мэндэд хор уршиг учруулж болох аюулт хүчин зүйлс

	Бохирын найрлага									
	Биологийн аюулт хүчин зүйл					Химийн аюулт хүчин зүйл		Физикийн аюулт хүчин зүйл		
Вирүс	Нян	Эгэл биетэн	Цагаан хорхой	Вектор	Химийн хортой бодис	Хүнд металл	Хурц зүйл	Органик бус материал	Эвгүй үнэр	
Бохирын шингэн бүрэлдэхүүн хэсэг										
Шингэрүүлсэн ялгагдас (хүн буюу амьтны)	X	X	X	X	X					X
Шээс (хүн буюу амьтны)	X	X	X	X	X					X
Аууин бохир ус	X	X	X	X	X		X	X	X	X
Борооны ус	X	X	X	X	X	X	X	X	X	
Голын ус	X	X	X	X	X	X	X	X	X	
Үйлдвэрийн хаягдал ус						X	X			
Бохирын хатуу бүрэлдэхүүн хэсэг										
Өтгөн дар	X	X	X	X	X		X	X	X	X
Цэвэрлэх байгууламжийн лаг	X	X	X	X	X	X	X	X	X	X
Аууин органик хог хаягдал	X	X	X	X	X					
Аууин органик бус хог хаягдал						X	X	X	X	
ХАА-н хог хаягдал (үр тарианы үлдэгдэл)	X	X	X	X	X		X	X	X	
Цэцэрлэгжүүлэлтийн хог хаягдал						X		X		
Маалын бүүд	X	X	X	X	X			X	X	X
Зинэзлгийн хог хаягдал	X	X	X	X	X		X	X	X	X
Үйлдвэрийн хог хаягдал						X	X	X	X	X
Мал нядалгааны газрын хог хаягдал	X	X	X	X	X		X			X
Барилгын хог хаягдал								X		X

Жич: үйлдвэрийн хаягдал угстай холбоотой эрсдэл харилцан адилгүй байж болно. Тухайлбал, зарим үйлдвэрийн хог хаягдал эмгэг төрөгч бичил биетэн болон химийн бодисоор бохирддог дусон байж болно. Үйлдвэрийн хог хаягдал дэх химийн бохирдуулалчийн талаар Тһопрсон нарын (2007) номоос харна уу.

ЧИГЛҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ 2.5

Биологийн аюулт хүчин зүйлийн талаарх мэдээллийг цуглуулах нь

- ДЭМБ-ын 2006 оны удирдамжид **нян, вирус, эгэл биетний** бохирдлыг хянах арга хэмжээг тодорхойлохдоо тэдгээрийн төрөл, зүйлийг харгалаан үзээгүй болно. Ялгагдсаар бохирлогдсон хог хаягдал дах эмгэг төрөгчийн агууламж, цэвэрлэлтийн үр дүнг тооцох чухал үзүүлэлт бол гэдэсний савханцар [*Escherichia coli*]-ын түвшрүүлэг юм.
 - **Цагаан хорхойн** халдварын гаралт, давтамж нь тухайн газрын онцлогоос хамаарч ялгаатай байдаг. Бохир доторх цагаан хорхойн төрөл, өндөгний агууламжаас хамаарч хэрэгжүүлэх хяналтын арга хэмжээ өөр өөр байх тул тухайн нутаг дэвсгэрт ямар төрлийн цагаан хорхойн халдвар нутагтшмал байдлаар гарч байгааг судлах шаардлагатай.
 - Бохирьг усны аж ахуйд ашиглаж байгаа тохиолдолд трематод ба шистосомын халдвар хүнсээр дамжихаас сэргийлэхэд онцгой анхаарах нь зүйтэй. Учир нь, эдгээр халдвар нь загас, усны ургамлаар дамжин тархдаг байна (ДЭМБ-ын 2006 оны удирдамжийн 3 дугаар ботвиос харна уу).
 - **Вектороор дамжих өвчин** нь ариун цэврийн системтэй 2 замаар холбогддог. Нэгдүгээрт, бохирын системийн тогтонги хэсэг, цэвэрлэх байгууламжийн сан зэрэг нь өвчин дамжуулагч шавж үржих орчин нөхцөл болж өгдөг. Энэ нь ажилчид, ойр орчны оршин суугчдын тав тухыг алдагдуулахаас гадна вектороор дамжих халдварт өвчний эрсдэлийг нэмэгдүүлдэг байна. Хоёрдугаарт, ялаа бохир дотор үржихээс гадна түүгээр хооллож, улмаар эмгэг төрөгч бичил биетнийг механикаар зөөвөрлөж, хүн, хүнсний зүйлийг бохирдуулдаг.
 - АЦБАСТ-ний баг тухайн нутаг дэвсгэрт ямар вектор нийлгийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал болж, ямар өвчин зөөвөрлөн тарааж болохыг тогтоох нь зүйтэй.
 - **Мэдээний эх сурвалж**
- Тодорхой өвчин буюу эмгэг төрөгч бичил биетний талаар мэдээлэл олж авахад эрдэм шинжилгээ судалгааны ажлын тойм үнэлгээ хийх нь тус дөхөм болж чаддаг. Мөн эрүүл мэндийн эрх бүхий байгууллагууд (ж.нь, ЭМЯ)-аас мэдээлэл авч болох боловч албан ёсны статистик мэдээний чанар эрүүл мэндийн тандалтын тогтолцооноос хамаарах ба ихэнхдээ өвчний тархалтыг дутуу үнэлдэг болохыг анхаарах нь зүйтэй. Түүнчлэн ойр орчмын эрүүл мэндийн байгууллагын ажилчдаас мэдээлэл авч болно. Ер нь, мэдээний үнэн бодит байдлыг хангахын тулд аль болох олон эх сурвалжаас мэдээ авах нь чухал юм.

ЧИГЛҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ 2.6

Химийн аюулт хүчин зүйлийн талаарх мэдээллийг цуглуулах нь

- **Химийн бохирдуулагч** нь эрүүл мэндэд хор уршиг учруулах аюулт хүчин зүйл болдог бөгөөд хяналтад авахад бэрхшээлтэй байдаг. Химийн хорт бодис [ж.нь, шавжгүйтэлийн бодис, эм] болон хүнд метал гадаад орчинд тэсвэртэй, ус, хөрс, амьтанд хуримтлагдах чадвартай байна. Бохирын найрлагыг тодорхойлоход [Модуль 2.2] химийн хорт бодис буюу хүнд метал агуулагдаж болохгүй байвал химийн бохирдуулагчийн төрөл, боломжтой бол - түвшрүүлгийг тодорхойлох шаардлагатай.

Тухайн цэвэрлэсэн бохир усыг ашиглах нь тохиромжтой эсэхийг үнэлэхийн тулд хөрсөн дэх химийн бодисын агууламжийг харгалзах нь чухал юм. Хөрсөн дэх химийн бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээг Хавсралт 3-аас харна уу.

Химийн бодисын талаар нэмэлт мэдээллийг Модуль 5 [Чиглүүлэх зөвлөмж 5.5]-аас харна уу.

- **Мэдээний эх сурвалж:**

Бохир буюу гол мөрний усан дах химийн бодисын агууламжийн талаарх мэдээллийг юуны өмнө байгаль орчны эрх бүхий байгууллагууд [ж.нь, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр]-аас олж авахыг зоринo.

Түнчлэн цэвэрлэх байгууламжуудын химийн бохирдлыг хянах үйл ажиллагааны тайлангаас тоо мэдээ олж авч болно. Үйлдвэрийн хаягдал усны хувьд үйлдвэрлэлийн асуудал эрхэлсэн байгууллага, лавлагаа материал [ж.нь Thompson ба бусад, 2007]-аас мэдээлэл авна.

Мэдээ байхгүй тохиолдолд бохирын бүрэлдэхүүн хэсэг буюу орчноос сорьц цуглуулж, шинжилгээ хийх шаардлагатай байж болно.

ЧИГЛҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ 2.7

Физикийн аюулт хүчин зүйлийн талаарх мэдээллийг цуглуулах нь

Хурц үзвэртэй зүйл [хагарсан шил, сахлын хутга, тариур г.м.], **органик бус материал, эвгүй үнэр** зэрэг нь физикийн аюулт хүчин зүйлд хамаарна. Эрүүл мэндийн эрсдэлийг хянах ямар арга хэмжээ хэрэгжүүлэх нь физикийн аюулт хүчин зүйл байгаа эсэхээс шалтгаалах тул Бохирын бүтэц, найрлагыг сайтар судлах нь чухал юм.

Шаардлагатай тохиолдолд мэдээний нэмэлт эх сурвалжаас мэдээлэл авч болно.


АРГА ХЭРЭГСЭЛ 2.1

Өртөмтгий бүлгийн ангилал

Тэмдэглэгээ	Бүлэг	Товч тайлбар
A	Ажилчид	Ариун цэврийн тоног төхөөрөмж, хэрэгслийг ажиллуулах, цэвэрлэх, засварлах үйл ажиллагааг хармуцсан хүн
T	Тариаланчид	Бүтээгдэхүүн (цэвэрлээгүй, бүрэн буюу хагас цэвэрлэсэн бохир ус, биологийн халуу хог хаягдал, өгтөн лаг г.м.)-ийг ашиглаж буй хүн
O	Орон нутгийн оршин суугчид	Ариун цэврийн байгууламж, бохир ус ашигладаг тариалангийн талбайн ойр буюу урсгал дагуу амьдарч, дам байдлаар өртөх боломжтой хүн
X	Хэрэглэгчид	Бохир ус ашиглан бий болгосон бүтээгдэхүүн (хүнсний ногоо, загас, бордоо г.м.)-ийг хэрэглэж буй хүн


ЖИШЭЭ 2.1

Хатуу хог хаягдал ба өтгөн лагийг бордоо болгон ашиглах



ЖИШЭЭ 2.2



Бохирын олон эх сурвалжийн зураглал, Португал



Португалд АЦБАБТ-г хэрэглэжүүлсэн туршлага


ЖИШЭЭ 2.2 (ҮРГЭЛЖЛЭЛ)

Бохирын олон эх үүсвэрийн зураглал, Португал



ЖИШЭЭ 2.3

Өтгөн лагийг боловсруулах систем, Филиппин



ЖИШЭЭ 2.4

Бохир усыг ХАА-д ашиглахтай холбоотой аюулт хүчин зүйлийг тодорхойлох нь, Перу

Сонирхыг эх үүсвэрээс нь дараах байдлаар ангилсан үүнд:

- Амьтан бохир
- Амьтн бохир ус
- Хүнийг агаар
- Холын кетүү хэл хэргэдэл
- Бослоор, шавьжтүгтэйлийн бохир агуулсан тармаглангийн талбайгаас урсган ус
- Уурхайн хэргэдэл
- Уулдээрхийн хэргэдэл

Ийнхүү ангилсан бохирын төрөл тус бүрийн хувьд биологийн, химийн, физикийн аюулт хүчин зүйл, тэдгээрийн улирал буюу хэвийн бүс үзэгдлээс шалтгаалж хувьсан өөрчлөгддөг байдлыг тодорхойлсон. Зарим бохир (ж.нь, уурхайн болон үйлдвэрийн) химийн аюулт хүчин зүйл, харин зарим нь нэнгийн аюулт хүчин зүйлтэй холбоотой байв.

Ус, хөрс, үр тариагаас сорьц авч, шинжилж баталгаажуулсан болно.

Жишээ 1.5 баг 1.11-с суурь мэдээллийг харна уу

ЖИШЭЭ 2.5

Системийн зураглалыг баталгаажуулах арга, Кампала, Уганда

Тайлан бүртгэл, талбарын ажиглагчанд тулгуурлан системийн зураглалыг гаргасан байна. Анхны зураглалыг гаргахад шууд оролцоогүй хараат бус шинжээчдээр нэмэлт мэдээлэл цуглуулж, зураглалыг баталгаажуулсан. Шугам сүлжээний мэдээний баримтжуулалтыг шугам сүлжээ харууцдаггүй ажигнуудаар хийлгэсэнээр нууцлалыг хангаж, мэдээ цуглуулах, дүн шинжилгээ хийх шатанд системт алдаа гарахаас сэргийлж чадсан. Шинжээчид талбарт ажиглахдаа операторуудын үйл ажиллагаанд ажиглалт хийх замаар мэдээ цуглуулсан байна.

Мэдээ цуглуулахын өмнө болон дараа нь мэдээ цуглуулах арга хэрэгсэл, үр дүнгийн талаар мэргэжлийн багудтай хэлэлцүүлэг зохион байгуулж, гарсан саналуудыг тусгасан байна.



МОДУЛЬ 3

АЮУЛТ ҮЗЭГДЛИЙГ
ТОДОРХОЙЛОХ, ХЯНАЛТЫН
АРГА ХЭМЖЭЭ БОЛОН
ӨРТӨЛГИЙН ЭРСДЭЛИЙГ
ҮНЭЛЭХ НЬ

МОДУЛЬ 3

АЮУЛТ ҮЗЭГДЛИЙГ ТОДОРХОЙЛОХ, ХЯНАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ БОЛОН ӨРТӨЛТИЙН ЭРСДЭЛГИЙГ ҮНЭЛЭХ НЬ

МОДУЛЬ

- 3.1 Аюулт хүчин зүйл, аюулт үзэгдлийг тодорхойлох нь
- 3.2 Өртөмтгий бүлэг, өртөх замыг нарийвчлан тодорхойлох нь
- 3.3 Одоо байгаа хяналтын арга хэмжээг тодорхойлох, үнэлэх нь
- 3.4 Өртөлтийн эрсдэлийг үнэлэх, эрэмбэлэх нь

ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ ҮР ДҮН

- Аюулт хүчин зүйлийн жагсаалт, аюулт үзэгдэл, өртөмтгий бүлэг, өртөх зам, одоо байгаа хяналтын арга хэмжээ болон тэдгээрийн үр дүнг тоймлон харуулсан эрсдэлийн үнэлгээний хүснэгт гаргасан байна
- Системийг сайжруулах арга хэмжээний чиглэлийг тогтоох аюулт үзэгдлийн эрэмбэлсэн жагсаалт гарсан байна

Тойм

Ариун цэврийн бүх системийн эцсийн зорилго нь нийгмийн эрүүл мэндийг хамгаалахад оршдог. Модуль 3-ийн үр дүнд үндэслэн цаашдын хяналтын арга хэмжээ болон хөрөнгө оруулалтыг эрүүл мэндэд хамгийн их эрсдэл учруулж болзошгүй асуудлыг шийдвэрлэхэд нэн тэргүүнд чиглүүлдэг байна.

Модуль 3.1 ба 3.2 нь ариун цэврийн системийн ажиглалгааны үед буюу түүний бүтээгдэхүүнийг ашиглах явцад хэн, хэрхэн аюулт хүчин зүйлд өртөх эрсдэлтэйг нарийвчлан тогтооно.

Модуль 3.3 нь одоогийн систем эрсдэлт бүлгийг хэр сайн хамгаалж чадаж байгааг тодорхойлдог.

Модуль 3.4 нь эрсдэлийг эрэмбэлж, нэн тэргүүнд анхаарал хандуулах эрсдэлийг тодорхойлох аргачлалыг танилцуулна.

Модуль 3-ын төгсгөлд АЦБАБТ-ний баг хамгийн өндөр эрсдэлтэй аюулт үзэгдлүүдийг тодорхойлсон байна. Аюулт үзэгдлийг хяналтад авах арга хэмжээ хэрэгжүүлээгүй эсхүл хэрэгжүүлсэн ч үр дүнгүй учраас эрсдэл учирч байвал Модуль 4-ийн хүрээнд эдгээр эрсдэлийг бууруулах сайжруулалтын төлөвлөгөө боловсруулна. Харин хэрэгжүүлсэн арга хэмжээ нь аюулт үзэгдлийн эрсдэлийг хяналтандаа авч чадаж байвал багийн зүгээс ямар нэгэн доголдол гарч байгаа эсэхийг тогтмол хянахад хангалттай юм (Модуль 5-с харна уу).

Чиглүүлэх зөвлөмж 3.1-д Модуль 3-ийн хүрээнд анхаарах зарим зарчмыг толилуулсан байна. АЦБАБТ-ний баг Ньютауны АЦБАБТ-ний жишээнд ашигласан үр дүнг бүртгэх загварыг өөриймшүүлэн авах нь зүйтэй ("Жишээ: Ньютауны АЦБАБТ"-с харна уу).

3.1 Аюулт хүчин зүйл, аюулт үзэгдлийг тодорхойлох нь

Аюулт хүчин зүйл болон үзэгдлийг тодорхойлох нь цаашид эрсдэлийг үнэлэхэд тус дөхөм болдог. Жишээ 3.1-д ариун цэврийн систем дэх эрүүл мэндэд хор уршиг учруулж болзошгүй түгээмэл аюулт хүчин зүйлсийг харуулсан болно. Юуны өмнө аюулт хүчин зүйл ба аюулт үзэгдэл хоёрын ялгааг ойлгох нь чухал юм (Чиглүүлэх зөвлөмж 3.2-с харна уу).

Модуль 2-ийн хүрээнд зураглалыг нь гаргасан ариун цэврийн системийн алхам тус бүрт байгаа аюулт хүчин зүйл болон холбогдох аюулт үзэгдлийг тодорхойлно. Ингэхдээ дараах зүйлийг анхаарна. Үүнд:

- Системийн хэвийн үйл ажиллагаатай холбоотой аюулт үзэгдэл (ж.нь, гэмтсэн дэд бүтэц, системийн хэт ачаалал, засвар үйлчилгээний доголдол, эрсдэлт зан үйл)
- Систем доголдсон буюу осол гарсангай холбоотой аюулт үзэгдэл (ж.нь, Цэвэрлэх ажиллагаа бүрэн буюу хэсэгчлэн алдагдсан, цахилгааны тасалдал, тоног төхөөрөмжийн эвдрэл, операторын алдаа)
- Улирал буюу цаг уурын хүчин зүйлтэй холбоотой аюулт үзэгдэл (ж.нь, үер, ган, газар тариалан эрхлэлтийн улирал)
- Дам аюулт хүчин зүйл ба/буюу аюулт үзэгдэл (ж.нь, ариун цэврийн системтэй шууд холбоогүй хүмүүс шавж, мэргэч зэрэг вектороор дамжин аюулт хүчин зүйлд өртөх)
- Хуримтлагддаг аюулт хүчин зүйл (ж.нь, химийн бодис хөрсөнд хуримтлагдах).

Өөр өөр нөхцөл байдал (ж.нь, системийн хэвийн ажиллагааны нөхцөл болон үерийн нөхцөл)-д бий болсон ижил төстэй аюулт үзэгдлийг тус тусд нь авч үзэх нь зүйтэй (Жишээ 3.2-ыг харна уу). Учир нь, өөр өөр нөхцөл байдалд ижил төстэй аюулт үзэгдлийн эрсдэлийн түвшин ялгаатай байж болно.

Аюулт үзэгдлийг тодорхойлох явцад үүнтэй холбоотой бодлого, зохицуулалтын сул талуудыг авч үзэх шаардлагатай байж болно. Тухайлбал, үйлдвэрийн хаягдал усыг Цэвэрлэхгүйгээр бохирын системд шууд нийлүүлэх нь холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах үйл ажиллагаа дутмаг байгаатай холбоотой байж болно. Мөн эрүүл мэндийн эрсдэлийн зэрэгцээ орчинд үзүүлж буй гэж нөлөөг тодорхойлж болно.

Аюулт хүчин зүйлийг тодорхойлоходоо Модуль 2-ын хүрээнд цуглуулсан мэдээллийг ашиглахын сацуу Модуль 2.5-д толгилуулсантай төстэй арга хэрэгслийг ашиглан газар дээр нь ажиллаж мэдээлэл цуглуулж болно.

3.2 Өртөмтгий бүлэг, өртөх замыг нарийвчлан тодорхойлох нь

Өртөмтгий бүлэг

Модуль 2.3-ын хүрээнд ерөнхий байдлаар ангилан тодорхойлсон өртөмтгий бүлгүүдийг задалж, нарийвчлан тодорхойлно.

Бохирын цэвэрлэгч зэрэг зарим өртөмтгий бүлгийг тодорхойлоход харьцангуй хялбар байдаг бол зарим (ж.нь, ойр орчмын гүний ус хэрэглэдэг хүн ам, улирлын чанартай тармалангийн талбайд ажилладаг ажилчид, албан бус оршин суугчид, шилжин суурьшигчид)-ыг нь тодорхойлоход төвөгтэй байж болно. Аюулт үзэгдэлтэй холбоотой

эрсдэлд хүйс, нас, нийгмийн байдал зэрэг хүн амзүйн үзүүлэлтүүд нөлөөлөхөөр байвал тэдгээрийн онцлогийг харгалзан үзнэ.

Модуль 3.1-ийн хүрээнд тодорхойлсон аюулт үзэгдэл тус бүрт өртөж болзошгүй хүн амын бүлгүүдийг судлан тогтооно. Ингэхдээ Арга хэрэгсэл 3.1-ийг ашиглан өртөмтгий бүлэг тус бүрийг тодорхойлно.

Өртөх зам

Аюулт үзэгдэл тархан тэлэх зам болон өртөмтгий бүлэг өртөх замыг судлан тогтооно. Энэ нь эрсдэлийг ойлгох, хяналтын зохих арга хэмжээг тодорхойлоход тус дөхөм болно.

Ялгадастай холбоотой эмгэг төрөгч бичил биетнүүд тархах зам, тэдгээрт өртөх зам нь анхдагч (шууд хавьтал буюу агаар дуслаар богино зайд тархах) буюу хоёрдогч (бохирлогдсон хүнсээр дамжин тархах) байж болно. Чиглүүлэх зөвлөмж 3.3-г АЦБАБТ-д харгалзан үзэх шаардлагатай түгээмэл өртөх замын талаар нэмэлт мэдээлэл өгсөн болно.

Ялгадастай холбоотой өвчин тархах зам, түүнд өртөх зам нь өртөлтийн цэгүүдтэй шууд холбоотой, харин халдварт өртөх эрсдэл нь эзэн биеийн хүчин зүйлээс хамаардаг. АЦБАБТ-ний хүрээнд өвчний эрсдэлийг бууруулахын тулд эдгээр харилцаа хамаарлыг ойлгох нь чухал юм.

3.3 Одоо байгаа хяналтын арга хэмжээг тодорхойлох, үнэлэх нь

Модуль 3.1-ийн хүрээнд тодорхойлсон аюулт үзэгдэл тус бүрийн хувьд түүний эрсдэлийг бууруулах ямар хяналтын арга хэмжээ нэгэнт хэрэгжүүлээд байгааг тодорхойлно. Улмаар уг хяналтын арга хэмжээ нь аюулт үзэгдлийн эрсдэлийг бууруулахад хэр үр дүнтэй болохыг

ТОГТООНО – хяналтын арга хэмжээний талаар нэмэлт мэдээллийг Чиглүүлэх зөвлөмж 3.4 болон Хавсралт 1-с харна уу.

Логарифм бууралт (энэ нь хяналтын арга хэмжээний үр дүнтэй эсэхийн үзүүлэлт болдог)-ын тухай ойлголтыг эрсдэлийг тооцох судалгаа шинжилгээ, 2006 оны ДЭМБ-ын удирдамж болон энэхүү гарын авлагад ашигласан болно. Логарифм бууралтын талаар ерөнхий ойлголт авахын тулд Нэр томъёоны тайлбар, Чиглүүлэх зөвлөмж 3.5 ба 4.1-ийг харна уу.

Хяналтын арга хэмжээ хэр үр дүнтэй болохыг үнэлэхдээ дараах зүйлийг харгалзана. Үнд:

1. Хяналтын арга хэмжээ хэр үр дүнтэй байж болох вэ (уг арга хэмжээ цаг үргэлж зохих ёсоор ажиллаж байсан гэж үзвэл): үүнийг хяналтын арга хэмжээний баталгаажуулалт гэнэ (Чиглүүлэх зөвлөмж 3.6-с харна уу).
2. Хяналтын арга хэмжээ бодит амьдрал дээр хэр үр дүнтэй байгаа вэ (бодит нөхцөл байдал, дүрмийн мөрдөлт, бодит практик ажиллагаа зэргийг харгалзан үзвэл).

Хяналтын арга хэмжээ хэр үр дүнтэй байж болох вэ гэдгийг техникийн нарийвчилсан үнэлгээ буюу энэ чиглэлээр хийгдсэн судалгаа шинжилгээний ажил дээр тулгуурлан үнэлэх боломжтой. Хавсралт 1 болон 2006 оны ДЭМБ-ын удирдамж (2, 3 ба 4 дүгээр ботгийн 5 дугаар бүлэг)-д түгээмэл хэрэглэдэг хяналтын арга хэмжээний үр дүнтгийн талаарх мэдээллийг тоймилосон болно. Урт хугацааны туршид цуглуулсан үйл ажиллагааны мэдээнд тулгуурлан гүйцэтгэлийн хүчин чадлын талаар тодорхой ойлголт авч болдог.

Зарим тохиолдолд байж болох ба бодит гүйцэтгэл ихээхэн ялгаатай байдаг. Тухайлбал, операторын алдаатай үйл ажиллагаа буюу хэт

ачааллаас шалтгаалж Цэвэрлэх байгууламж зориулалтын дагуу ажиллаж чадахгүй байж болно. Хувийн хамгаалах хэрэгслийн хэрэглээ зэрэг зарим хяналтын арга хэмжээний үр дүнтэй байдал хувь хүний зан үйлээс ихээхэн хамаардаг. Жишээ 3.3-д хяналтын арга хэмжээнд түгээмэл гардаг доголдолын талаар өгүүлсэн болно.

Хяналтын арга хэмжээний үр дүнт баталгаажуулахад АЦБАБТ-ний багийн туршлагатай гишүүд буюу бусад мэргэжилтнүүдийн дүгнэлтэд тулгуурлаж болно. Харин нэмэлт мэдээлэл бий болгогч эрсдэлийн үнэлгээг эргэн харж, шаардлагатай бол баталгаажуулалтыг тоо мэдээнд тулгуурлан илүү шинжлэх ухаанч байдлаар хийнэ.

3.4 Өртөлтийн эрсдэлийг үнэлэх, эрэмбэлэх нь

Модуль 3.1-ийн хүрээнд ноцтой болон хор хөнөөл багатай аюулт үзэгдлүүдийг тодорхойлно. Модуль 3.4-ийн хүрээнд энэхүү тодорхойлсон аюулт үзэгдэл тус бүртэй холбоотой эрсдэлийг үнэлж, АЦБАБТ-ний багт хэрэгжүүлэх арга хэмжээний тэргүүлэх чиглэлийг тогтоох боломжийг олгоно.

АЦБАБТ-ний хүрээнд эрсдэлийн үнэлгээний өөр өөр аргуудыг ашигладаг. Үнд:

1. Багаар хийж гүйцэтгэх эрсдэлийн чанарын үнэлгээ
2. Магадлал, ноцтой байдлын матрицыг ашиглан хийх эрсдэлийн хагас тоон үнэлгээ
3. Тоон үнэлгээний арга (ж.нь, микробын эрсдэлийн тоон үнэлгээ)

Эрсдэлийн чанарын буюу хагас тоон үнэлгээг АЦБАБТ-ний багийн хэд хэдэн гишүүд тус тусдаа эсхүл багаар хийж гүйцэтгэх шаардлагатай. Ингэснээр эрсдэлийн үнэлгээний бодит байдлыг сайжруулах, нэгдсэн үнэлгээг зөвшилцөн гаргах боломжтой болдог.



Тоон үнэлгээг мэргэжлийн хүмүүс хийх ба энэхүү гарын авлага зориулагдсан АЦБАБТ-ний багийн ихэнх гишүүдийн хувьд хамааралгүй юм. Эрсдэлийн үнэлгээг хийсний дараа үр дүн нь бодит байдалд нийцэж байгаа эсэхийг дахин хянаж, эргэлзээгүй тохиолдолд мэдээлэл болон үнэлгээг дахин нягтлах нь зүйтэй.

Багаар хийж гүйцэтгэх эрсдэлийн чанарын үнэлгээ

Эрсдэлийн чанарын үнэлгээг хийхдээ АЦБАБТ-ний багийн гишүүд аюулт үзэгдэл тус бүрийг өндөр, дунд зэргийн, бага буюу тодорхойгүй эрсдэлтэй гэж ангилдаг. Эрсдэлийн түвшнийг хэрхэн тодорхойлохыг багийн гишүүд өөрсдөө шийдэж болохоос гадна Арга хэрэгсэл 3.2-т тогилдуулсан тодорхойлолтыг ашиглаж болно. Ямар ч тодорхойлолт ашигласан гэсэн нийгмийн эрүүл мэндийг хамгаалах үндсэн зарчмаас хазайж болохгүй.

АЦБАБТ-г анх боловсруулахад эрсдэлийн чанарын үнэлгээний аргыг ашигласан бол төлөвлөгөөний дараагийн тойм үнэлгээнд хасаг тоон үнэлгээний аргыг ашиглахаар тогтоож болно. Үнэлгээний ямар аргыг хэрэглэх талаар гаргасан шийдвэрийн үндэслэлийг баримтжуулах нь чухал юм.

Эрсдэлийн хагас тоон үнэлгээ

Эрсдэлийн хагас тоон үнэлгээ бол чанарын үнэлгээтэй харьцуулахад илүү нарийвчилсан арга юм. Эрхзүйн зохицуулалтын орчин тодорхой, АЦБАБТ-ний баг НАССР буюу УАБТ-ийн аргазүйтэй танил эсхүл өмнө нь АЦБАБТ боловсруулж байсан туршлагатай бол энэхүү аргыг ашиглах нь тохиромжтой.

Хагас тоон үнэлгээг хийхдээ АЦБАБТ-ний баг эрсдэлийн матриц ашиглан аюулт үзэгдэл тус бүрийн магадлал, ноцтой байдлыг үнэлж, эрсдэлийн нэгдсэн оноо гаргаж авна. Эрсдэлийн матрицыг Арга

хэрэгсэл 3.4-д харуулсан болно. Энэхүү үнэлгээг хийхдээ магадлал (ж.нь, магадлалтай, болзошгүй, магадлал багатай) ба ноцтой байдал (ж.нь, их, бага)-ын нэгдсэн тодорхойлолтыг ашиглана (Арга хэрэгсэл 3.3-с харна уу). Ноцтой байдлыг үнэлэхдээ бохирын найрлага, түвшрүүлгийн (Модуль 2-т тодорхойлсон) зэрэгцээ үүнтэй холбоотой эрүүл мэндийн сөрөг үр дагаврын их, багыг харгалзана.

АЦБАБТ-ний баг тухайн систем болон газар нутгийн онцлогт тулгуурлан магадлал, ноцтой байдлын өөрийн тодорхойлолтыг гаргаж, ашиглаж болно. Тодорхойлолтонд эрүүл мэндэд үзүүлэх нөлөө, олон нийт буюу хэрэглэгчдийн ойлголтод үзүүлэх нөлөө зэргийг харгалзаж үзэх нь зүйтэй. Ямар ч тодорхойлолт ашигласан гэсэн нийгмийн эрүүл мэндийг хамгаалах үндсэн зарчмаас хазайж болохгүй.

Эрсдэлийн үнэлгээний хяналтын хуудсыг Чиглүүлэх зөвлөмж 3.7-д харуулсан байна. Эрсдэл хамгийн ихтэй аюулт үзэгдлүүдийг сонгож, тэдгээрийг хяналтад авах сайжруулалтын төлөвлөгөөг Модуль 4-ийн хүрээнд боловсруулна.

Өвчлөлийн динамик өөрчлөлт, өртсөн хүний тоо зэргийг харгалздаг эрсдэлийн үнэлгээний илүү боловсронгуй аргуудыг мөн ашиглаж болно.

Газар тариалангийн усалганд бохир ус ашиглахтай холбоотойгоор үүсэх нянгийн гаралтай эрүүл мэндийн эрсдэлийн тухай тойм мэдээллийг Хавсралт 2-т нэгтгэсэн байна. Энэхүү мэдээлэл нь ХАА-н зориулалтаар бохир ус ашиглахтай холбоотой аюулт үзэгдлийн ноцтой байдлыг үнэлэхэд тус дөхөм болно.

ЧИГЛҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ 3.1

Модуль 3-ийн хүрээнд анхаарах асуудлууд

Модуль 3-ийг хэрэгтжүүлэхэд АЦБАБТ-нийбагт дараах шаардлага тавигдана:

- Системийн бүрэлдэхүүн хэсгүүд онолын хувьд болон практик дээр хэрхэн ажилладаг талаар мэргэжлийн өндөр түвшний мэдлэгтэй байх
- Халдвар тархах замын талаар ойлголттой байх
- Юмс, үзэгдлийн цаад учрыг ухаж ойлгох хүсэл эрмэлзэлтэй байх:
 - Аюулт үзэгдэл хэрхэн эрүүл мэндэд нөлөө үзүүлж болох вэ?
 - Өмнө нь эрүүл мэндэд хэрхэн нөлөөлж байсан бэ?
 - Тухайн аюулт үзэгдэл байнга байдаг уу эсхүл зөвхөн тодорхой үйл явдалтай холбоотой юу?
 - Өмнө нь системд ямар доголдол гарч байсан бэ?
 - Цаашид юу доголдож болох вэ? зэрэг асуултуудад харуулахыг хичээнэ.

Модуль 3-ийг хэрэгжүүлэх явцад багийн гишүүдийн ойлголт улам бүр бэхжинэ.

Модуль 3.1 ба 3.4-ийг тусд нь тайлбарласан боловч бодит амьдрал дээр эдгээр нь давхцаж болно. Нэгээс нөгөө рүү эргэн буцаж сайжруулах шаардлага ч гарч болно (ж.нь, аюулт үзэгдэл, аюулт хүчин зүйлийг үнэлсний дараа өртөмтгий бүлэг, өртөх зам зэргийг нарийвчлан судалсны үндсэн дээр эхний үнэлгээг эргэн тодотгох шаардлагатай байж болно).

Хяналтын арга хэмжээний үр дүнтэй эсэхийг үнэлэхэд Модуль 4-т тайлбарласан зарим зүйлс тус дөхөм болдог.

ЧИГЛҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ 3.2

Аюулт хүчин зүйл ба аюулт үзэгдлийн ялгаа

Аюулт үзэгдэл гэдэг нь ариун цэврийн систем дэх аюулт хүчин зүйлд хүмүүс өртөх явдал юм. Бохир доторх эмгэг төрөгчийг аюулт хүчин зүйлийн жишээ болгон энэхүү хүчин зүйл хэд хэдэн аюулт үзэгдэлд хүргэж болохыг дараах хүснэгтэд тогилуулсан болно. Аюулт үзэгдэл тус бүр өөрийн гэсэн онцлог шалтгаантай учраас түүнийг хяналтад авах тус тусдаа арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагатай. Аюулт үзэгдэл тус бүрийн тухайд аюулт хүчин зүйл (ж.нь, бохир доторх эмгэг төрөгч)-д өртөх хүн амын бүлэг мөн ялгаатай байж болно.

Аюулт үзэгдлийг тодорхойлохдоо ямар нөхцөлд, ямар шалтгааны улмаас энэхүү үзэгдэл бий болдгийг тогтооно.

Аюулт хүчин зүйл	Аюулт үзэгдэл	Аюулт үзэгдлийн давтамж, ноцтой байдалд нөлөөлөх шалтгаан	Аюулт үзэгдлийг хянах арга хэмжээ	Аюулт хүчин зүйлд өртөмтгий хүн ам
Бохир доторх эмгэг төрөгч	Их бороо орсны улмаас бохир хальж, бохирт өртөх	<ul style="list-style-type: none"> Бороо орсон үед дамжуулах систем нэмэлт ачаалал даахааргүй бага хэмжээтэй Хальсан бохирт хяналт тавьдаггүй 	<ul style="list-style-type: none"> Халиглын давтамжийг тогтоох стандарт боловсруулах Борсны улирал эхлэхээс өмнө бохирын системд тогтмол засвар үйлчилгээ хийх 	Бохирын системийн ойр орчим буюу халилт үүссэн хэсгээс доош амьдардаг хүмүүс
	Бохирын шахуургад засвар хийх явцад бохирт өртөх	<ul style="list-style-type: none"> Шахуурга хуучирч муудсан буюу ачааллаа дийлэхгүйн улмаас ойр ойрхон бөглөрдөг Ажилчдын мэдлэг, ур чадвар дутмаг, тоног төхөөрөмжийн хангамж муу Засвар үйлчилгээний үед ашиглах нөөц шугам сүлжээ байхгүй 	<ul style="list-style-type: none"> Шахуурга зөвдрэхээс сэргийлэх зорилгоор төлөвлөгөөт засвар үйлчилгээ хийх Шахуурлын төрөл, хаалгыг зөв сонгох Ажилчдыг хувийн хамгаалах хэрэгслээр хангах Стандарт ажиллагааны удирдамж боловсруулах, хангах Шахуурлын станцийн стандарт боловсруулах 	Бохирын шахуургын засвар үйлчилгээ харилцсан ажилчинд

ЧИГЛҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ 3.3

АЦБАБТ-Д АНХААРАХ ТҮГЭЭМЭЛ ӨРТӨХ ЗАМ

Өртөх зам	Тайлбар
Бохир ус / ялгадастай харьцсаны дараа бохирдлыг залгих	Ялгадас (шээс, өтөн)-тай харьцсан гар, эд зүйлээс бохир ам руу орох, тухайлбал бохирдсон шороо гараар дамжин аманда орох (ж нь, газар тариаланчид, хүүхдүүд)
Бохирлогдсон гүний буюу гадаргуйн ус уух	Бохир ус, ялгадсаар бохирлогдсон гадаргуйн буюу гүний ус уух, үүнд мөн усан сангийн усыг санамсаргүй залгих
Бохирлогдсон бүтээг дэхүүн (хүнсний ногоо) идэх	Бохир усаар усалсан буюу түүнээс гаргаж авсан бордлогдоор бордсон газар дээр ургуулсан ургамал (ж нь, шандай) идэх
Ялгадас, бохир усгай арьсаар хүрэлцэх	Бохир ус, ялгадастай хол буюу биеийн бусад хэсгийн арьсаар хүрэлцэх үед эмгэг төрөгч (ж нь, аккилостом) арьсаар дамжин биед нэвтрэх
Вектор (ялаа, шүүмүүл)-оор дамжих	Ялаа бохирдуулагчийг хүн буюу хүнсний бүтээг дэхүүн рүү механикаар зөвөөрлөх, эмгэг төрөгчийг биедээ агуулсан шүүмүүл, бусад шавьж хүнийг хазардаа тараах
Агаар дусал, тоосонцор амьсгалын замаар нэвтрэх	Ариун цэврийн техник хэрэгслээс ялгарч буй эмгэг төрөгч агуулсан шингэний бичил дусал буюу тоосонцор амьсгалын замаар хүний биед нэвтрэх

Жич: Ялгадастай холбоотой эмгэг төрөгч бичил биетэн тархах зам, гүнд ордох зам нь анхдагч (ялгадас буюу түүгээр бохирлогдсон гадаргуитай шууд хүрэлцэх, хүнээс хүнд дамжих эсрэг хувийн ариун цэвэр мугтан холбоотой) буюу хоёрдогч (бохирлогдсон хүнс, вектороор дамжин тархах) байж болно. Түүнчлэн агаар дуслын замаар халдвар тархах болно, тухайлбал, бохир усаар усалга хийх үед.

Эх сурвалж: Stenstam ба бусад (2011)

ЧИГЛҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ 3.4

Хяналтын арга хэмжээ

Хяналтын арга хэмжээ гэдэг нь ариун цэвэртэй холбоотой аюулт хүчин зүйлээс сэргийлэх, түүнийг арилгах, зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл багасгахад чиглэсэн аливаа арга хэмжээ, үйл ажиллагаа буюу хаалт юм. Хаалт нь бохирыг дамжуулах, тээвэрлэх, цэвэрлэх явцад эмгэг төрөгчийн тоошилыг эрс бууруулдаг. Олон давхар хаалт ашиглах (ө.х. аюулт хүчин зүйлийн эсрэг нэгээс олон хяналтын арга хэмжээ хэрэгжүүлэх)-ыг зөвлөмж болгодог.

Хаалт	Жишээ
Цэвэрлэлтийн	<ul style="list-style-type: none"> • Биет бүтэц (ж.нь, тундасжуулах цистерн) • Нянгийн үйл явц (ж.нь, идэвхжүүлсэн лаг) • Шингээлт (ж.нь, хиймэл намгархуу газар) • Биологийн идэвхгүйжүүлэлт (ж.нь, бордоо хийх) • Химийн идэвхгүйжүүлэлт (ж.нь, лагийг хагааж, халдваргүйжүүлэх)
Цэвэрлэлтийн бус	<ul style="list-style-type: none"> • Үр тарианы сонголт • Усжуулалтын төрөл • Бохир ус ашигласнаас хойш үр тариаг хэрэглэх хүртэлх хадгалалтын наад захын хугацаа • Завсрын эзэн ба векторын хяналт • Дархлаажуулалт ба урьдчилан сэргийлэх хими эмчилгээ
Техникийн бус (зан үйлийн)	<ul style="list-style-type: none"> • Хувийн хамгаалах хэрэгсэл ашиглах • Цэвэрлэлтийн болон ашиглалтын хэсгүүдэд нэвтрэхийг хязгаарлах • Үр тариаг халдваргүйжүүлэх, угаах, чанаж хүнсэндээ хэрэглэх <p>Жич: Зан үйлийн хяналтын арга хэмжээг цэвэрлэлтийн болон цэвэрлэлтийн бус арга хэмжээтэй хослуулан хэрэгжүүлнэ. Зан үйл нь хувь хүний онцлог (ж.нь, айдас, зуршил), саад бэрхшээл (ж.нь, үнэ, цагийн боломж, сонирхол), нийгэм-соёлын үнэт зүйлээс шалтгаалдаг бөгөөд эрүүл мэнд, ариун цэврийг дэмжих нөлөөллийн үйл ажиллагаагаар хэвшүүлэх боломжтой.</p>

Эх сурвалж: Stenslipn ба бусад (2011)

Ариун цэврийн системд олон төрлийн аюулт хүчин зүйлийн эсрэг хаалтуудыг хийж өгнө. Өөрөөр хэлбэл, олон давхар хаалт ашиглахыг зөвлөмж болгодог. Ингэснээр ариун цэврийн сайн систем нь хүний эрүүл мэндэд учрах эрсдэлийг бууруулж чаддаг.

Бохирын бүтээгдэхүүнийг ашиглаж байгаа нөхцөлд (ж.нь, ХАА буюу усны аж ахуйд) өртөх зам, халдвар тархах замыг ойлгох нь хяналтын арга хэмжээний үр дүнтэй байдлыг үнэлэхэд чухал ач холбогдолтой юм. Тухайлбал, хяналтын арга хэмжээ нь хэт өндөр зардалтай, нийгмийн зүгээс хүлээн зөвшөөрөгдөхгүй, практикт ашиглахад зохимжгүй байвал техник ажиглаганы хувьд сайн байсан ч үр дүнгүйд тооцогдож болно. Түүнчлэн өртөх замыг ойлгох нь тухайн аюулт үзэгдлийг хяналтад авах арга хэмжээний үр дүнг тодорхойлоход тус дөхөм болдог. Тухайлбал, амьсгалын замаар хүний биед нэвтэрдэг аюулт хүчин зүйлийн хувьд арьсыг хамгаалах бээлий зэрэг хэрэгсэл үр дүнгүй байна.

Хяналтын зарим арга хэмжээний үр дүнгийн талаарх мэдээллийг Хавсралт 1-д нэгтгэн тоймлосон болно. Мөн “Жишээ: Ньютауны АЦБАБТ”-д холбогдох зарим асуудлыг тайлбарласан байна.

ЧИГЛҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ 3.5

Аюулт хүчин зүйлийг бууруулах үзэл баримтлалыг ойлгоход тус дөхөм болох тайлбар

АЦБАБТ-ний баг хяналтын арга хэмжээний үр дүнтэй эсэхийг үнэлэх зорилгоор судалгаа шинжилгээний ажил, бусад нийтлэл (ж.нь, 2006 оны ДЭМБ-ын удирдамж)-тэй танилцах явцад энэхүү мэдээлэл тус дөхөм болно. Ус хангамжийн салбарт усны цэвэрлэлтийн үр дүнтэй байдлыг үнэлэх зорилгоор заагуур нян (ж.нь, *E. coli*) ашиглах үзэл баримтлалыг 19 дүгээр зууны төгсгөлд боловсруулсан билээ. Усанд энэхүү заагуур нян илрэх нь ус ялгагдсаар бохирлогдсон ба бусад эмгэг төрөгчөөр бохирлогдсон байж болзошгүй гэсэн дохио болдог. Харин заагуур нян илрээгүй бол ус эмгэг төрөгч бусад нянгаар бохирлогдсон байх магадлал бараг байхгүй гэж үздэг.

Бохир усны хувьд заагуур нянг ашиглан цэвэрлэлтийн үр дүнд бохирдол хэр буурч байгааг, өөрөөр хэлбэл бохир усанд өртөх буюу түүнийг ашиглахад учрах эрсдэл хэр багасч байгааг үнэлдэг байна. Үүний тулд логарифм бууралт гэсэн ойлголтыг ашигладаг.

Заагуур нянгийн тоошил буурах нь бусад эмгэг төрөгч нянгийн тоошил хэрхэн буурч байгааг дам байдлаар харуулдаг боловч эмгэг төрөгч вирус, этэл биетэн, цагаан хорхойн тоошил буурсан эсэхийг илэрхийлж чаддаггүй.

2006 оны ДЭМБ-ын удирдамжид вирусийн тоошилд тулгуурлаж эмгэг төрөгч бичил биетний тоошил буурсан эсэхийг хянах аргыг санал болгосон нь зөвхөн вирусийн төдийгүй нян болон этэл биетний хорогдлыг давхар илэрхийлж чаддаг давуу талтай байна. Цагаан хорхойн бохирдлыг түүний өндөгний тоошилоор хянахыг ДЭМБ-ын удирдамжид зөвлөмж болгожээ.

Чиглүүлэх зөвлөмж 4.1-с бохир усыг ХАА-д ашиглахтай холбоотой тавьдаг зорилтуудын талаар харна уу.

Эх сурвалж: Мага (2004) ба 2006 оны ДЭМБ-ын удирдамж (2 дугаар боть, хуудас 63-69).

ЧИГЛҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ 3.6

АЦБАБТ-ний хүрээнд хяналтын арга хэмжээг баталгаажуулах нь

Хяналтын арга хэмжээний баталгаажуулалт нь тухайн арга хэмжээ зорилтоо (ж.нь нянгийн тоошилыг бууруулах) хэрэгжүүлж чадаж байгааг нотолдог.

Ариун цэврийн системийн хувьд хяналтын арга хэмжээний баталгаажуулалтыг дараах байдлаар хийнэ:

- Системийн ачааллыг түүний техникийн тодорхойлолтод заасан хүчин чадалтай харьцуулах
- Цэвэрлэлтийн тодорхой үе шатны гүйцэтгэлийн талаар судалгаа шинжилгээний ажил, бусад нийтлэлээс мэдээлэл авах
- Хэвийн бус нөхцөлд гүйцэтгэл ямар байсан талаар түүхэн баримт мэдээллийг шалгах
- Техникийн бус (зан үйллийн) хяналтын арга хэмжээ эмгэг төрөгчийн хорогдолд хэрхэн нөлөөлдөг талаар 2006 оны ДЭМБ-ын удирдамжаас мэдээлэл авах (ж.нь, 2 дугаар ботийн Хүснэгт 4.3 ба 5 дугаар бүлэг, 3 дугаар ботийн 5 дугаар бүлэг, 4 дүгээр ботийн 5 дугаар бүлэг)

ЧИГЛҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ 3.7

Эрсдэлийн үнэлгээний хяналтын хуудас

- Эрсдэлийн үнэлгээний ямар арга ашиглахыг урьдчилж шийднэ
- Эрсдэлийн үнэлгээг аюулт үзэгдэлтэй холбон хийнэ
- Хяналтын арга хэмжээний доголдлыг өөрийн гэсэн магадлал, үр дагавар бүхий бие даасан аюулт үзэгдэл гэж авч үзнэ

АРГА ХЭРЭГСЭЛ 3.1

Өртөгтгий бүлэг, өртөх замыг нарийвчлан тодорхойлоход тус дөхөм болох асуултууд

Асуулт	Асуултын тайлбар	Жишээ
Өртөгтгий бүлэг	A1, X1, O1 г.м.-ээр тодорхойлно уу	O1 (орон нутгийн оршин суугчдын 1 дүгээр бүлэг)
Хэн?	Өртөгтгий бүлгийн энэ хүмүүс хэн болох, хэрхэн өртөж болох талаар мэдээлэл өгнө Нас, хүйс, нийгмийн байдалтай холбоотой өртөгтгий дэд бүлгүүд байвал тодруулна	A тосгоны оршин суугчид Улирлын чанартай жинс хураах ажил эрхэлдэг эмэгтэй ажилчид
Хэдүүгээ вэ?	Өртөгтгий бүлгийн хэдэн хүн байгааг тодорхой мэдэж байвал тоо заана, үгүй бол баримжаалсан тооцоо хийж, тооцолсон аргага тайлбарлана Шууд буюу дэм өртөх магадлалтай хүний тоо	A тосгоны 250 өрх (үүн дотроо 50 хүүхэд)
Хаана?	Ариун цэврийн системийн хаана, хэрхэн аюулт хүчин зүйлд өртөх боломжтойг тайлбарлана	A тосгоны голд сэлэх, эрэг дагуу амарч зугаалах
Юүнд өртөж байна?	Ямар бохирдуулагчид ямар нөхцөлд өртөж болохыг тайлбарлана (ж.нь, хийжийн буюу нянгийн бохирдуулагчид хяналтын арга хэмжээ дотроосон буюу цаг уурын онцгой үзэгдлийн үед)	Цөөрөм хальсан үед нянгийн бохирдолд өртөх
Ямар замаар өртөж байна?	Халдвар тархах замыг тодорхойлно (арьсаар, бохирлогдсон ногоо хүнсэндээ хэрэглэх, усаар, хөрсөөр, вектороор г.м.)	Арьстай хүрэлцэх замаар, хоол боловсруулах замаар
Ямар давтамжтай өртөж байна?	Өртөлтийн давтамж: өдөр бүр, долоо хоног тутам, сард нэг удаа, жилд нэг удаа г.м. Мэдэхгүй байвал таамаглал дэвшүүлнэ	Зуны саруудад өдөр тутам
Өртөлтийн тунг?	Өртөлтийн магадлалт тун – энэ нь нөхцөл байдлаас шалтгаалах ба тооцоолоход төвөгтэй байж болно. Мөн бүлгүүдийн хооронд ялгаатай байж болно. Мэдэхгүй байвал таамаглал дэвшүүлнэ	Цөөрөмийн усанд <ul style="list-style-type: none"> • 100 мл тутамд ... E.coli • 1 л тутамд ... цагаан хорхойн өндөг байх магадлалтай

* энэ асуулт эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ зэрэг нарийн тоон үнэлгээнд хамаатай

Эх сурвалж: Stenstrup ба бусад (2011)

АРГА ХЭРЭГЭСЭЛ 3.2

Эрсдэлийн чанарын үнэлгээнд ашиглах эрсдэлийн түвшний ангилал

Эрсдэлийн түвшин	Тайлбар
Өндөр	Тухайн үйл явдал болсноор хүмүүс гэмтэх, цочмог буюу архаг өвчинд нэрвэгдэх, амь насаа алдах боломжтой. Эрсдэлийг бууруулахын тулд арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай.
Дунд зэрэг	Тухайн үйл явдал болсноор хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөө дунд зэрэг (ж.нь, толгой өвдөх, халуурах, суулгах, бага хэмжээний бэртэл) эсхүл тав тух алдагдана (ж.нь, дуу чимээ, зөвгүй үнэр). Өндөр эрсдэлт үзэгдлийг хянасны дараа дунд зэргийн эрсдэлийг бууруулах арга хэмжээ хэрэгжүүлнэ.
Бага	Эрүүл мэндэд нөлөө үзүүлэхгүй. Ямар нэгэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай. АЦБАБТ – ний хэрэгжилтийг үнэлэхдээ эрсдэлийг дахин үнэлнэ.
Тодорхойгүй	Эрсдэлийг эрэмбэлэхийн тулд нэмэлт тоо мэдээ шаардлагатай. Нэмэлт мэдээ цуглуулах эзүү эрсдэлийг бууруулах зарим арга хэмжээ авч хэрэгжүүлж болно.

АРГА ХЭРЭГЭСЭЛ 3.3

Эрсдэлийн хагас тоон үнэлгээнд ашиглаж болох эрсдэлийн тодорхойлолт

Тодорхойлолт	Тайлбар
Магардал	
1 Маш бага	Өмнө нь тохиолдож байгаагүй ба дараагийн 12 сарын хугацаанд тохиолдоно гэх боломж бага үгүй.
2 Бага	Өмнө нь тохиолдож байгаагүй боловч дараагийн 12 сарын хугацаанд онцгой нөхцөл байдалд тохиолдож болно.
3 Боломжтой	Өмнө нь тохиолдсон байж болзошгүй ба/буюу дараагийн 12 сарын хугацаанд ердийн нөхцөл байдалд тохиолдож болно.
4 Өндөр	Өмнө нь тохиолдож байсан ба/буюу дараагийн 12 сарын хугацаанд тохиолдох магадлалтай.
5 Тодорхой	Өмнө нь тохиолдож байсан ба/буюу дараагийн 12 сарын хугацаанд ямар ч нөхцөлд тохиолдох нь бараг тодорхой.
Нолгой байдал	
1 Үлмийгүй	Аюулт хүчин зүйл буюу аюулт үзэгдэл нь эрүүл мэндэд нөлөө үзүүлэхгүй буюу өчүүхэн нөлөө үзүүлнэ
2 Бага зэрэг	Аюулт хүчин зүйл буюу аюулт үзэгдэл нь эрүүл мэндэд бага зэрэг нөлөө үзүүлнэ (ж.нь, загатнах, дотор муухайрах, толгой өвдөх зэрэг түр зуурын шинж тэмдэг илэрнэ)
4 Дунд зэрэг	Аюулт хүчин зүйл буюу аюулт үзэгдэл нь хөнгөвтөр өвчин үүсгэнэ (ж.нь, цочмог суулгалт, бөөлжилт, амьсгалын дээд замын халдвар, бага хэмжээний бэртэл гэмтэл)
8 Ихээхэн	Аюулт хүчин зүйл буюу аюулт үзэгдэл нь өвчин буюу гэмтэлд хүргэнэ (ж.нь, хумхаа, шистосомоз, хүнсээр дамжих цагаан хорхойтой өвчин, архаг суулгалт, амьсгалын архаг эмгэг, мэдрэлийн эмгэг, ясны хугарал), ба/буюу эрхзүйн зөрчилд хүргэнэ, ба/буюу хяналтаар томоохон зөрчил илрэхэд хүргэнэ.
16 Гамшигт	Аюулт хүчин зүйл буюу аюулт үзэгдэл нь хүнд өвчин буюу гэмтэл, үхэлд хүргэнэ (ж.нь, хүндээр хордох, мөч таарах, хүчтэй түлэгдэх, живэх), ба/буюу томоохон хяналт шалгалт, зарим тохиолдолд мөрдөн байцаалтын ажиллагаа эхлүүлэхэд хүргэнэ.

АРГА ХЭРЭГСЭЛ 3.4

Эрсдэлийн хагас тоон үнэлгээний матриц

Магадлал (M)	Нолгой байдал (H)				
	Ялимгүй	Бага зэрэг	Дунд зэрэг	Ихэвхэн	Гамшигт
Маш бага	1	2	4	8	16
Бага	2	4	8	16	32
Боломжтой	3	6	12	24	48
Өндөр	4	8	16	32	64
Тодорхой	5	10	20	40	80
Эрсдэлийн оноо $Z=(M)(H)$	<6	7-12			>32
Эрсдэлийн түвшин	Бага	Дунд зэрэг		Өндөр	Маш өндөр

ЖИШЭЭ 3.1

Ариун цэврийн систем дэх түгээмэл аюулт хүчин зүйлийн төрөл

Аюулт хүчин зүйлийн төрөл	Жишээ
Эмгэг төрөгч бичил биетэн	Нян, шимэгч эгэл биетэн, вирус (ж.нь, <i>Yersinia enterocolitica</i> , <i>Giardia intestinalis</i> , коксакивирус, гепатит E вирус) Цагаан хорхой (ж.нь, хялгасан хорхой, анкилостом) Вектороор дамжих эмгэг төрөгч (ж.нь, денге вирус, шистосом)
Химийн бодис	Хүнд метал (ж.нь, хүнцэл, кадми, мөнгөн ус) Гербицид ба пестицид
Физикийн хүчин зүйл	Зарим нөхцөлд ургац нэмэгдүүлэх бодис (ж.нь, бор) Хурц үзүүртэй зүйл (ж.нь, зүү) Үнэр Ажилчид багаж тоног төхөөрөмжид өртөж, бэртэх Арьс цочроогч (нянгийн ба химийн аюулт хүчин зүйлийн холлимог)

Жич: Замгийн хор мөн байж болно. Нуур, усан сан, цөөрөм, удаан урсгалтай гол мөрөнд хөх ногоон замгаг ихээр ургадаг ба эдгээрийн цөөнгүй төрөл нь эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй хор ялгаруулдаг.

ЖИШЭЭ 3.2

Аюулт үзэгдлийн төрөл

<p>Аюулт үзэгдлийг тодорхойлохдоо дараах зүйлийг харгалзана. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Системийн зураглалд тодорхойлсон бохирдын өөр өөр эх үүсвэрүүд • Улирлын ба уур амьсгалын хүчин зүйл (ж.нь, урсгалын хурдны өөрчлөлт, хуурай улиралд хорт химийн бодисын түвшрүүлэг нэмэгдэх, усалгааны улирал) • Урсгалын дээр хотжилт буюу үйлдвэржилтийн ажил явагдах • Системийн доголдол буюу осол (ж.нь, доголдол үүссэнээс буюу үйлдвэрийн хаягдал усыг хууль бусаар нийлүүлснээс химийн бохирдол болох, усжуулалтын дэд бүтэц задарснаас тариалангийн талбай дах цэвэрлэлтийн цөөрмөөр дамжаагүй ус нийлүүлэгдэх)

Жишээ 1.5 ба 1.11-с суурь мэдээллийг харна уу


ЖИШЭЭ 3.3

Хяналтын арга хэмжээ, тэдгээрийн гүйцэтгэл, түгээмэл доголдлын жишээ

Хяналтын арга хэмжээ	Хяналтын түвшин*	Багалгажуулах явцад тодорхойлсон түгээмэл доголдол
Хувийн хамгаалах хэрэгсэл	Ажилчдыг аюулт хүчин зүйлд арьс болон агаар дуслын замаар өртөхөөс хамгаалдаг	Ажилчид зөвхөн хүйтний улиралд хувийн хамгаалах хэрэгслийг хэрэглэдэг тул жилийн 12 сарын 7-д нь өртөх эрсдэлтэй байдаг
Бохирыг тогтворжуулах цөөрөм	100 мл-д ногдох колиформын тоошил тодорхой түвшинд бууртал бохирыг цэвэршүүлдэг 1 литрт цагаан хорхойн өндөгний тоошил 1-ээс цөөн болтол бууруулдаг	Оновчгүй хийцтэй байснаас, ачааллыг хэтрүүлснээс тогтворжуулах хугацаа богиносж, цөөрмөөс гарч буй усны чанар муу байв
Усжуулалт: хэсэг газрын дуслын усалгааны технологи	Ажилчдыг өртөлтөөс хамгаалахад маш үр дүнтэй (логарифм бууралтын үзүүлэлт = 2)	Усалгааны шугам хоолой бөглөрснөөс ажилчид түүнийг засварлах явцад аюулт хүчин зүйлд өртөх боломжтой
Усжуулалт: эмгэг төрөлчийг үхүүлэх зорилгоор сүүлд усалснаас ургац хураах хүртэл тодорхой хугацаанд хүлээх	Логарифм бууралтын үзүүлэлт нь үр тарианы төрөл, температурас хамаарах бөгөөд газар бүрт онцлог байдаг	Цэвэр усны хангамж хязгаарлагдмал хуурай улиралд тэр бүр хэрэгжүүлдэггүй Цагаан хорхойн өндөг удаан хугацаагаар амьдрах чадвартай нөхцөлд (ж.нь, шууд нарны тусгалгүй орчинд, цаг агаар сэрүүн үед) доголдох эрсдэл өндөр
Хоол бэлдэх арга: саладны ургамлыг сайтар угаах	Логарифм бууралт = 1	Нэн ялангуяа ядуу, усны хангамж хязгаарлагдмал өрхүүд тэр бүр хэрэгжүүлдэггүй

* Хяналтын арга хэмжээний үр дүнтэй эсэхийг үнэлэх талаар нэмэлт мэдээллийг Модуль 4 ба Хавсралт 1-с харна уу.

Эх сурвалж: 2006 оны ДЭМБ-ын удирдамж (2 дугаар ботгийн 3.1.1 ба 5 дугаар хэсэг)



МОНДУЛЬ 4
ҮЕ ШАТТАЙ
САЙЖРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨ
БОЛОВСРУУЛАХ,
ХЭРЭГТЖҮҮЛЭХ НЬ

МОДУЛЬ 4 ҮЕ ШАТТАЙ САЙЖРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ, ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ

Тойм

Модуль 3-ын хүрээнд АЦБАБТ-ний баг нэн тэргүүнд хяналтанд авах шаардлагатай эрсдэлүүдийг тодорхойлсон. Улмаар Модуль 4 нь эдгээр эрсдэлийг хамгийн үр дүнтэй байдлаар хянах шинэ арга хэмжээ болон сайжруулалтын бусад арга хэмжээ хэрэгжүүлэх боломжийг олгоно. Ингэхдээ хамгийн өндөр эрсдэлийг нэн тэргүүнд хяналтандаа авахад санхүүжилт болон бусад хүчин чармайлтыг чиглүүлэх зарчим баримтална.

Модуль 4.1-ийн хүрээнд АЦБАБТ-ний баг эрсдэлийг хянах хувилбаруудыг авч үзнэ. Үүнд урт, богино хугацааны төлөвлөгөө, цэвэрлэлтийн, цэвэрлэлтийн бүс болон зан үйлийн хяналтын арга хэмжээ зэргийг харгалзан үзэхийн зэрэгцээ ариун цэврийн шугам сүлжээний чухам хаана хэрэгжүүлэх дээр тогтоно.

Модуль 4.2 нь дээрх хувилбаруудыг үйл ажиллагааны тодорхой төлөвлөгөө болгон нэгтгэнэ.

Модуль 4.3 нь сайжруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд анхаарна.

Модуль 4-ийн хүрээнд боловсруулж хэрэгжүүлсэн сайжруулалтын төлөвлөгөө болон Модуль 5-ын хүрээнд боловсруулж хэрэгжүүлсэн хяналт-шинжилгээний төлөвлөгөө нь АЦБАБТ-ний гол бүтээгдэхүүн болдог. Хэрэв Модуль 3-ын хүрээнд эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлийг эрэмбэлэхэд сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагагүй гэсэн үр дүн гарвал Модуль 4-ийг алгасч, Модуль 5, 6 руу шилжинэ.

Модуль

4.1 Тодорхойлсон эрсдэлийг хянах хувилбаруудыг сонгох нь

4.2 Сонгосон хувилбаруудыг ашиглан үе шаттай сайжруулалтын төлөвлөгөө боловсруулах нь

4.3 Сайжруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх нь

Хүлээгдэж буй үр дүн

- Бүх өргөмтийг бүлгүүдийг хамгаалахад чиглэсэн үе шаттай сайжруулалтын төлөвлөгөөг хэрэгжинэ

4.1 Тодорхойлсон эрсдэлийг хянах хувилбаруудыг

СОНГОХ НЬ

Модуль 3-ыг хэрэгжүүлсний эцэст эрсдэлийн дагуу эрэмбэлсэн аюулт хүчин зүйл болон аюулт үзэгдлийн жагсаалт гарсан байна.

АЦБАБТ-ний баг эдгээр эрсдэлийг хяналтанд авах боломжуудыг судалж, хэрэгжүүлэхээр сонгосон арга хэмжээнүүдийг сайжруулалтын төлөвлөгөө болгон томъёолно.

Сайжруулалтын төлөвлөгөөнд дараах арга хэмжээг тусгаж болно. Үүнд:

- Барилгын ажил (ж.нь, Цэвэрлэх байгууламж нэмж буюу шинээр барих, байгууламжийг хаших)
- Явцын арга хэмжээ (ж.нь, өвчин дамжуулагчийг устгах, үр тарианы төрлийг хязгаарлах)
- Зан үйлийн арга хэмжээ (ж.нь, хувийн хамгаалах хэрэгслийн хэрэглээг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт тогтмол хамруулах)
- Дээрхийн хослол

Жишээ 4.1-д сайжруулалтын төлөвлөгөө болон хяналтын арга хэмжээний төрлийг харуулсан байна. Хавсралт 1-д бохир усыг дахин ашиглахтай холбоотой хэрэгжүүлэх хяналтын арга хэмжээний жишээ, тэдгээрийн үр дүнгийн талгарах мэдээллийг тоймлоосон болно.

Чиглүүлэх зөвлөмж 4.1-д хэрэглэгчийг хамгаалахын тулд эмгэг төрөгчийн тоошилыг хорогдуулах аргуудын талгар мэдээлэл өгсөн байна.

Хяналтын арга хэмжээг сонгохдоо дараахь зүйлийг харгалзах нь зүйтэй. Үүнд:

- Одоо байгаа хяналтын арга хэмжээнээс давуу байж чадах эсэх
- Шаардлага зардлыг үр дүнтэй нь харьцуулж үзэх
- Армун цэврийн шугам сүлжээний чухам хаана (ж.нь, аюулт хүчин зүйлийн эх үүсвэрт эсхүл урсгал дагуу өөр цэгт) хэрэгжүүлбэл хамгийн үр дүнтэй байхыг судлах
- Хяналтын арга хэмжээний үр дүнгийн техникийн үзүүлэлт
- Орон нутгийн соёл, зан заншлын онцлогт нийцэх, хүлээн зөвшөөрөгдөх эсэх
- Тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалт, харилцаа мэдээлэл, тайлагналтын урсгал.

Боломжтой бол сайжруулалтын төлөвлөгөөнд тулгамдсан асуудлын үндсэн шалтгааныг арилгах арга хэмжээг тусгана. Эрсдэлийг бууруулахад баримталдаг гол зарчим бол хяналтын арга хэмжээг эрсдэлийн эх үүсвэрт аль болох ойр хэрэгжүүлэх зарчим юм. Гэвч энэ тэр бүр боломжтой байдаггүй. Икэнхдээ эрсдэлийн эх үүсвэрээс өөр хэсэгт хяналтын нэг арга хэмжээ хэрэгжүүлж, хэд хэдэн аюулт үзэгдлийг хяналтанд авах зарчмыг баримталдаг.

Жишээ 4.2-т хязгаарлагдмал нөөцтэй ХАА-н салбарт харгалзан үзэх хувилбаруудыг толилуулсан бөгөөд зарим тохиолдолд хамгийн тохиромжтой арга хэмжээг хэрэгжүүлэх боломжгүй байсан ч нийгмийн эрүүл мэндийг хамгаалах бусад арга хэмжээг хэрэгжүүлж болдог, хэрэгжүүлэх ёстойг ч тодотгон харуулсан байна. Жишээ 4.3-т ХАА-н салбарт цагаан хорхойн өндгийг хянах өвөрмөц арга хэмжээний жишээг толилуулжээ.

4.2 Сонгосон хувилбаруудыг ашиглан үе шаттай сайжруулалтын төлөвлөгөө боловсруулах нь

Эрсдэл тус бүрийг хянах хамгийн тохиромжтой арга хэмжээг сонгосны дараа АЦБАБТ-ний баг эдгээрийг нэгтгэсэн сайжруулалтын төлөвлөгөө боловсруулна. “Жишээ: Ньютауны АЦБАБТ”-д ашигласан маягуудыг сайжруулалтын төлөвлөгөөний загвар болгон ашиглаж болно.

Зарим эрсдэлийг хянахын тулд хоёр буюу түүнээс олон байгууллага хамтран оролцох шаардлагатай байж болно. Ийм тохиолдолд эрсдэлийн үнэлгээний үр дүнгийн талаар зөвшилцөлд хүрэх, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох асуудлыг Удирдах зөвлөл (Модуль 1.1) буюу АЦБАБТ-г тэргүүлэгч байгууллага (Модуль 1.3) хариуцах нь зүйтэй.

Сайжруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахын тулд үйл ажиллагаа тус бүрийг хариуцсан байгууллага/албан тушаалтан, хэрэгжүүлэх хугацааг тодорхойлно. Оролцогч талуудын үүрэг хариуцаага, шаардлагатай санхүүжилт, хугацаа зэргийг тодорхойлоход сайжруулалтын төлөвлөгөө хамгийн тохиромжтой юм.

Хяналтын өртөг зардал өндөртэй арга хэмжээг хэрэгжүүлэх санхүүжилт олгооо арай хямд төсөр түр зуурын арга хэмжээг хэрэгжүүлж болно.

“Жишээ: Ньютауны АЦБАБТ”, Жишээ 4.4-4.7-с сайжруулалтын төлөвлөгөөний талаар нэмэлт мэдээлэл авна уу.

4.3 Сайжруулалтын төлөвлөгөө хэрэгжүүлэх нь

АЦБАБТ-ний баг сайжруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор хяналт тавьж, тайлагнана.

ЧИГЛҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ 4.1

ХАА-д бохир ус ашиглахад олон давхар хаалтын аргыг хэрэгжүүлэх нь

Чиглүүлэх удирдамж 3.5-д тайлбарласнаас харвал бохир усны цэвэрлэлтийн дүнд эмгэг төрөгчдийн тоошилыг бууруулах нь эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах чухал ач холбогдолтой байна. ДЭМБ-ын 2006 оны удирдамжид эрүүл мэндийн зорилтыг нэг жилд нэг хүнд ногдох ХЧА-гүй наслаглыг 10-6 байхаар тогтоосон бөгөөд энэхүү зорилтыг хангахын тулд эмгэг төрөгчийн тоошилыг бууруулах наад захын хэмжээг зөвлөмж болгосон.

ХАА-д ашиглах бохир усан дах бичил биетний тоошилын логарифм бууралтын зорилтот түвшинг Зур. 4.1-д харуулсан бөгөөд бохир усны цэвэршүүлэлтийг эрүүл мэндийг хамгаалах бусад арга хэмжээтэй хослуулах замаар энэхүү зорилтыг хангах боломжтой юм. Логарифм бууралтын зорилтот түвшин нь усалгааны төрөл, үр тарианы төрөл, тариалалтын арга ажиллагаанаас хамаардаг байна.

Газар тариалан эрхлэгчид болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдийг цагаан хорхойн халдвараас хамгаалахын тулд 1 литрт 1-ээс цөөн дуггираг хорхойн өндөгтэй усыг усалгаанд (өндөр ургалттай үр тарианы хэсэг газрын усжуулалтаас бусад тохиолдолд) ашиглана. Харин 15 хүртэлх насны хүүхэд өртөх эрсдэлтэй бол энэхүү үзүүлэлтийг 1 литрт 0.1-ээс цөөн өндөг болгон бууруулна [2006 оны ДЭМБ-ын удирдамжийн 2 дугаар ботийн 66-68 дугаар хуудаснаас дэлгэрүүлнэ үү].

ХАА-д ашиглах бохир усан дах бичил биетний тоошилын зорилтот түвшингийн талаар 2006 оны ДЭМБ-ын удирдамж (3 дугаар ботийн 4.2, 4 дүгээр ботийн 4.1 ба 5 дугаар хэсэг)-аас дэлгэрүүлнэ үү.



2006 оны ДЭМБ-ын удирдамж болон Зур. 4.1-д тусгэгддаагүй нэмэлт ойлголтуудыг дор дурдсан болно. Үүнд:

1. Бүх өртөмтгий бүлгүүдийг зохих ёсоор хамгаалах шаардлагатай. Бохир усыг ХАА-д ашиглаж байгаа тохиолдолд нэн ялангуяа тариаланчид болон хэрэглэгчдийг хамгаалах нь чухал юм.
2. Эхэндээ логарифм бууралтын зорилтыг бүрэн хангах боломжгүй байж болно. Сайжруулалтын төлөвлөгөөний хүрээнд нөхцөл байдлыг үе шаттайгаар сайжруулах зорилт тавина.
3. Усалгаанд ашиглаж буй усны чанар тариаланчдын болон хэрэглэгчдийн аюулгүй байдлыг хангахад онцгой чухал. Цэвэрлээгүй бохир ус хэзээ ч аюулгүйд тооцогдохгүй. Иймд усалгааны усны чанарын шаардлагыг хангахын тулд усыг цэвэрлэх нь зүйтэй (энэхүү жагсаалтын 5 ба 6 дугаарыг харна уу). Гэхдээ логарифм бууралтын зорилтот түвшин Зур. 4.1-д харуулсанчлан тариалалтын нөхцөл байдлаас хамаардаг.

4. Газар тариалан эрхлэгчид онцгой өртөмтгий байдаг тул өртөлтөөс сэргийлэх арга хэмжээ хэрэгжүүлэх (ж.нь, хувийн хамгаалах хэрэгсэл ашиглах, гар угаах, хувийн ариун цэврийг сайтар сахих) нь зүйтэй. Эдгээрийг хамгаалах нөлөөтэй гэж үздэг боловч 2006 оны ДЭМБ-ын удирдамжид логарифм бууралтын нөлөөг нь тооцоолоогүй байна. Усалгааны усны микробиологийн чанар шаардлагын түвшинд хүрэхгүй байгаа нөхцөлд эдгээр арга хэмжээ нь нэн чухал юм.
 5. Усалгааны усны чанарын шаардлагыг хангахуйц ус цэвэрлэлтийн олон арга байдаг. Тухайлбал, хагас цэвэрлэх тунадасжуулалтын арга нь усны чанарыг сайжруулах, шимт бодисыг хадгалах бүрэн цэвэрлэлттэй харьцуулахад зардал багатай арга юм. 2006 оны ДЭМБ-ын удирдамжийн Хавсралт 1 [2 дугаар ботийн 5 дугаар хэсэг]-д цэвэрлэлтийн аргуудыг танилцуулж, логарифм бууралтын нөлөөг нь тодорхойлсон байна.
 6. Эмгэг төрөгчийн тоошилыг бууруулах бас нэг арга бол шингэрүүлэлтийн арга (ө.х. цэвэрлээгүй бохир усыг голын устай холих арга) юм. Гэхдээ бичил биетний тоошилыг 1 логарифм нэгжээр бууруулахын тулд бохир усыг нэлээд их хэмжээний голын усаар шингэрүүлэх шаардлагатай болдог.
 7. Цэвэрлэлт, шингэрүүлэлтээс гадна эмгэг төрөгчийн тоошилыг бууруулах олон арга бий. Тухайлбал, хэсэг газрын усжуулалт нь тариаланчдын өртөх эрсдэлийг бууруулах үр дүнтэй арга юм. Хэсэг газрын усжуулалтанд ашиглах усанд тавих чанарын шаардлага нь гадаргын буюу бороожуулах усжуулалттай харьцуулахад бага байж болно. Гэхдээ нам дор ургалттай үр тарианы хувьд хэсэг газрын усжуулалт ашигласан ч гэсэн 1 литр усан дах цагаан хорхойн өндөгний тоошилыг 1 буюу түүнээс доош хэмжээнд барих шаардлага тавигддаг. Хэсэг газрын усалгаанд боломжтой бол цэвэрлэсэн бохир ус ашиглах нь зүйтэй.
 8. Хэрэглэгчдийн аюулгүй байдлыг хангах нэмэлт хяналтын арга хэмжээ хэрэгжүүлж болно. Тухайлбал, хэрэглээнд хязгаарлалт тогтоох (ө.х., түүхийгээр идэж болох үр тариаг заавал болгож хүнсэнд хэрэглэх үр тарианаас ялгах), ургац хураахаас тодорхой хугацааны өмнө усалгааг зогсоох, хамгийн сүүлд усалснаас хойш хүнсэнд хэрэглэх хүртэл заавал хүлээх хугацааг тогтоож мөрдөх, бүтээгдэхүүнийг угааж/хальсалж/чанааж хүнсэнд хэрэглэх. Дэлгэрэнгүйг Хавсралт 1 болон 2006 оны ДЭМБ-ын удирдамж [2 дугаар боть, Хүснэгт 4.3 ба 5 дугаар хэсэг]-аас харна уу.
 9. Логарифм бууралтын зорилтыг хангахын тулд хяналтын хэд хэдэн арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай болдог. Үүнийг “олон давхар хаалт”-ын арга гэж нэрлэдэг.
- Зур. 4.1-Д ашигласан нэр томъёоны тайлбарыг гарын авлагын эхэнд байгаа Нэр томъёоны тайлбараас харна уу.
- Түгээмэл хэрэглэдэг хяналтын арга хэмжээнүүдийн логарифм бууралтын нөлөөг Хавсралт 1-с харна уу.
- Зур. 4.1-ийн практик хэрэглээний зарим жишээг “Жишээ:Ньютауны АЦБАБТ”-с харна уу.

ЗУРАГ 4.1

УСАЛГААНЫ УСНЫ ЧАНАРТ ТАВИХ ШААРДЛАГА УСКЖУУЛАГТЫН АРГА, ҮР ТАРИАНЫ ТӨРЛӨӨС ХАМААРАХ НЬ



ЖИШЭЭ 4.1

Сайжруулалтын төлөвлөгөөний төрөл

Сайжруулалтын төлөвлөгөөний төрөл	Жишээ
Хяналтын арга хэмжээ: явцын	Хэрэглээнд хязгаарлалт тогтоох, усаалганы арга
Хяналтын арга хэмжээ: зан үйлийн	Тариалангийн талбайд ажиллаж дуусаад гар, хөлөө угаах*
Бариалтын ажил	Бохир ус цэвэрлэх байгууламж барих

* Талбайд ажиллахдаа өмсөж байсан бохирдсон хувцсыг гэртээ оруулах нь өвчин тараах эх үүсвэр болж болно

ЖИШЭЭ 4.2

Нөөц хязгаарлагдмал нөхцөлд гар ажиллагаа бүхий газар тариаланд хэрэгжүүлж болох сайжруулалтын төлөвлөгөө

Энэхүү жишээнд цэвэрлээгүй бохир усыг халих усжуулалтад ашигладаг байна. Ийм аргаар усаалж ургуулсан шанцай (навчит хүнсний ногоо)-г орон нутгийн зах зээлд нийлүүлдэг. Шанцай хөрстэй байнга шүргэлцэх ба хүнсэнд түүхийгээр нь хэрэглэдэг. Энэ жишээнд гар ажиллагаа бүхий газар тариалан эрхэлдэг байна.

Орон нутагт санхүүгийн нөөц хязгаарлагдмал бөгөөд бохир ус хэрэглэх нь тариаланчдын амьжиргаанд тус нэмэр болдог байна. Бохир усан дах шим тэжээл нь ургац арвин байхад нөлөөлдөг. Бохир усыг төвлөрсөн байгууламжийд Цэвэрлэх болгомж ойрын ирээдүйд байхгүй. Хэрэглэгчид хүнсний ногоог угааж хүнсэндээ хэрэглэдэг.

Чиглүүлэх зөвлөмж 4.1-ийн Зур. 4.1-с харахад энэ нөхцөлд логарифм бууралтын зорилт 6 байна. Үүнээс логарифм бууралтын 3 нэгж нь тариаланчдыг хамгаалахад шаардлагатай. Гэвч бодит байдал дээр усаалганы усан дах бичил биетэн (үүнд цагаан хорхойн өндөг)-ийн тоошил чанарын шаардлага хангахгүй бөгөөд тариаланчид өндөр эрсдэлтэй нөхцөлд ажиллаж байна.

Тариаланчдыг хамгаалах дараах болгомж байна. Үүнд:

- Тариан талбайд усыг богино хугацаагаар хорих анаароо цөөрөм байгуулснаар цагаан хорхойн өндөг, бусад эмгэг төрөгчийн тоошилыг тодорхой хэмжээгээр бууруулах
- Дуслын усаалга (хэрэглэгчдийг бүрэн хамгаалахын тулд нэмэлтээр логарифм бууралтын нэгжийг 4 болгох шаардлагатай анхаарна уу)
- Тариаланчдын хувийн хамгаалах хэрэгслийг сайжруулах (ж.нь, хамгаалах хуцас өмсөх, гараа угаах, хувийн ариун цэврийг сайтар сахих)

Хэрэглэгчдийг хамгаалах дараах болгомж байна. Үүнд:

- Ургац хураалтын өмнөх усаалганы хангалт (ж.нь, ургац хураахаас тодорхой хугацааны өмнө усаалгааг зогсоох)
- Хүнсэнд хэрэглэхээс өмнө эмгэг төрөгчийг үхүүлэх (ж.нь, хамгийн сүүлд усаалснаас хойш хүнсэнд хэрэглэх хүртэл заавал хүлээх хугацааг тогтоож мөрдөх)
- Бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхээс өмнө цэвэр усаар угаах
- Бүтээгдэхүүнийг хүнсэнд хэрэглэх зохистой дадал хэвшүүлэх суртал

Бодит нөхцөл байдлыг харгалзан ойрын хугацаанд зорилтыг хэрэгжүүлэх боломжгүй хэдий ч дээрх арга хэмжээнүүдийг хослуулан хэрэгжүүлснээр тариаланчид, хэрэглэгчдийн эрүүл мэндэд учирч болох эрсдэлийг бууруулах боломжтой юм.

ЖИШЭЭ 4.3

Цагаан хорхойн халдварыг хянах арга хэмжээ

Аюулт хүчин зүйл: цагаан хорхойн өндөг

Аюулт үзэгдэл: хагас цэвэрлэсэн бохир усыг тармалангийн талбайд ашиглах үед тармаланчид буюу хүүхдүүд (15 хүртэлх насны) өртөж, цагаан хорхойн халдвар авах

Хяналтын арга хэмжээ ба анхаарах асуудал:

1. Турийтэй гутал өмсөх нь аюулт хүчин зүйлд өртөх магадлалыг бууруулна. Гэвч энэ нь бодит амьдрал дээр тэр бүр хэрэгждэггүй тул найдвартай биш.
2. Бохир усыг цэвэрлэх энгийн арга (ж.нь, усалганд ашиглахаас өмнө бохир усыг тодорхой хугацаанд хорьж, цагаан хорхойн өндөгний тоошилыг 1 литрт 0.1-с бага болгох энгийн цөөрөм) нь цагаан хорхойн өндөгний тоошилыг үр дүнтэй бууруулж чадна (2006 оны ДЭМБ-ын удирдамжийн 2-р ботийн 84-86-р хуудсаас харна уу).
3. Бохир устай харьцдаг ажилчдад цагаан хорхойн эсрэг эмийг тогтмол уулгах нь халдварын үргэлжлэх хугацаа болон хүндийн зэргийг бууруулдаг. Цагаан хорхойн халдвар нэлээд тархсан нөхцөлд халдварын тархалтыг бууруулах зорилгоор нийт хүн ам (ж.нь, сургуулийн хүүхдүүд)-д цагаан хорхойн эсрэг эмийг тогтмол уулгаж болно.

ЖИШЭЭ 4.4

Органник бордооны үйлдвэрлэлд хэрэгжүүлэх сайжруулалтын төлөвлөгөө, Вьетнам

Ойрын ирээдүйд хэрэгжүүлэх төлөвлөгөө:

- Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын талаар дотоод сургалт зохион байгуулах (ажлын байран дээрх бодит эрсдэлтэй холбох)
 - Вакуум цистерний үйл ажиллагаа болон бордоон дээр цэвэрлэх байгууламжаас гарсан усыг нэмэх үйл ажиллагаатай холбоотой эрсдэлийг бууруулах (ж.нь, вакуум цистерн ашиглахын оронд бохирыг цэвэрлэх байгууламжаас үйлдвэр рүү дамжуулдаг эвдэрсэн шахуургыг засварлаж, дахин сууримлуулах)
- Урт буюу дунд хугацааны төлөвлөгөө:
- Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг сайжруулж, механик эвдрэлийг багасгах (учир нь, эвдрэлийн үед ажилчинд аюулт хүчин зүйлд өртөх эрсдэл өндөр байдаг)
 - Бие засах газруудын орчин нөхцлийг сайжруулж, ажилчинд болон олон нийт эрсдэлд өртөхөөс сэргийлэх.

Жишээ 1.4 ба 2.1-с суурь мэдээллийг харна уу.

ЖИШЭЭ 4.5

ХАА-д бохир ус ашиглахтай холбоотой сайжруулалтын төлөвлөгөө, Вьетнам

Нөхцөл байдал:

1. Тосгон: өдөрт 40 м³ ус шахах хүчин чадалтай шахуурлын станц ашиглан бохир усыг шуудуунаас тариалангийн талбай руу шахдаг. Гэр ажиллагаатай газар тариалан эрхэлдэг ба тариалангийн талбай 90 га. Үүнээс гадна бохирын шуудуунаас бохир ус ашигладаг загас үржүүлгийн 10 цөөрөм бий. Тариаланчдын тоо 3000 орчим. Үр тарианы хувьд жилийн турш шуудуурдацдаг, арь, 4-8 дугаар сард нетруни, 9-өес 3 дугаар сарын хооронд усан кресс, туулайн талгай, осончу, хулуу зэргийг тариалдаг байна.
2. Зэргэлдээ хотоос цэвэрлээгүй бохир ус (ахуйн болон үйлдвэрийн) бохирын шуудуугаар дамжин тариалангийн талбайд хүргэгддэг байна. Бохир усыг нэмж цэвэрлэлтгүйгээр ХАА-д ашигладаг.

Сайжруулалтын төлөвлөгөөнд дараах арга хэмжээ туссан байна.

Ойрын ирээдүйд хэрэгжүүлэх төлөвлөгөө:

- Хувийн хамгаалах хэрэгсэл хэрэглэх, ажлын үеэр болон дараа цэвэр усаар гэр, хөлөө угаах дадал хэвшүүлэх сургалтад тариаланчдыг хамруулах
 - Шүүмүүл устгах ажлыг эрчимжүүлж, вектортой холбоотой эрсдэлийг бууруулах
 - Усалгаа хийж буй газрын ойр нэн ялангуяа хөл нүцэн тоглохын эрсдэлийн талаар сургалт зохион байгуулах
 - 6 сар тутам зорилготой хүн амьт цагаан хорхойн эсрэг эмчилгээнд хамруулах
 - Ургац хураалтаас өмнө хүнсийг хамгаалах арга хэмжээ авах (ж.нь, ургац хураахаас өмнө аль болох эрт усалгааг зогсоож эмгэг төрөгчийн тоошилыг бууруулах)
 - Үр тариа хүнсэнд хэрэглэх зохистой дадал хэвшүүлэх сургалт (ж.нь, түүхийгээр нь хүнсэнд хэрэглэдэг үр тариаг халдваргүйжүүлсэн усаар сайтар угаах)
- Үрт буюу дунд хугацааны төлөвлөгөө:**
- Усалгаанд ашигладаг бохир усан дах химийн бохирдлын түвшинг бууруулах (хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах)
 - Бохир усыг цэвэрлэх ажиллагааг үе шаттай сайжруулж, бохирын шуудуунд нийлүүлж буй усны чанарыг сайжруулах

ЖИШЭЭ 4.6

Сайжруулалтын арга хэмжээнүүдийн эрэмбэлэлт

Сайжруулалтын арга хэмжээнүүдээс нэн тэргүүнд хэрэгжүүлэхийг нь сонгохын тулд тэдгээрийн хүний ба орчны эрүүл мэндийг сайжруулах хүчин чадал, техникийн үр дүнтэй байдал, сонирхогч талуудад хүлээн зөвшөөрөгдөх магадлалыг харьцуулж үзсэн байна. Энэхүү харьцуулалтын үр дүн ба үзүүлэлт тус бүрийг ач холбогдлоор нь хэрхэн жинлэснийг дараах хүснэгтэд харуулсан болно.

Хүчин чадал	Техникийн үр дүнтэй байдал	Хүлээн зөвшөөрөгдөх байдал
Жинлэх коэффициент: 1.5	Жинлэх коэффициент: 1	Жинлэх коэффициент: 1.5
Өндөр = 3	Өндөр = 3	Өндөр = 3
Дунд зэрэг = 2	Дунд зэрэг = 2	Дунд зэрэг = 2
Бага = 1	Бага = 1	Бага = 1

Эрэмбийн оноо = (хүчин чадал × жин) × (үр дүн × жин) × (хүлээн зөвшөөрөгдөх байдал × жин) Эрэмбийн оноо өндөр байх тусам тухайн арга хэмжээнд тэргүүлэх ач холбогдол өгсөн болно.

Ингэснээр санхүүгийн болон бусад нөөцийн хязгаарлагдмал байдлыг харгалзан сайжруулалтын төлөвлөгөөнд тэргүүлэх чиглэлийг тогтоох боломжтой болсон байна.

Перу дах АЦБАБГ-ний туршлагад тулгуурласан болно.

ЖИШЭЭ 4.7

ХАА-д бохир ус ашиглахад хэрэгжүүлсэн ба хэрэгжүүлж болох хяналтын арга хэмжээ, Перу


Ариун цэврийн системд эрсдэлийг бууруулах зорилгоор хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлж болох хяналтын арга хэмжээнүүдийг тодорхойлжээ. Ингэхэд өөр өөр аюулт хүчин зүйлийг хянах зорилгоор ижил арга хэмжээг давтан хэрэгжүүлсэн тохиолдлууд илэрсэн нь нэг арга хэмжээний тусламжтай хэд хэдэн аюулт хүчин зүйлийг хянах боломжтойг харуулсан байна. Тухайлбал, "гол руу хаягдал ус нийлүүлэхийг хянах" арга хэмжээг 8 аюулт хүчин зүйлийн 7-д нь хэрэгжүүлэх боломжтой байна.

Голын ус руу нийлүүлэх:

- Голын усны бохирдлыг хянах (ж.нь, хаягдал усны чанарыг сайжруулахын тулд үндэсэрлэлийн болон уул уурхайн ажиллагааг боловсронгуй болгох, хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах)
- Ахуйн бохир усыг голд нийлүүлэх ажиллагааг хянах (ж.нь, ахуйн бохир ус цэвэрлэх байгууламж барих, хууль тогтоомж зорчигчдод торгууль ногдуулах)
- Усжуулалтын шуудуудад ялгдас, бохир ус нийлүүлэхийг хянах (ж.нь, ойролцоо айл өрхүүдэд ариун цэврийн тусгаарлагдмал систем байгуулах)

Ногоон байгууламж, тариалангийн талбай, усны аж ахуйн усжуулалтын систем:

- Ус эмгэг төрөгчөөр бохирлогдохыг хянах (ж.нь, бохир усыг усалгаанд ашиглахаас өмнө тодорхой хугацаанд барьж гүнадаасжуулах, цэвэрлэх байгууламж шинээр барих, суурьшлын бүсээс усжуулалтын шуудуу руу бохир ус, ялгдас асгахад хяналт тавих)
- Хүнсний ногоо, загас эмгэг төрөгчөөр бохирлогдохоос сэргийлэх (ж.нь, бохир усыг усалгаанд ашиглахаас өмнө тодорхой хугацаанд хорьж гүнадаасжуулах, хууль тогтоомж зорчигчдод торгууль ногдуулах, ургацыг хураасны дараа цэвэр усаар угаах)



МОНДУЛЬ 5

ХЯНАЛТЫН АРГА
ХЭМЖЭЭГ ХЯНАХ
БА ГҮЙЦЭТГЭЛИЙГ
БАТАЛГААЖУУЛАХ НЬ

МОДУЛЬ 5

ХЯНАЛТЫН АРГА ХЭМЖЭЭГ ХЯНАХ БА ГҮЙЦЭТГЭЛИЙГ БАТАЛГААЖУУЛАХ НЬ

МОДУЛЬ

- 5.1 Үйл ажиллагааны хяналт–шинжилгээ хийх нь
- 5.2 Системийн гүйцэтгэлийг баталгаажуулах нь
- 5.3 Системийн аудит хийх нь

ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ ҮР ДҮН

- Үйл ажиллагааны хяналт–шинжилгээний төлөвлөгөө
- Баталгаажуулалтын хяналт–шинжилгээний төлөвлөгөө
- Хараат бус үнэлгээ

Тойм

Ариун цэврийн систем нь динамик систем юм. Маш сайн төлөвлөсөн систем хүртэл доголдож, нийгмийн эрүүл мэндэд эрсдэл учруулж, үйлчилгээ буюу бүтээгдэхүүнд нь итгэх итгэл алдрахад хүргэж болно. Модуль 5-ийн хүрээнд систем төлөвлөсний дагуу ажиллаж байгаа эсэхийг тогтмол хянах, доголдол гарсан тохиолдолд хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох хяналт–шинжилгээний төлөвлөгөө боловсрогдоно. Үйл ажиллагааны болон баталгаажуулалтын хяналт–шинжилгээ нь системийн гүйцэтгэл сайн байгаагийн баталгааг операторууд, олон нийт, эрх бүхий байгууллагуудад гаргаж өгдөг.

Модуль 5.1-ийн хүрээнд хяналтын арга хэмжээ үр дүнтэй байгаа эсэх талаар шуурхай эргэн мэдээлэл өгөх, шаардлагатай бол хугацаа алдалгүй залруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх боломж олгодог тогтмол хяналт–шинжилгээний талаар авч үзнэ.

Модуль 5.2 нь бохир ус, бүтээгдэхүүний чанар зэрэг системийн гүйцэтгэлийн үр дүнг үе үе баталгаажуулахад чиглэнэ. Баталгаажуулалтыг операторууд буюу хяналтын байгууллагууд хийх ба эрхзүйн хатуу зохицуулалттай, нөөц бололцоо сайтай газар энэ нь илүү хатуу чанд хийгддэг.

Модуль 5.3 нь системийн гүйцэтгэл, АЦБАБТ-ний чанарын талаар хөндлөнгийн нэмэлт нотолгоо бүрдүүлж өгдөг. Аудит нь энэхүү гарын авлагын танилцуулга хэсэгт тайлбарласан тандалтын чиг үүргийн нэг хэсэг байж болно. Зарим улс орнуудад ХАА-д бохир ус ашигласан бол бүтээгдэхүүнийг нь гэрчилгээжүүлэх шаардлага тавьдаг. Ийм тохиолдолд аудит хийх нь нэн ялангуяа тохиромжтой байдаг.

Модуль 5-ын хүрээнд бүрдүүлсэн нотолгоо нь системийг тасралтгүй сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэх үндэслэл болдог.

Модуль 4-ийн үр дүнд боловсруулж хэрэгжүүлсэн сайжруулалтын төлөвлөгөө болон **Модуль 5-ын хүрээнд** боловсруулж хэрэгжүүлсэн хяналт-шинжилгээний төлөвлөгөө нь АЦБАБТ-ний гол үр дүн болдог.

5.1 Үйл ажиллагааны хяналт-шинжилгээ хийх нь

Байгаа болон хэрэгжүүлэх шаардлагатай хяналтын арга хэмжээнүүдийг **Модуль 3** ба 4-ийн хүрээнд боловсруулсан. Эдгээр нь төлөвлөсөн ёсоор хэрэгжиж байгаа эсэх талаар шуурхай эргэн мэдээлэл өгч чадах хяналт-шинжилгээний цэг болон шалгуур үзүүлэлтийг сонгох нь **Модуль 5.1-ийн зорилт юм.**

Үйл ажиллагааны хяналт-шинжилгээгээр дараах мэдээг цуглуулдаг. Үүнд:

- Энгийн ажиглалт ба хэмжилтийн мэдээ (ж.нь, бохир хоригдох хугацааг тодорхойлох зорилгоор урсгалын хурдыг хэмжих, тариалангийн талбар дах ажиллагааг ажиглах)

- Сорьц цуглуулж, шинжилгээ хийх (ж.нь, химийн хэрэгцээт хүчилтөрөгч, биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч, хатуу тунадас)

Чиглүүлэх зөвлөмж 5.1-д үйл ажиллагааны хяналт-шинжилгээний жишээг тогилуулсан байна.

Хяналтын бүх арга хэмжээг хянах боломжгүй байж болно. Ийм тохиолдолд хамгийн өндөр эрсдэлийг хянах арга хэмжээ буюу хяналт-шинжилгээний нэн чухал цэгийг сонгох шаардлагатай. Хяналт-шинжилгээний цэг тус бүрийн хувьд дараах зүйлсийг тогтооно:

- Хянах шалгуур үзүүлэлт (хэмжилт хийх буюу ажиглах замаар хянанал)
- Хяналт-шинжилгээний арга
- Хяналт-шинжилгээний давтамж
- Хариуцах эзэн
- Зөвшөөрөгдөх хязгаар
- Зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан тохиолдолд авах арга хэмжээ

Хянах шалгуур үзүүлэлтийн зөвшөөрөгдөх хэмжээг голдуу тоон утгаар тодорхойлдог. Зарим тохиолдолд чанарын үзүүлэлт байдлаар тодорхойлж болно (ж.нь, "эвгүй үнэр байхгүй", "ялаа тав тух алдагдуулахгүй")

Үйл ажиллагааны хяналт-шинжилгээний төлөвлөгөө боловсруулахдаа Арга хэрэгсэл 5.1 ба 5.2-г толилуулсан маягтыг ашиглаж болно (мөн Жишээ 5.1-ийг харна уу).

Үйл ажиллагааны хяналт-шинжилгээний төлөвлөгөөг талбарт авч явахад тохиромжтой хүснэгт буюу бүртгэлийн дэвтэр хэлбэрээр үлэж ашиглаж болно.

5.2 Системийн гүйцэтгэлийг баталгаажуулах нь

Системийн ажиллагаа дотголдоггүй явагдаж байгаа эсэхийг тогтоохын тулд үе үе баталгаажуулах хяналт-шинжилгээг хийж, цаг хугацааны өөрчлөлтийг хянана. Системийн гүйцэтгэлийг баталгаажуулах нэн чухал цэгүүдийг сонгоно. Баталгаажуулах хяналт-шинжилгээнд үйл ажиллагааны хяналт-шинжилгээтэй харьцуулахад гүнзгийрүүлсэн шинжилгээ (ж.нь, E.coli, цагаан хорхой) хийнэ. Баталгаажуулах хяналт-шинжилгээг АЦБАБТ-ний баг буюу хөндлөнгийн эрх бүхий байгууллага хийж болно.

Үйл ажиллагааны хяналт-шинжилгээний нэгэн адил хянах шалгуур үзүүлэлт, арга, давтамж, харилцах эзэн, зөвшөөрөгдөх хэмжээ, зөвшөөрөгдөх хэмжээ хэтэрсэн үед хэрэгжүүлэх арга хэмжээ зэргийг тодорхойлно.

Үйл ажиллагааны хяналт-шинжилгээтэй харьцуулахад арай цөөн цэг сонгож баталгаажуулах хяналт-шинжилгээг хийнэ. Энэ нь голдуу системийн эцсийн бүтээгдэхүүний чанарт (ж.нь, системээс гарч буй усны чанар, үр тариа болон хөрсний нян судлалын ба химийн шинжилгээ, өрсөн хүн амын эрүүл мэндийн үзэлг) төвлөрдөг.

Нэмэлт мэдээллийг Чиглүүлэх зөвлөмж 5.2-5.5, Жишээ 5.2, 5.3-с авна уу.

5.3 Системийн аудит хийх нь

АЦБАБТ-ний эхэн үед нэн ялангуяа эрсдэлийн үнэлгээ, удирдлагатай холбоотой эрхзүйн зохицуулалт байхгүй нөхцөлд системийн аудит хийх нь тохиромжгүй байж болно.

Аудит нь АЦБАБТ-ний чанар, хэрэгжилтийн үр дүнг шалгах замаар АЦБАБТ-ний эрүүл мэндэд үзүүлэх зөрөг нөлөөллийг бататгаж өгдөг. Аудитыг дотоод буюу хөндлөнгийн аудиторуд хийж болно. Аудит нь АЦБАБТ-г зохих ёсоор боловсруулсан, үр дүнтэй хэрэгжүүлж байгаа эсэхийг харуулдаг. Чиглүүлэх зөвлөмж 5.7-д аудит хийхэд анхаарах асуудлуудыг толилуулсан байна. Аудит нь АЦБАБТ-г сайжруулах, хязгаарлагдмал нөөцийг илүү үр дүнтэй ашиглах боломж, сургалтын болон бусад хэрэгцээ шаардлагыг тодорхойлсноор АЦБАБТ-г хэрэгжүүлэхэд тус дөхөм болдог.

Аудитын давтамжийг системийн найдвартай ажиллагаанд эргэлзэхгүй байдлыг хангахад шаардлагатай түвшинд тогтооно. Аудит хийх мэдлэг, үр чадвар, туршлагатай хүний нөөцийг бүрдүүлэхэд амаргүй байж болно.

ЧИГЛҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ 5.1

АЦБАБТ-ний үйл ажиллагааны ба баталгаажуулах хяналт-шинжилгээ

Үйл ажиллагааны хяналт-шинжилгээ гэдэг нь аюулт үзэгдэл бий болохоос сэргийлэх талаар удирдлагын шийдвэрийг цаг алдалгүй гаргахад шаардлагатай нотолгоог бүрдүүлэх зорилгоор богино хугацаанд хэмжих боломжтой шалгуур үзүүлэлтүүдийг [ажиглалт хийх буюу түргэвчилсэн шинжилгээ хийх замаар] тогтмол хянах үйл ажиллагаа юм.

Ариун цэврийн системийн операторууд үйл ажиллагааны хяналт-шинжилгээнд дараах шалгуур үзүүлэлтийг ашиглаж болно.
Үнд:

- Бохирын урсгалын хурд
- Бохирыг хорих хугацаа
- Бохирыг цуглуулах давтамж
- Ашиглахаар төлөвлөж буй бохирын хэмжээ
- Биет хаалтууд байгаа эсэх
- Булингар, рН, БХХ, ууссан хүчилтөрөгч, үлдэгдэл хлор
- Хувийн хамгаалах хэрэгслийг зөв хэрэглэж байгаа эсэх
- Аюулт үзэгдэлд хүргэж болзошгүй цаг уурын ба уур амьсгалын мэдээг тогтмол хянадаг эсэх
- Ариун цэврийн тандалт хийдэг эсэх
- Хашаа, анхааруулах тэмдэг тэмдэглэгээний бүрэн бүтэн байдал
- Усанд шавжны авгалдай, эмгэн хүмс зэрэг завсрын эзэн байгаа эсэх

ЧИГЛҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ 5.2

2006 оны ДЭМБ-ын удирдамж дах мэдээллийн эх сурвалж

2006 оны ДЭМБ-ын удирдамжид үйл ажиллагааны ба баталгаажуулах хяналт-шинжилгээний шалгуур үзүүлэлт, давтамж, зөвшөөрөгдөх хэмжээний талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгснийг дараах хэсгээс харна уу:

Удирдамжийн бөтгөл дугаар		Хяналт-шинжилгээний талаарх холбогдох хэсэг	
Боть 2 (ХАА дах бохир усны хэрэглээ)		Хэсэг 4.3 Баталгаажуулах хяналт-шинжилгээ	
		Хүснэгт 4.6 Баталгаажуулах хяналт-шинжилгээний давтамж	
		Хэсэг 6.4 Үйл ажиллагааны хяналт-шинжилгээ	
		Хэсэг 6.5 Баталгаажуулах хяналт-шинжилгээ	
Боть 3 (ХАА дах бохир ус ба ялгадасны хэрэглээ)		Хэсэг 6.5 Үйл ажиллагааны хяналт-шинжилгээ	
		Хэсэг 6.6 Баталгаажуулах хяналт-шинжилгээ	
Боть 4 (ХАА дах ялгадас ба саарал усны хэрэглээ)		Хэсэг 6.4 Үйл ажиллагааны хяналт-шинжилгээ	
		Хэсэг 6.5 Баталгаажуулах хяналт-шинжилгээ	

Чиглүүлэх зөвлөмж 5.3-г ДЭМБ-ын 2006 оны удирдамжийн баталгаажуулах хяналт-шинжилгээтэй холбоотой зарим зөвлөмжийг тоймлосон болно.

ЧИГЛҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ 5.3

2006 оны ДЭМБ-ын удирдамжийн баталгаажуулах хяналт-шинжилгээтэй холбоотой зөвлөмжүүд

Бичил биетний хяналттай холбоотой гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ

- E.coli ба цагаан хорхой (гэдэсний ба шистосомын)-н өндөгний хяналт-шинжилгээг 3-6 сар тутам өртөлтийн цэгүүдэд хийнэ [Жич [2]-ыг харна уу]
- Шистосомозын эрсдэлтэй нөхцөлд ажилчид болон орон нутгийн хүн амын дунд халдварын шинж тэмдэг илрүүлэх үзлэг шинжилгээг халдварын тархалт өндөр бол жил тутам, дунд зэрэг бол 2 жилд нэг удаа, бага бол 5 жилд нэг удаа тус тус хийнэ [Жич [2]-ыг харна уу].
- Хүнсэнд түүхийгээр нь хэрэглэдэг загас, ургамал үржүүлдэг усны аж ахуйн цөөрөмд E.coli ба цагаан хорхойн өндөгний баталгаажуулах хяналт-шинжилгээг сар тутам хийнэ [Жич [3]-ыг харна уу].
- Арьс цочроогч хүчин зүйлийн баталгаажуулах хяналт-шинжилгээг хийнэ. Устай байнга харьцдаг усны аж ахуйн ажилчид болон бусад хүнийг арьсны эмчийн үзлэгт 6-12 сар тутам хамруулна [Жич [4]-ийг харна уу].
- Усны аж ахуйн загас, ургамлыг сайтар болгож хүнсэнд хэрэглэдгээс бусад бүх тохиолдолд амьдрах чадвартай трематодын өндөг байгаа эсэхийг заавал шинжилнэ [Жич [1]-ийг харна уу].
- Цөөрмийн усанд вектор байгаа эсэхийг 2-3 сар тутам баталгаажуулна [Жич [4]-ийг харна уу].

Химийн бохирдлын хяналттай холбоотой гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ:

Усны аж ахуйн бүтээгдэхүүн дэх химийн бодисын түвшрүүлгийг баталгаажуулах шинжилгээг хүнсний аюулгүй байдлын асуудал эрхэлсэн эрх бүхий байгууллагаас 6 сар тутам хийнэ [Жич [3]-ыг харна уу].

Жич: 2006 оны ДЭМБ-ын удирдамжийн 3 дугаар ботигос нэмэлт мэдээлэл авна уу: [1] хуудас 40, [2] хуудас 44, [3] хуудас 42, [4] хуудас 45.

ЧИГЛҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ 5.4

ХАА ба усны аж ахуйд ашигладаг химийн бодис

ХАА-д бохир ус хэрэглэсэнтэй холбоотой ялгадас дах эмгэг төрөгч (үүнд цагаан хорхой, шистосом хамаарна) болон вектороор дамждаг эмгэг төрөгчөөр сэдээгдсэн өвчин үүсэх, арьс цочрох эрсдэл бий болдог. Харин химийн бодистой холбоотой эрсдэл бага байхын зэрэгцээ химийн бодис хүний биед удаан хугацааны турш хуримтлагдаж эрүүл мэндийн нөлөө нь хожуу илэрдэг тул эрүүл мэндийн эрсдэлийг өртөгттэй шууд хамаатуулахад төвөгтэй байдаг (2006 оны ДЭМБ-ын удирдамжийн 2 дугаар боть, хуудас 8).

Усны аж ахуйн загас, хүнсний ногоонд баталгаажуулах хяналт-шинжилгээ хийх талаар 2006 оны ДЭМБ-ын удирдамж (3 дугаар ботийн 3.3, 4.1.3 дугаар хэсэг)-аас харна уу.

Бохир усан дахь химийн бохирдуулагчийн нөлөөнд өртөх гол зам бол хүнсний сүлжээ байдаг (2006 оны ДЭМБ-ын удирдамжийн 2 дугаар боть, хуудас 73). Баталгаажуулах хяналт-шинжилгээнд ашигладаг хөрс, загас, хүнсний ногоон дах химийн хортой бодисын зөвшөөрөгдөх хэмжээг Хавсралт 3-т харуулсан байна. Хөрсөн дэх химийн бодисын агууламж зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд бохирдуулагч хүнсний сүлжээгээр дамжин хүний биед нэвтрэх боломжтой юм.

Органик бус химийн бодисын хувьд бохир усаар усалгаа хийх тоолонд хөрсөн дэх агууламж нь аажим нэмэгддэг байна. Гэхдээ Энэтхэгт хийсэн судалгаагаар бохир усыг усалгаанд 30 орчим жил ашигласан тариалангийн талбайд ургасан үр тариан дах хүнд металын агууламж зөвшөөрөгдөх хэмжээнээс бага байжээ (Мага 2004, хуудас 245).

Органик нэгдлийн хувьд бохир усан дах түвшрүүлэг нь маш бага байдаг тул хөрсөнд зөвшөөрөгдөх хэмжээнээс ихээр хуримтлагдах магадлал бага юм. Нэмэлт мэдээллийг 2006 оны ДЭМБ-ын удирдамж (2 дугаар боть, 4.6 ба 8.1 дэх хэсэг)-аас авна уу.

Түнчлэн үндэсний стандарт, хууль тогтоомжийг судлах нь зүйтэй.

ЧИГЛҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ 5.5

Тусгайлсан үнэлгээ

Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ

АЦБАБТ нь ариун цэврийн шинэ томоохон системийг шинээр төлөвлөхөд зориулагддаггүй болно. Ийм нөхцөлд эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ мэтийн тусгайлсан судалгааг төлөвлөлтөд ашиглах нь зүйтэй. Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ гэдэг нь хөгжлийн төсөл хэрэгжүүлснээс үүдэн гарах байгаль орчны ба/буюу нийгмийн томоохон өөрчлөлтөөс өртөмтгий хүн амын эрүүл мэндийг хамгаалах арга хэрэгсэл юм. ДЭМБ-ын тодорхойлсноор эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ гэж “бодлого, хөтөлбөр буюу төслийн хүн амын эрүүл мэндэд үзүүлж болох үр нөлөө, энэхүү үр нөлөөний хүн амын бүлгүүд дэх хуваарилалтын талаар дүгнэлт гаргах арга, ажиглалаа, арга хэрэгслийн нийлбэр”-ийг хэлнэ [Эрүүл мэндийн бодлогын Европын төв, 1999]. Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ нь шийдвэр гаргалтад нөлөөлж, эрүүл мэндийн сөрөг үр дагаврыг аль болох багасгаж, зөрөг үр дагаврыг нэмэгдүүлэх зорилготой олон мэргэжлийн оролцоо шаардсан аргагүй юм. Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний хүрээнд эрүүл мэндийг тодорхойлогч олон хүчин зүйл, эрүүл мэндийн олон үр дагаврыг харгалзаж үзэж, тоон ба чанарын аргыг хослуулан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний чиглэлийг тогтоохыг зорьдог байна.

Сонирхогч талуудын оролцоог хангах нь эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний гол шинж юм.

Ариун цэврийн томоохон системийг шинээр төлөвлөхөд нийгмийн эрүүл мэндийн үүднээс хамгийн тохиромжтой сонголтыг хийхэд эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ тус дөхөм болно. Түнчлэн эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ нь тухайн төслийн бүхий л шат [ө.х. барих, ажиглуулах, хаах]-нд гарч болох эрүүл мэндийн үр дагавруудыг системтэйгээр тодорхойлдог. Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний үр дүнд [1] ариун цэврийн системийн дизайныг боловсронгуй болгох санал, [2] эрүүл мэндийн сөрөг нөлөөллийг бууруулах, зөрөг нөлөөллийг нэмэгдүүлэх арга хэмжээний санал, [3] ариун цэврийн системийг нэвтрүүлснээр нийгмийн эрүүл мэндэд үзүүлэх үр нөлөөг цаашид үнэлэх суурь үзүүлэлтүүдийг боловсруулсан байна.

АЦБАБТ-г голдуу системийн операторууд хийж гүйцэтгэдэг бол эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээг нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнүүд хийж гүйцэтгэдэг байна. Эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний талаар нэмэлт мэдээллийг 2006 оны ДЭМБ-ын удирдамжийн 2 дугаар ботгийн Хавсралт 3, ДЭМБ-ын эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний вэбсайт [http://www.who.int/hia/en/-аас авна уу.

Микробын эрсдэлийн тоон үнэлгээ

Микробын эрсдэлийн тоон үнэлгээ гэдэг нь тодорхой бичил биетэнтэй холбоотой аюулт хүчин зүйлд өөр өөр замаар өртсөнөөс бий болох эрсдэлийг үнэлэх арга юм. Үүнийг тухайн хүн ам (ж.нь, усалгаанд бохир ус ашигладаг тариаланчид)-ын дунд өвчнийг судлах тархварзүйн судалгаанд нэмэлтээр ашиглаж болдог. Энэ аргыг мөн эрүүл мэндийн шалгуур үзүүлэлтийн зорилтот түвшинг тогтооход хэрэглэдэг. Үндэсний түвшинд эдгээр зорилт нь ариун цэврийн системтэй холбоотой өвчлөлийн зөвшөөрөгдөх хэмжээг тогтоож өгдөг байна. Харин системийн түвшинд эмтэг төрөгчийн хорогдлын зорилтот түвшинг тогтоох үнэлгээний болон баталгаажуулалтын арга болгон ашиглах боломжтой.

Ихэнх тохиолдолд микробын эрсдэлийн тоон үнэлгээг системийн операторууд хийж чадахгүй, харин нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнүүд хийх боломжтой. Нэмэлт мэдээллийг Наас ба бусад (1999), WHO (2011) зэрэг эх сурвалжуудаас авна уу.

ЧИГЛҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ 5.6

Аудитад харгалзан үзэх асуултууд

- Бүх ноцтой аюулт хүчин зүйл, аюулт үзэгдлийг тодорхойлж чадсан уу?
- Зохих хяналтын арга хэмжээг тусгасан уу?
- Үйл ажиллагааны хяналт-шинжилгээний зохих процедурьг тогтоосон уу?
- Үйл ажиллагааны үзүүлэлт болон зөвшөөрөгдөх хэмжээг тогтоосон уу?
- Залруулах арга хэмжээг тодорхойлсон уу?
- Баталгаажуулах хяналт-шинжилгээний зохих процедурьг тогтоосон уу?
- Хүний эрүүл мэндэд хамгийн халтай аюулт үзэгдлүүдийг тодорхойлж, зохих арга хэмжээ авсан уу?

АРГА ХЭРЭГСЭЛ 5.1

Үйл ажиллагааны хяналт-шинжилгээний төлөвлөгөөний тойм хэсэг (загвар)

Ариун цэврийн алхам	Үйл ажиллагааны хяналт-шинжилгээний дэлгэрэнгүй төлөвлөгөө боловсруулах шаардлагатай хяналтын арга хэмжээнүүд Зааварчилгаа: Дэлгэрэнгүй төлөвлөгөө боловсруулах шаардлагатай хяналтын арга хэмжээнүүдийг жагсааж, Арга хэрэгсэл 5.2-ыг ашиглан тус бүрт нь тохирсон дэлгэрэнгүй төлөвлөгөө боловсруулна
Божир үүсэх	
Божирьг дамжуулах / тээвэрлэх	
Цэвэрлэх / боловсруулалт хийх	
Ашиглах буюу зайлуулах	
Бүтээгдэхүүнийг хэрэглэх	

АРГА ХЭРЭГСЭЛ 5.2

Үйл ажиллагааны хяналт-шинжилгээний дэлгэрэнгүй төлөвлөгөө (загвар)

Үйл ажиллагааны хяналт-шинжилгээний төлөвлөгөө

Үйл ажиллагааны хяналт-шинжилгээний төлөвлөгөөний хамрах хүрээ:

Хяналтын арга хэмжээний товч тайлбар	
Зөвшөөрөгдөх хэмжээ*	Хяналтын арга хэмжээний үйл ажиллагааны хяналт-шинжилгээ
	Хяналтын арга хэмжээ
	Юуг хянах?
	Хэрхэн хянах?
	Хаана хянах?
	Хэн хянах?
	Хэзээ хянах?
	Зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн үед
	Залруулах арга хэмжээ
	Ямар арга хэмжээ хэрэгжүүлэх?
	Хэн хэрэгжүүлэх?
	Хэзээ хэрэгжүүлэх?
	Хэнд мэдэгдэх?

* зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн бол хяналтын арга хэмжээ зорилгалтын дагуу ажиглахгүй байна гэж үзнэ

ЖИШЭЭ 5.1

Үйл ажиллагааны хяналт-шинжилгээний төлөвлөгөө: бордооны үйлдвэр, Вьетнам

Бордооны үйлдвэрийн үйл ажиллагааны хяналт-шинжилгээний төлөвлөгөө

Үйл ажиллагааны хяналт-шинжилгээний төлөвлөгөөний хамрах хүрээ:

Ажилчид, менежерүүдийн техникийн арга ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх

Хяналтын арга хэмжээний товч тайлбар

Зөвшөөрөгдөх хэмжээ	Хяналтын арга хэмжээний үйл ажиллагааны хяналт-шинжилгээ		Зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн үед	
	Хяналтын арга хэмжээ: Цэвэрлэх байгууламж		Заглуулах арга хэмжээ	
Техникийн арга ажиллагааг 100% зааврын дагуу хийж гүйцэтгэх	Юуг хянах?	Практик ажиллагаа	Ямар арга хэмжээ хэрэгжүүлэх?	Ажилчдад сануулга өгөх, бүртгэл хөглөх
	Хэрхэн хянах?	Ажиллалт	Хэн хэрэгжүүлэх?	Чанарын албаны менежер, ажилчид
	Хаана хянах?	Ажлын байранд	Хэзээ хэрэгжүүлэх?	24 цагийн дотор
	Хэн хянах?	Чанарын албаны менежер, ажилчид	Хэнд мэдэгдэх?	Чанарын албанд сар тутам тайлагнана
	Хэзээ хянах?	Сард ядаж 1 удаа		

ЖИШЭЭ 5.2

Баталгаажуулах хяналт-шинжилгээний сорьц цуглуулах хөтөлбөр:
бордооны үйлдвэр, Вьетнам


Сорьц цуглуулах байршил	Сорьцны тоо / 3 сард	Үзүүлэлт
Олон нийтийн бие засах газар орчмын хөрсний сорьц	3	
Цэвэрлэх байгууламж руу нийлүүлж буй өгтөн лаг	2	E.coli
Цэвэрлэх байгууламжаас гарч буй бохир усны сорьц	2	Цагаан хорхойны өндөг
Тундасны сорьц	2	
Вакуум цистерний хоолойноос авсан усны сорьц	2	
Элсийн бүтээгдэхүүн (бордоо)	2	

Жич: 2006 оны ДЭМБ-ын зөвлөмжид энэхүү жишээнд тохирсон баталгаажуулах хяналт-шинжилгээний давтамжийн талаар зөвлөмж өгөөгүй байна. АЦБАБГ-ний нөхцөл байдал, нөөцийн болгомжийг харгалзан давтамжийг өөрсдөө тогтоосон

ЖИШЭЭ 5.3

Баталгаажуулах хяналт-шинжилгээний төлөвлөгөө

Ариун цэврийн алхам		Баталгаажуулах хяналт-шинжилгээ			
	Юу	Зөвшөөрөгдөх хэмжээ	Хэзээ	Хэн	Арга
Бохирын үүсэх	Бохирын системд нийлүүлж буй үйлдвэрийн хэвдлын тоо, чанар	Орон нутгийн хууль тогтоомжид заасан	Байнгын	Ариутгах татuurгын компани буюу хяналтын байгууллага	Жилийн тайлан
Бохирын тээвэрлэлт	Халилтын тоо, жилд	Орон нутгийн нөхцөл байдлаас хамаарна	Жил тутам	Ариутгах татuurгын компани буюу хяналтын байгууллага	Жилийн тайлан
Орон нутгийн болон дараагийн шатны ЭМТ-ийн бүртгэл мэдээлэлд 2 жил тутам дүн шинжилгээ хийсэн.
Мөн хэрэглэгчдийн судалгааг жил тутам хийхээр шийдвэрлэсэн байна.

Модуль 5.2 Системийн аудит хийх нь

Төлөвлөгөөг 2 жил хэрэгжүүлж, тодорхой хэмжээний туршлага хуримтлуулсны аудитын шаардлагыг эргэн харахаар шийдвэрлэсэн.

Баталгаажуулах стратегийг тодорхойлохдоо бид ЭМТ, Ньютауны хотын захиргааны зүгээс шинжилгээ хийх боломж хязгаарлагдмал байгааг хэргэлсэн үзсэн. Одоогийн шатанд үр тарианы микробиологийн шинжилгээ хийх нь боломжгүй боловч цаашид АДАБТ-ийн эхний тойм үнэлгээ хийхээс өмнө ийнхүү шинжилдэг болоход Удирдах зөвлөл анхаарах ёстой.

Аудитын ач холбогдлыг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ бидэнд одоогоор энгийн дотоод аудит ч хийх туршлага байхгүй тул бид энэхүү шийдвэрийг гаргасан болно. Гэхдээ бид дараагийн 2 жилд энэ чиглэлээр чадавхи бэхжүүлэхээр ажиллана.

Модуль 6. Дэмжих хөтөлбөр боловсруулж, төлөвлөгөөнд тойм үнэлгээ хийх нь

Модуль 6.1 Дэмжих хөтөлбөр, удирдлагын ажиллагааны удирдамжийг боловсруулж, хэрэгжүүлэх нь

Дэмжих хөтөлбөрүүд:

- Ажилчид (ж.нь, цэвэрлэх байгууламжийн операторууд, вакуум цистерний операторууд)-д зориулсан эрүүл мэндийн болон аюулгүй байдлын сургалтуудыг ажилд ороход нь баримжаа олгох сургалт хэлбэрээр, улмаар жил болгон давтан сургалт хэлбэрээр зохион байгуулах.
- Жилийн тайлан гаргах, Удирдах зөвлөлийн хурал, нээлттэй хаалганы өдөр зохион байгуулах замаар АЦБАБТ-г хэрэгжүүлсний үр дүн, нотолгоог олон нийт, сонирхогч талуудад танилцуулах
- Өртөгтгий бүлгүүдэд сургалт зохион байгуулж, зан үйлийн өөрчлөлтийг хэвшүүлэх
- Засвар үйлчилгээг тогтмол хийх
- Олон нийтийн МСС-ны кампанит ажил зохион байгуулах
- ХАА-д усны хэрэглээг үр ашигтай болгох талаар сургалт зохион байгуулах

Удирдлагын ажиллагаа

- Төрөл бүрийн стандартаг ажиллагсааны удирдамж боловсруулах, тухайлбал
 - Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа (ж.нь, ил цөөрмийн дэргэд ажиллах үед баримтлах аюулгүй ажиллагсааны дүрэм, шахуургын засвар хийх удирдамж, хувийн хамгаалах хэрэгсэл хэрэглэх заавар)
 - Бохир усны тээвэрлэлт
 - Бохирыг тогтворжуулах цөөрмийн лагийг цэвэрлэх ажиллагаа
- Үйл ажиллагаа, засвар үйлчилгээ, шинжилгээний хуваарь

Модуль 6.2 АЦБАБТ -г тоймлон үнэлж, тодотгох нь

Төлөвлөгөөг хэрэгжүүлж эхэлснээс хойш 2 жилийн дараа эхний тойм үнэлгээг хийнэ.

Эдгээр нь мэдээж Ньютауны онцлогт тохирсон хөтөлбөр, стандартаг ажиллагаа юм.

Ус хангамжийн системд тогтсон хөтөлбөр, ажиллагаа нэлээд байгаа хэдий ч арвин цэврийн салбарт сайжруулах зүйл олон байгааг бид олж харсан. Бид зорилгоо (Модуль 1.1) хэрэгжүүлэхийн тулд ХАА-н үйл ажиллагаа, хэрэглэгчдийн эрүүл мэнд, арин цэврийн инженерийн асуудалд анхаарах ёстой. Гол бэрхшээл төсвийн хязгаарлагдмал байдлаар хойно болгох байх.



НОМ ЗҮЙ

- Armath P et al. Low-cost options for reducing consumer health risks from farm to fork where crops are irrigated with polluted water in West Africa. Colombo, Sri Lanka, International Water Management Institute (IWMI), 2011.
- European Centre for Health Policy. Health impact assessment: main concepts and suggested approach. Gothenburg consensus paper. Copenhagen: WHO Regional Office Europe, 1999.
- Haas C, Rose J, Gerba C. Quantitative microbial risk assessment. New York, John Wiley, 1999.
- Kato S, Fogarty E, Bowman DD. Effect of aerobic and anaerobic digestion on the viability of *Cryptosporidium parvum* oocysts and *ascaris suum* eggs. *International Journal of Environmental Health Research*, 2003, 13(2): 169–179.
- Kengne JM, Akoa A, Kone D. Recovery of biosolids from constructed wetlands used for faecal sludge dewatering in tropical regions. *Environmental Science and Technology*, 2009, 43 6816–6821.
- Kone D et al. Helminth eggs inactivation efficiency by faecal sludge dewatering and co-composting in tropical climates. *Water Research*, 2007, 41:4397–4402.
- Mahassen M et al. Performance evaluation of a waste stabilization pond in a rural area in Egypt. *American Journal of Environmental Sciences*, 2008, 4: 316–325.
- Mara D. Domestic wastewater treatment in developing countries. London, Earthscan, 2004.
- Nielsen S. Helsingør sludge reedbeds systems: Reduction of pathogenic organisms. *Water, Science and Technology*, 2007, 56(3):175–182.
- Stenström TA et al. Microbial exposure and health assessments in sanitation technologies and systems. Stockholm, Stockholm Environment Institute, 2011.

Thompson I, Fawell J, Kunikane S, Jackson D, Appleyard S, Callan P et al. Chemical safety of drinking-water: assessing priorities for risk management. Geneva, World Health Organization, 2007. http://wtrqibdoc.who.int/publications/2007/9789241546768_eng.pdf

USEPA Sewage sludge use and disposal rule (40 CFR Part 503), Publication Number 822F92002. USA, United States Environmental Protection Agency, 1992.

WHO Guidelines for the safe use of wastewater, excreta and greywater. Geneva, World Health Organization, 2006. www.who.int/water_sanitation_health/wastewater/gsuww/en

WHO Guidelines for drinking-water quality, fourth edition. Geneva, World Health Organization, 2011. http://www.who.int/water_sanitation_health/dwq/en/



НЭМЭЛТЭЭР УНШИХ ЗҮЙЛ

- Bartram J, Corrales L, Davison A, Deere D, Dury D, Gordon B et al. (2009). Water safety plan manual: step-by-step risk management for drinking water suppliers. Geneva, World Health Organization.
- Bartram J, Fewtrell L, Stenstrom T (2001). Harmonized assessment of risk and risk management for water-related infectious disease: an overview. In: Fewtrell L, Bartram J, editors. Water quality: Guidelines, standards and health. London, IWA Publishing, 1–16.
- Campros L, Ross P, Nasir Z, Taylor H, Parkinson J. (in press) Development and application of a methodology to assess sanitary risks in Maputo, Mozambique. Special Issue of Environment And Urbanization "Sanitation And Drainage For Cities", October 2015
- Drechsel P., C.A. Scott, L. Raschid-Sally, M. Redwood and A. Bahri (eds.) 2010. Wastewater irrigation and health: Assessing and mitigation risks in low-income countries. Earthscan-IDRC-IWMI, UK, London, 404 pp.
- Emory University. Sanipath rapid assessment tool. Atlanta, Emory University Centre for Global Safe Water, 2014. (<http://www.sanipath.com>, сүүлд хандсан огноо: 2015.01.23).
- Fuhlimann S, Winkler M, Schneeberger P, Niwagaba C, Vuwile J, Babu M et al. (2014) Health risk assessment along the wastewater and faecal sludge management and reuse chain of Kampala, Uganda: a visualization. Geospatial Health, 9:251–255 (<http://www.geospatialhealth.net/index.php/gch>, сүүлд хандсан огноо: 2015.01.15).
- Scheierling S, Bartone C, Mara D, Drechsel P (2010). Improving wastewater use in agriculture: an emerging priority. World Bank (Working paper WPS5412) (<http://hdl.handle.net/10986/3897>, сүүлд хандсан огноо: 2014.12.11).

Strande L, Ronteltap M, Vrdjanovic D, editors (2014). Faecal sludge management systems approach for implementation and operation. London, IWA Publishing (http://www.eawag.ch/forschung/sandec/publikationen/index_EN, сүүлд хандсан огноо: 2015.01.15).

Tilley E, Ulrich L, Lythi C, Reymond P, Zurbrugg C (2008). Compendium of sanitation systems and technologies, 2nd revised edition. Switzerland, Eawag (http://www.eawag.ch/forschung/sandec/publikationen/index_EN, сүүлд хандсан огноо: 2015.01.15).

WHO Guidelines for the safe use of wastewater, excreta and greywater. Geneva, World Health Organization, 2006

WHO HIA website. Geneva, World Health Organization (<http://www.who.int/hia/en/>, сүүлд хандсан огноо: 2015.01.15).

WHO Water safety planning for small community water supplies: Step-by-step risk management guidance for drinking-water supplies in small communities. Geneva, 2012 (http://www.who.int/water_sanitation_health/publications/2012/water_supplies/en/index.html, сүүлд хандсан огноо: 2012.12.19).



ХАВСРАЛТ 1

Биологийн аюулт хүчин зүйлийг хянах арга хэмжээний жишээ

ЦЭБАБТ-д ашиглаж болох хяналтын арга хэмжээний жишээг энд нэгтгэсэн болно. Хяналтын арга хэмжээний үр дүнтэй эсэхийг МАШ БАГ-аас ИХ хүртэл үнэлсэн.

А1-1 Бохир усны цэвэрлэлт

Хүснэгт А1-1 Бохир усны цэвэрлэлттэй холбоотой хяналтын арга хэмжээ

Сонгох хүснэгд	Үр дүн, log бууралт	Тайлбар	Нэмэлт эх сурвалж
Бохирыг гогтгосруулах цөөрм, агааржуулах цөөрм, бохир усны халдварт ба сан	ИХ 2-5 нэгж	<p>Үр дүн нь халдвартын хугацаа, ачааллах хурд, хорих хугацаа, тундасжилтын үр дүнтэй байдал зэргээс хамаардаг.</p> <p>Ажилчид, оршин суугчдын эрсдэлийг бууруулахын тулд холбогдох дараах асуудалд анхаарна:</p> <ul style="list-style-type: none"> • Шүүмүүл үржихээс сэргийлэх • Шистосомын завсрын эзэн эмгэн хумс үржихээс сэргийлэх • Хашаагаар тусгаарлах • Цөөрмөөс үс нэвчиж, Гүний усыг бохирдуулахаас сэргийлэх (ж.нь, цөөрмийг шавар буюу бусад халгалгах материалгаар доторлох) 	<p>Mahassen et al. (2008). Stenstrup et al. (2011), 68-70, 79, 129-130. WHO (2006) Vol. 2, 84-87</p>
Хиймэл намат	Дүнд ЗЭРЭГ 1-3 нэгж	<p>Үр дүн нь дизайны (ж.нь, гадаргуун эсүүл гадаргуун дээрх урсгалтай намат), ачаалал, хорих хугацаа зэргээс хамаардаг.</p> <p>Ажилчид, оршин суугчдын эрсдэлийг бууруулахын тулд холбогдох дараах асуудалд анхаарна:</p> <ul style="list-style-type: none"> • Шүүмүүл үржихээс сэргийлэх • Шистосомын завсрын эзэн эмгэн хумс үржихээс сэргийлэх • Ургамлын ургалтыг хянах • Амьтны ялгадсаар бохирлогдохоос хамгаалах • Намгаас үс хальж, Гүний усыг бохирдуулахаас сэргийлэх 	<p>Stenstrup et al. (2011), 71-72, 79, 131-132. WHO (2006) Vol. 2, 87.</p>
Биологийн хиймийн цэвэрлэлт	Дүнд ЗЭРЭГ 1-3 нэгж	Хяналтын арга хэмжээний үр дүн дизайнаас хамаарна.	<p>Stenstrup et al. (2011), 73-75. WHO (2006) Vol. 2, 82-84 & Table 5.3.</p>
Амьсан түвшний цэвэрлэлт	ИХ 2->6 нэгж		

А1-2 Бохир усыг ХАА-д ашиглах

Бохир усыг ашиглахад тариаланчид, ажигчид, оршин суугчдын эрсдэлээс хамгаалах дараах асуудлыг анхаарвал зохино. Үнд:

- Бохир ус цэвэрлэх, хадгалах байгууламжийг өвчин дамжуулагч амьтан, шавж нэвтрэхээс хамгаалах
- Тариалангийн талбай зэрэгт бохир ус тогтож, вектор үржихээс сэргийлэх
- Үр тарианы эрэлт хэрэгцээг хангахуйц хэмжээгээр бохир усыг ашиглах

Хүснэгт А1-2 Бохир усыг ХАА-д ашиглахтай холбоотой хяналтын арга хэмжээ

Сонгох хувилбар	Үр дүн, лог бууралт	Тайлбар	Нэмэлт эх сурвалж
Цэвэрлээгүй бохир ус ашиглах	МАШ БАГА – БАГА	Цэвэрлээгүй бохир усыг хэзээ ч аюулгүйд тооцож болохгүй. Өргөмтгий бүлгийн хүн амын эрсдэлийг бууруулахын тулд холбогдох дараах асуудалд анхаарна: <ul style="list-style-type: none"> • Хэрэглээнд хязгаарлалт тогтоох • Хэсэг газрын (ж.нь, дуслын) усжуулалт • Ургац хураалтын өмнөх усалгааны хяналт (ж.нь, ургац хураахаас тодорхой хугацааны өмнө усалгааг зогсоох) • Хүнсэнд хэрэглэхээс өмнө эмгэг төрөгчийг үхүүлэх (ж.нь, хамгийн сүүлд усалснаас хойш хүнсэнд хэрэглэх хүртэл заавал хүлээх хугацааг тогтоож мөрдөх) • Ургац хураах ба хураасны дараах хяналтын арга хэмжээ • Цэвэрлэх технологи нэвтрүүлэх 	WHO (2006) Vol. 2, 89-91
Бохир усны чанартай уялдуулан үр тариаг сонгох	ИХ	Үр дүн дараах зүйлээс хамаарна: <ul style="list-style-type: none"> • Үр тарианы зориулалт (ж.нь, хөвөн, тосны ургамал зэрэг хүнсэнд хэрэглэхэд зориулагдаагүй үр тарианы хувьд зарим эрсдэл хамааралгүй байна) • Тариалалт, усжуулалтын бүсэд хүн нэвтрэх боломж (ямар нэг хязгаарлалт байхгүй байх тусам эрсдэл нэмэгдэнэ) • Хэрэглээнд тогтоосон хязгаарлалтыг мөрдөх 	WHO (2006) Vol. 1, 24. WHO (2006) Vol. 2, 76.
Бохир ус ашиглах арга: гадаргуйн доорх усжуулалт	ИХ	Энэ арга нь: <ul style="list-style-type: none"> • Тариаланчдын өртөлтийг багасгадаг • Үндсэнд илүү ус шингэхэд нөлөөлдөг • Усны үр дүнтэй хэрэглээг дэмждэг • Бөглөрдөггүй дамжуулалтын хоолой эсхүл шүүлтүүр ашиглаж, бөглөрөхөөс сэргийлэхийг шаарддаг Энэ арга нь бохир усанд өртөх явдлыг, мөн усны хомсдолтой газар усны алдагдлыг бууруулах ач холбогдолтой. Гэхдээ шугам хоолой бөглөрснөөс буюу гэмтсэнээс болж бохир ус гадаргуйд ил гарах, тогтонгишихоос сэргийлэх шаардлагатай.	WHO (2006) Vol. 1, 26. WHO (2006) Vol. 2, 76.
Бохир ус ашиглах арга: хэсэг газрын дуслын усжуулалт (өндөр ургалттай үр тарианы хувьд)	ИХ	Энэ аргыг ашиглахдаа: <ul style="list-style-type: none"> • Дуслын нүх бөглөрөхөөс сэргийлнэ • Бохирдлоос сэргийлэхийн тулд хураасан ургацыг түр зуур газар дээр орхиж явдлыг аль болох бууруулна • Ус тогтонгишихоос сэргийлнэ • Галтар хучлагаар бүтээж үр дүн, үр ашгийг нэмэгдүүлнэ Хураасан ургацыг газар дээр орхиж, хадгалах нь бусад хяналтын арга хэмжээний үр дүнг үгүй хийж хэмжээнд үр тариаг бохирдуулах эрсдэлтэй.	Stenstrup et al. (2011), 93. WHO (2006) Vol. 1, 26.



Сонгох хувилбар	Үр дүн, юг бууралт	Тайлбар	Нэмэлт эх сурвалж
<p>Бохир ус ашиглах арга: хэсэг газрын дуслын усжуулалт (нам дор ургалттай үр тарианы хувьд)</p>	<p>ДУНД ЗЭРЭГ 2 нэгж</p>	<p>Эрсдэлийг бууруулах үр дүн нь үр тарианы төрөл (ж.нь, үндсэрхэг эсхүл навчит ногоо, түүхийгээр эсхүл чанаж хүнсэнд хэрэглэдэг), тариалалтын арга (механикжсан байдла)-аас хамаардаг.</p> <p>Энэ аргыг ашиглахдаа:</p> <ul style="list-style-type: none"> Гялгар хуцлагаар бүтээж үр дүнг нэмэгдүүлнэ Дуслын нүх бөглөрөхөөс сэргийлнэ Ус тогтонгишихоос сэргийлнэ Усжуулалтын цэгтэй үр тариа хүрэлцэхээс сэргийлнэ Бохирдлоос сэргийлэхийн тулд хураасан ургалыг түр зуур газар дээр орхих явдлыг аль болох бууруулна <p>Хураасан ургалыг газар дээр орхих, хадгалах нь бусад хяналтын арга хэмжээний үр дүнг үгүй хийх хэмжээнд үр тариаг бохирдуулах эрсдэлтэй.</p>	<p>Stenstrup et al. (2011), 93. WHO (2006) Vol. 1, 26.</p>
<p>Бохир ус ашиглах арга: халиах усжуулалт</p>	<p>БАГА – ДУНД ЗЭРЭГ</p>	<p>Эрсдэлийг бууруулах үр дүн нь үр тарианы төрөл (ж.нь, үндсэрхэг эсхүл навчит ногоо, түүхийгээр эсхүл чанаж хүнсэнд хэрэглэдэг), тариалалтын арга (механикжсан байдла)-аас хамаардаг. Өргөмтгий бүлгийн хүн амын эрсдэлийг бууруулахын тулд холбогдох дараах асуудалд анхаарна:</p> <ul style="list-style-type: none"> Хөрс угаагдах, гадаргуйн ус руу урсаж орохоос сэргийлж усалгаанд ашиглах усны хэмжээг хянах Сүүлийн усалгаа ба ургац хуралтын хоорондын хугацааг хянах Борлоо орох үед дөтөлдөх эрсдэлтэй <p>Үүнээс гадна:</p> <ul style="list-style-type: none"> Ус тогтонгишихоос сэргийлнэ Бохирдлоос сэргийлэхийн тулд хураасан ургалыг түр зуур газар дээр орхих явдлыг аль болох бууруулна <p>Хураасан ургалыг газар дээр орхих, хадгалах нь бусад хяналтын арга хэмжээний үр дүнг үгүй хийх хэмжээнд үр тариаг бохирдуулах эрсдэлтэй.</p>	<p>WHO (2006) Vol. 1, 23.</p>
<p>Бохир ус ашиглах арга: (өндөр даралттай) шурших усжуулалт</p>	<p>БАГА – ДУНД ЗЭРЭГ</p>	<p>Үр дүн нь дараах зүйлээс хамаарна:</p> <ul style="list-style-type: none"> үр тарианы төрөл (ж.нь, үндсэрхэг эсхүл навчит ногоо, түүхийгээр эсхүл чанаж хүнсэнд хэрэглэдэг) суурьшлын бүс, тариаланчдын байршилыг харгалзан усжуулах системийг суурьлуулсан байдал усалгааны усны чанар, цэвэршүүлэлт <p>Дараах асуудалд анхаарна:</p> <ul style="list-style-type: none"> Суурьшлын бүсээс 50–100 м зайтай буфер бүс бий болгох (логарифм бууралт – 1 нэгж) Салхины хурд, чиглэл зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтэрсэн үед усжуулалтыг зогсоох Сүүлийн усалгаа ба ургац хуралтын хоорондын хугацааг хянах Бохирдлоос сэргийлэхийн тулд хураасан ургалыг түр зуур газар дээр орхих явдлыг аль болох бууруулах Хөрс угаагдах, гадаргуйн ус руу урсаж орохоос сэргийлж усалгаанд ашиглах усны хэмжээ, бордоо ашиглалтыг хянах <p>Хураасан ургалыг газар дээр орхих, хадгалах нь бусад хяналтын арга хэмжээний үр дүнг үгүй хийх хэмжээнд үр тариаг бохирдуулах эрсдэлтэй.</p>	<p>Stenstrup et al. (2011), 91-93. WHO (2006) Vol. 2, 64.</p>

Сонгох хувилбар	Үр дүн, юг бууралт	Тайлбар	Нэмэлт эх сурвалж
Бохир ус ашиглах арга: (Нам, даралттай) шурших усжуулалт	БАГА – ДУНД ЗЭРЭГ	<p>Үр дүн нь дараах зүйлээс хамаарна:</p> <ul style="list-style-type: none"> • Үр тарианы төрөл (ж.нь, үндсэрхэг эсхүл навчит ногоо, түүхийгээр эсхүл чанаж хүнсэнд хэрэглэдэг) • Суурьшлын бүс, тариаланчдын байршиллыг харгалзан усжуулах системийг сууриллуулсан байдал • Усалгааны усны чанар, цэвэрлэлт <p>Дараах асуудалд анхаарна:</p> <ul style="list-style-type: none"> • Сүүлийн усалгаа ба ургац хуралтын хоорондын хугацааг хянах • Бохирдлоос сэргийлэхийн тулд хураасан ургацыг түр зуур газар дээр орхих авдлыг аль болох бууруулах • Бордоо ашиглалтыг хянах • Нэгж талбайд ногдох усалгааны усны хэмжээг хянах 	<p>Stensittim et al. (2011), 91–93. WHO (2006) Vol. 2, 64. Atgoh et al. (2011).</p>
Бохир ус ашиглах арга: тариман талбай дах цөөрмөөс саваар ус зөөж услах (хүнсний ногоо ба үндсэрхэг үр тариа)	БАГА	<p>Үр дүн нь дараах зүйлээс хамаарна:</p> <ul style="list-style-type: none"> • Усалгааны усны чанар, цэвэрлэлт • Услах арга • Сүүлийн усалгаа ба ургац хуралтын хоорондын хугацаа <p>Дараах асуудалд анхаарна:</p> <ul style="list-style-type: none"> • Бохирдлоос сэргийлэхийн тулд хураасан ургацыг түр зуур газар дээр орхих авдлыг аль болох бууруулах • Гадагшгүйн ус руу урсаж орохоос сэргийлж усалгаанд ашиглах усны хэмжээ, бордоо ашиглалтыг хянах <p>Тариман талбай дах цөөрөмд бохир усыг тодорхой хугацаанд барьснаар колиформын логарифм бууралтыг 1–1.5 нэгжид хүргэх боломжтой.</p> <p>Үүн дээр элсэн шүүлтүүрийг нэмбэл колиформын логарифм бууралтыг 2 нэгж, хялгасан хорхойн өндөгний логарифм бууралтыг 0.5–1.5 нэгжид хүргэх боломжтой</p>	<p>Atgoh et al. (2011).</p>
Эмгэг төрөлчийг үхүүлэх долоо хоногийн хугацаа: Ургац хураахаас тодорхой хугацааны өмнө усалгааг зогсоох	ДУНД ЗЭРЭГ – ИХ	<p>Логарифм бууралт нь үр тарианы төрөл, температурас хамаарах ба газар болон өөр өөр байдаг. Жишээ 3.3-с дэлгэрэнгүй тайлбарын харна уу.</p>	<p>Stensittim et al. (2011), 93. WHO (2006) Vol. 1, 32.</p>
Зарахаас өмнөх үр тариаг тодорхой хугацаанд хадгалалт	ДУНД ЗЭРЭГ	<p>Үр дүн нь дараах зүйлээс хамаардаг:</p> <ul style="list-style-type: none"> • Хадгалалтын нөхцөл (ж.нь, хадгалалтын явцад нэмж бохирлогдох, уур амьсгалын нөхцөл) • Хорт шавьж нэвтрэх боломж • Хадгалалтын хугацаа <p>“Эмгэг төрөлчийг үхүүлэх долоо хоногийн хугацаа”-тай хослуулбал – үр дүн ИХ</p>	
Бусад аюулгүй харьцах ажиллагаа	Чухал боловч тооцоогүй	<p>А1–7 дугаар хэсгээс харна уу. Эрсдэл хэр буурахыг тооцоолгүй боловч чухал эерэг үр нөлөөтэй гэж үздэг</p>	<p>WHO (2006) Vol. 2, Chapter 5.5.</p>
Ургац хураасны дараах өртөлтийг хянах арга хэмжээ	ДУНД ЗЭРЭГ – ИХ 2–7 нэгж	<p>А1–7 дугаар хэсгээс харна уу. Үндд удаан хугацаагаар хадгалах, угааж цэвэрлэх, хальслах, чанаж зэрэг арга хэмжээ хамаарна.</p>	<p>WHO (2006) Vol. 2, Chapter 5.4.</p>



А1-3 Бохир усыг усны аж ахуйд ашиглах

Хүснэгт А1-3 Бохир усыг усны аж ахуйд ашиглахтай холбоотой хяналтын арга хэмжээ

Сонгох хувилбар	Үр дүн, лог бууралт	Тайлбар	Нэмэлт эх сурвалж
Цөөрмийн усны чанар: E.coli: 100 мл-д <103 Цагаан хорхойн өндөг 1 л-д <1	ИХ	<ul style="list-style-type: none"> Бохир усыг ийм түвшинд цэвэрлэсэн тохиолдолд ажилчид, хэрэглэгчдийг бүрэн хамгаалах ба нэмэлт хяналтын арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагагүй Шистосомозын голомттой нутаг дэвсгэрт завсрын эзэн болох эмгэн хумсыг устгах физикийн, химийн буюу биологийн арга хэмжээ хэрэгжүүлэх нь зүйтэй Шүүмүүл зэрэг вектор үржихээс сэргийлэх арга хэмжээ авах Амьдрах чадвартай трематодын өндөг илрүүлэх шинжилгээний талаар ДЭМБ-ын 2006 оны удирдамжийн 3 дугаар ботийн 40 дүгээр хуудаснаас харна уу 	<p>WHO (2006) Vol. 3, 39-45.</p>
Цөөрмийн усны чанар: E.coli: 100 мл-д <104 Цагаан хорхойн өндөг 1 л-д <1	ДУНД ЗЭРЭГ – ИХ	<ul style="list-style-type: none"> Бохир усыг ийм түвшинд цэвэрлэсэн тохиолдолд хэрэглэгчид хамгаалагдах боловч ажилчдыг хамгаалах нэмэлт арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай Шистосомозын голомттой нутаг дэвсгэрт завсрын эзэн болох эмгэн хумсыг устгах физикийн, химийн буюу биологийн арга хэмжээ хэрэгжүүлэх нь зүйтэй Шүүмүүл зэрэг вектор үржихээс сэргийлэх арга хэмжээ авах Амьдрах чадвартай трематодын өндөг илрүүлэх шинжилгээг системийн баталгаажуулалтын шатанд хийнэ. Усны аж ахуйд үржүүлсэн загас, усны ургамлыг сайтар чанаж хүнсэндээ хэрэглэдэг бол трематодын өндөг илрүүлэх шинжилгээ хийх шаардлагатай. Амьдрах чадвартай трематодын өндөг илрүүлэх шинжилгээний талаар ДЭМБ-ын 2006 оны удирдамжийн 3 дугаар ботийн 40 дүгээр хуудаснаас харна уу 	<p>A1-7. WHO (2006) Vol. 3, 39-45.</p>
Цэвэрлээгүй буюу хагас цэвэрлэсэн бохир ус	ДУНД ЗЭРЭГ (хяналтын арга хэмжээ хэрэгжүүлсэн бол, эс бөгөөд – БАГА)	<ul style="list-style-type: none"> Зөвхөн чанаж хүнсэндээ хэрэглэдэг загасны төрлийг үржүүлэх Загасан бүтээгдэхүүнийг зарж борлуулахаас өмнө боловсруулалт хийх шаардлагатай Ажилчдыг хамгаалах арга хэмжээний талаар А1-7 дугаар хэсгээс харна уу Шистосомозын голомттой нутаг дэвсгэрт завсрын эзэн болох эмгэн хумсыг устгах физикийн, химийн буюу биологийн арга хэмжээ хэрэгжүүлэх нь зүйтэй Шүүмүүл зэрэг вектор үржихээс сэргийлэх арга хэмжээ авах Усны аж ахуйн байгууламжид нэвтрэх боломжийг хязгаарлах Амьдрах чадвартай трематодын өндөг илрүүлэх шинжилгээний талаар ДЭМБ-ын 2006 оны удирдамжийн 3 дугаар ботийн 40 дүгээр хуудаснаас харна уу 	<p>WHO (2006) Vol. 3, 21, 41 & 47-68.</p>
Хэрэглээнд хязгаарлалт тогтоох	БАГА – ИХ	<ul style="list-style-type: none"> Зөвхөн чанаж хүнсэндээ хэрэглэдэг усны ургамал, загасны төрлийг үржүүлэх Ялгавч загас үржүүлэх аж ахуйд трематодын халдвараас сэргийлэхэд онцгой анхаарах 	<p>WHO (2006) Vol. 3, 55.</p>
Бохир ус ашигласнаас ургац хургах хүртэл барих хугацаа	ДУНД ЗЭРЭГ	<ul style="list-style-type: none"> Үр дүн хугацаанаас хамаардаг Загас буюу усны ургамлын ургац хурдахаас өмнө эмгэг төрөчийг үхүүлэх хугацаа олгохын тулд тодорхой хугацааны турш шинээр нэмж бохир ус ашиглахгүй байхыг зөвлөмж болгодог. Гэхдээ томоохон усны аж ахуйн цөөрм рүү ойр орчмын өрхүүдийн бохир ус байнга нийлүүлэгдэж байдаг. 	<p>WHO (2006) Vol. 3, 57.</p>

Сонгох хувилбар	Үр дүн, log буруалт	Тайлбар	Нэмэлт эх сурвалж
Цэвэрлэх (загасыг зарахаас өмнө цэвэр усанд байлгаж бохирдлыг бууруулах)	ДУНД ЗЭРЭГ	<ul style="list-style-type: none"> Хугацаанаас хамаардаг, 2-3 долоо хоног цэвэрлэхийг зөвлөмж болгодог Трематодын агууламжид нөлөөлөхгүй 	WHO (2006) Vol. 3, 57.
Хүнсэнд хэрэглэх	ДУНД ЗЭРЭГ	<ul style="list-style-type: none"> Загасны мах бохирлогодооос сэргийлэх Загасны гэдэс дотрыг нэн түрүүнд салгаж хаях хэрэгтэй Цэвэр хутга, бандан ашиглах 	WHO (2006) Vol. 3, 58.
Бүтээгдэхүүнийг угаах, халдваргүйжүүлэх	ДУНД ЗЭРЭГ	<ul style="list-style-type: none"> Усны ургамалд хамаарна 	WHO (2006) Vol. 3, 58.
Чанах	ИХ	<ul style="list-style-type: none"> Усны аж ахуйн бүх бүтээгдэхүүнд хамаарна Чананы дараа халдгалах явцад бохирлогдож болно 	WHO (2006) Vol. 3, 58.
Трематодын эсрэг эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээ	БАГА – ИХ	<ul style="list-style-type: none"> ДЭМБ-ын 2006 оны удирдамжийн 3 дугаар ботгийн Хүснэгт 5.4-өөс тоймыг харна уу 	WHO (2006) Vol. 3, 63-68.



А1-4 Ялгадсыг ашиглах

Хүснэгт А1-4 Ялгадсыг ашиглахтай холбоотой хяналтын арга хэмжээ

Хувилбар	Сонгох хувилбар	Үр дүн, loc бууралт	Тайлбар	Нэмэлт эх сурвалж
Ялгадсыг цуглуулж, хадгалах	Дан нүхэн жорлон	БАГА – ДУНД ЗЭРЭГ	<ul style="list-style-type: none"> Хугацаа өнгөрөх тусам эмгэг төрөгч үхнэ. Ялгадсыг сооруулах үед эрсдэл үүсдэг. Гүний ус бохирлогдохос сэргийлэхийн тулд нүхийг хөрсний усны түвшинээс дор хаяж 2-3 м дээш хэмжээнд ухсан байна (доторлоогоогүй) Жорлонгийн агааржуулалт сайн байхад анхаарна. Эвгүй үнэртэй бол хүмүүс ашиглахгүй, чийгтэй бол ялаа үржинэ Шээсийг өгтөнөөс салгаж цуглуулах техникийн шийдэл ашиглаж болно 	Stenstam et al. (2011), 14, 28-29, 32. WHO (2006) Vol. 4, 80, 83.
Ялгадсыг цуглуулж, хадгалах	Сэлгэх хос нүхэн жорлон	ДУНД ЗЭРЭГ – ИХ	<ul style="list-style-type: none"> Хос нүхэн жорлон нь ялгадсыг удаан хугацаа (>1.5-2 жил)-аар дээрээс нь ялгадас шинээр нэмэхгүйгээр хадгалах боломж олгодог Нэг нүх нь дүрвэхэд нөгөөхийг нь ашиглахад анхаарна Удаан хугацаагаар хадгалах нь бохир зайлуулж буй ажилтнуудыг хамгаалах арга болно Гүний ус бохирлогдохос сэргийлэхийн тулд нүхийг хөрсний усны түвшинээс дор хаяж 2 м дээш хэмжээнд ухсан байна (доторлоогоогүй) Жорлонгийн агааржуулалт сайн байхад анхаарна. Эвгүй үнэртэй бол хүмүүс ашиглахгүй, чийгтэй бол ялаа үржинэ Дараах нөхцөлд үр дүн ИХ байна: <ul style="list-style-type: none"> Цагаан хорхойн тархалт ихтэй газар 2-200С-д 1.5-2 жил хадгална >200С-д дор хаяж 1 жил хадгална рН-ийг >9 байлгаж чадвал (шохой буюу үнс нэмж) дор хаяж 6 сар хадгална 	Stenstam et al. (2011), 34-36, 87, 96. WHO (2006) Vol. 4, 69, 80, 82-83.
Ялгадсыг цуглуулж, хадгалах	Услуйжүүлэх хос нүхэн жорлон	ДУНД ЗЭРЭГ – ИХ	<p>Үр дүн: вирус, нянгийн хувьд их үр дүнтэй бөгөөд цагаан хорхойн өндөгний тоошилыг нэлээд бууруулдаг. Дэлгэрэнгүй мэдээллийг нэмэлт эх сурвалжаас харна уу.</p> <ul style="list-style-type: none"> Хос нүхэн жорлон нь ялгадсыг удаан хугацаагаар дээрээс нь ялгадас шинээр нэмэхгүйгээр хадгалах боломж олгодог Удаан хугацаагаар хадгалах нь бохир зайлуулж буй ажилтнуудыг хамгаалах арга болно Температур ба рН-с хамаарна Жорлонгийн агааржуулалт сайн байхад анхаарна Дараах нөхцөлд үр дүн ИХ байна: <ul style="list-style-type: none"> Цагаан хорхойн тархалт ихтэй газар 2-200С-д 1.5-2 жил хадгална >200С-д дор хаяж 1 жил хадгална рН-ийг >9 байлгаж чадвал (шохой буюу үнс нэмж) дор хаяж 6 сар хадгална 	Stenstam et al. (2011), 87. WHO (2006) Vol. 4, 69, 82-83.

Хувилбар	Сонгох хувилбар	Үр дүн, юг бууралт	Тайлбар	Нэмэлт эх сурвалж
Ялгадсыг цуглуулж, хадгалах	Усан булхаатай жорлон / бохирын цооног	БАГА – ИХ	<ul style="list-style-type: none"> Гүний ус бохирлогдохоос сэргийлэхийн тулд нухийг хөрсний усны түвшинээс дор хаяж 2 м дээш хэмжээнд угсан байна (догорилоогоо хийг дээггүй) Жорлонгийн агаржжуулалт сайн байхад анхаарна. Эвгүй үнэртэй бол хүмүүс ашиглахгүй, чийгтэй бол ялаа, шумуул үржинэ Усны хангамжаас хамаарна (ж.нь, усны хангамж муу бол жорлонгийн ариун цэврийн нөхцөлд сөртөөр нөлөөлнө) Ажилтнуудыг хамгаалах зорилгоор жорлон бөглөрөхөөс сэргийлнэ. Засвар үйлчилгээ хийж байгаа ажилтнууд хамгаалах хэрэгсэл (ж.нь, бээлий) хэрэглэнэ Бохирын цооногт чигшил хэт их байвал анаароо орчин бүрддэг, харин хэт бага бол биологийн задрал удааширдаг Бохирын цооногт эмгэг төрөлчийн хорогдол бага явагддаг ба нян, вирус нь шингэн ба халуу фазын аль алинд нь байдаг. Цагаан хорхойн өндөгний логарифм бууралт 0.5 нэгжээс бага байна. 	Stenstjmt et al. (2011), 19-20, 38-39, 43-44, 96. WHO (2006) Vol. 4, 80-88.
Ялгадсыг цуглуулж, хадгалах	Биологийн хийн реактор	ДҮНД ЗЭЭРЭГ – ИХ	<ul style="list-style-type: none"> Үр дүн хадгалах хугацаанаас, мөн термофиль эсхүл мезофиль задралын аль нь явагдаж байгаагаас хамаардаг: <ul style="list-style-type: none"> Термофиль (50-600С) – хэдэн хснөгийн дотор логарифм бууралт 1.5-2 нэгжид хүрнэ Мезофиль (30-380С) – хэдэн долоо хоног-сар шаарддагдана Тухайлбал, анаароо цооногт Sterilization process-ийн логарифм бууралтыг 3 нэгжид хүргэхийн тулд 370С-д 10 хоног, 470С-д 4 хоног, 550С-д 2 хоног шаардлагатай байна. Хялгасан хорхойн хувьд 370С-д 10 хоногт хорогдол 75%, 470С-д 2 хоногт хорогдол 95%, 550С-д 1 цагт 3 логарифм нэгжээс их байв. Биологийн хийн реакторт нэмж халаахгүйгээр термофиль нөхцөл бүрдүүлэх боломж хязгаарлагдмал байдаг. 	Kato et al. (2003). Stenstjmt et al. (2011), 47-48
Ялгадсыг дамжуулах				
	Гар ажиллагаагаар асгаж, тээвэрлэх	ИХ – ДҮНД ЗЭЭРЭГ	<ul style="list-style-type: none"> Цэвэрлэгдсэн бохирьг тээвэрлэнэ Ажилчид, оршин суугчдыг хамгаалах арга хэмжээний талаар А1-7 дугаар хэсгээс харна уу 	Stenstjmt et al. (2011), 57. WHO (2006) Vol. 4, 89.
	Механикжсан аргаар соруулж, тээвэрлэх	Өртөмтгий бүлэг, арга ажиллагсанаас хамаарч ялгаатай байна	<ul style="list-style-type: none"> Цэвэрлэгдсэн бохирьг тээвэрлэнэ Ажилчид, оршин суугчдыг хамгаалах арга хэмжээний талаар А1-7 дугаар хэсгээс харна уу 	Stenstjmt et al. (2011), 59. WHO (2006) Vol. 4, 89.



Хувилбар	Сонгох хувилбар	Үр дүн, лог бууралт	Тайлбар	Нэмэлт эх сурвалж
Ялгадсыг Цэвэрлэх : Хоёрдогч				
	Бүрэн шатаах (үнсэнд нүүрстөрөгч <10%)	ИХ	<ul style="list-style-type: none"> Эмгэг төрөгчдийг бүрэн устгах температурт шатаах 	WHO (2006) Vol. 4, 68.
	Температурыг 500С-с дээш түвшинд барьж, дор хаяж 7 хоногийн турш задлах	ДҮНД ЗЭРЭГ – ИХ	<ul style="list-style-type: none"> Температурыг барьж чадвал – ИХ, бүрэн барьж чадахгүй бол – ДҮНД ЗЭРЭГ Мезофиль задралын хувьд баталгаажуулах хяналт–шинжилгээ хийнэ 500С хүртэлх температурыг задрал явагдсан бол ялгадсыг хадгалах хугацааг өмнөх хэсгүүдээс харна уу Хялгасан хорхойн өндөгний логарифм бууралт >1.5-2 нэгж (термофиль задрал) 	Копе et al. (2007). Stenstrup et al. (2011), 77. WHO (2006) Vol. 4, 68.
Хоёрдогч хадгалалт	Ердийн хадгалалт		<ul style="list-style-type: none"> Анхдагч цэвэрлэлтийн нэгэн адил хугацаа, гадна температур нөлөөлнө 	
Хоёрдогч хадгалалт	Шүлтээр цэвэрлэх, хадгалах	ДҮНД ЗЭРЭГ – ИХ	<ul style="list-style-type: none"> pH<9 бол >6 сар (температур >350С, чийгшил <25%) pH бага эсхүл чийгшил их бол хугацаа уртасна pH=11 (ө.х. шохой нэмсэн) үед хугацаа богино байна 	WHO (2006) Vol. 4, 68.
Хоёрдогч хадгалалт	Хатаах талбай ба хат ягаан туяагаар шаррах	ДҮНД ЗЭРЭГ – ИХ	<ul style="list-style-type: none"> Цагаан хорхойн өндөг – 3 логарифм бууралт (1 сар) Нян – 2.5-6 логарифм бууралт (4 сар хадгалах) 	Кенгле et al. (2009). Nielsen (2007). Stenstrup et al. (2011), 77, 137.
Ялгадстай харьцах ерөнхий асуудал				
Ерөнхий			<ul style="list-style-type: none"> Ажилчдыг хамгаалах арга хэмжээний талаар А1-7 дугаар хэсгээс харна уу 1 т хуурай бодисд <1 цагаан хорхойн өндөг байвал хяналтын нэмэлт арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагагүй Өтгөн даг, биологийн хатуу хог хаягдлыг хадгалахдаа гадаргуйн ус руу угаагдахаас хамгаална Векторын хяналтын арга хэмжээ 	Stenstrup et al. (2011), 99. WHO (2006) Vol. 4, 66.
Ялгадсыг ХАА-д ашиглах				
1 т хуурай бодисд <1 цагаан хорхойн өндөг үргэл цэвэрлэсэн буюу цэвэрлээгүй ялгадсын хувьд хэрэгжүүлэх нэмэлт хяналтын арга хэмжээ				
Тариалангийн газарт ашиглах	Цэвэрлэсэн ялгадсыг хөрстэй бүрэн холино	ХЭМЖИХ БОЛОМЖИГҮЙ (хавьтлыг багасгах)	<ul style="list-style-type: none"> Ийнхүү ашигласнаар ургамлын шим тэжээл сэйжирчнэ Ашиглах явцад хувийн ариун цэврийг сайтар сахина 	Stenstrup et al. (2011), 87, 97. WHO (2006) Vol. 4, 78.
Тариалангийн газарт ашиглах	Газар халгалах, үр тарих үед ашиглах	ДҮНД ЗЭРЭГ – ИХ	<ul style="list-style-type: none"> Бордсоноос ургац хураах хүртэлх хугацаанаас үр дүн хамаарна 	

Хувилбар	Сонгох хувилбар	Үр дүн, log бууралт	Тайлбар	Нэмэлт эх сурвалж
Хэрэглээнд хязгаарлалт тавих	Хүнсний бүс зориулалттай үр тариа эхсүүл чанаж, боловсруулсны дараа хүнсэнд хэрэглэдэг үр тариаг борлоход ашиглах	ИХ	<ul style="list-style-type: none"> Ингэснээр өртөмтгий бүлгийг зөвхөн тариаланчдаар хязгаарлах боломжтой Тариаланчид хувийн ариун цэврийг сайтар сахих шаардлагатай 	Stensildum et al. (2011), 87. WHO (2006) Vol. 4, 77.
Эмгэг төрөлчийг үрүүлэх 1 сарын хугацааг баримтлах	Ургац хураахаас тодорхой хугацааны өмнө ялгдсаар бордохыг зогсоох	ДҮНД ЗЭРЭГ – ИХ	<ul style="list-style-type: none"> Ажилчид, оршин суугчдыг хамгаалах арга хэмжээний талаар А1–7 дугаар хэсгээс харна уу Энэхүү арга хэмжээг үр тариаг зарж борлуулахаас өмнө тодорхой хугацаанд хадгалах арга хэмжээтэй (БАГА – ДҮНД ЗЭРЭГ) хослуулж болно 	USEPA (1992). WHO (2006) Vol. 4, 78.
Ургац хураасны дараах өртөлтийг бууруулах арга хэмжээ	Халдварлүйтгэх бодистой, бодисгүй угаах, хальсгах, чанах г.м.	ДҮНД ЗЭРЭГ – ИХ	<ul style="list-style-type: none"> Энэ бол хэрэглэгчийг хамгаалах арга хэмжээ Баталгаажуулахад төвөгтэй хяналтын арга хэмжээ Арга хэмжээний төрлөөс хамаарч логарифм бууралт 1–7 нэгж байна 	WHO (2006) Vol. 4, 78–79.
Ялгдсыг усны аж ахуйд ашиглах				
Цөөрөмд хийхээс өмнө ялгдсыг хадгалах		ДҮНД ЗЭРЭГ – ИХ	<ul style="list-style-type: none"> Хугацаанаас үр дүн хамаарна Сүүлд шинэ ялгадаас намснээс хойш хадгалалтын хугацааг тооцно Трематодын халдварын эрсдэлийг бууруулахын тулд 4 долоо хоног хадгална, Fasciola spp.-ийн халдварын эрсдэлийг бууруулахын тулд 10 долоо хоног хадгалах шаардлагатай Эмгэг төрөгч нян, вирус хорогдоно 	WHO (2006) Vol. 3, 50.
Биологийн хийн ферментаци хийх		БАГА – ДҮНД ЗЭРЭГ	<ul style="list-style-type: none"> Хугацаа, температургаас хамаарна Бүсэд арга хэмжээтэй хослуулахыг зөвлөмж болгодог 	WHO (2006) Vol. 3, 51.



А1-5 Шээсийг ашиглах

Хүснэгт А1-5 Шээсийг ашиглахтай холбоотой хяналтын арга хэмжээ

Хувилбар	Сонгох хувилбар	Үр дүн, лог бууралт	Тайлбар	Нэмэлт эх сурвалж
Шээсийг хадгалах	Шээс өгтөн ялгадсаар бохирлогдсон нь тодорхой	ХАМАРАХГҮЙ	<ul style="list-style-type: none"> Бохир усны нэгэн адил цэвэршүүлнэ (Хүснэгт А1-1-ээс харна уу) 	
Шээсийг хадгалах	Хүн, амьтан өргөхөвс сэргийлж шээсийг битүүмжилсэн саванд хадгалах	БАГА – ИХ	<ul style="list-style-type: none"> Өгтөн ялгадсаар давхар бохирлогдсон эсэхийг ажиглана Нягтийн хорогдол хадгалалтын хугацаанаас хамарна. 90%-ийн хорогдол явагдахад шаардагдах хугацаа (Т90): грам сөрөг нян – <5 хоног, криптоспориди – 1 сар, вирус – 1-2 сар Азотын алдагдлыг багасгана Хүн өргөх явдлыг багасгана Үнэр багасна 	Stensigt et al. (2011), 40-41. WHO (2006) Vol. 4, 70-71.
Шээсийг хадгалах	Эмгэг төрөгчийн хорогдлыг бууруулахгүйн тулд шингэрүүлэхгүй	ХАМААРАХГҮЙ	<ul style="list-style-type: none"> Шингэрүүлээгүй шээсийн рН 8.8 орчим байдаг нь нягтийн хорогдлыг эрчимжүүлдэг Шингэрүүлсэн шээсэнд шумуул үржиж чаддаг бол шингэрүүлээгүй шээсэнд чаддаггүй Шингэсемыг идэвхгүйжүүлдэг 	WHO (2006) Vol. 4, 70-71.
Ашиглахаас өмнө шээсийг хадгалахгүй	Өрхийн жижиг талбайг бордоход ашиглах	ХАМААРАХГҮЙ	<ul style="list-style-type: none"> Зөвхөн нэг өрхийн гишүүдийн шээсийг тухайн өрхийн жижиг талбайг бордоход ашиглаж байгаа бол хадгалах шаардлагагүй Нэг өрхийн гишүүдийн хооронд шээсээр халдвар дамжих эрсдэл "бордоо-үр тариа"-ны замтай харьцуулахад хүн хоорондын хавьтлаар илүү байна 	WHO (2006) Vol. 4, 70.
Ашиглахаас өмнө шээсийг хадгалах	Түүхийгээр нь хүнсэнд хэрэглэдэг үр тарианы хувьд	ӨНДӨР	<ul style="list-style-type: none"> >200С-д дор хаяж 6 сар хадгалж, шээсээр бордсоноос ургац хураах хүртэл тодорхой хугацааг мөрдөнө (нэмж хяналтын арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагагүй) 	Stensigt et al. (2011), 85. WHO (2006) Vol. 4, 70.
Ашиглахаас өмнө шээсийг хадгалах	Боловсруулалт хийж хүнсэнд хэрэглэдэг буюу малын тэжээлийн үр тарианы хувьд	ДУНД ЗЭРЭГ – ИХ	<ul style="list-style-type: none"> >200С-д дор хаяж 1 сар эсхүл 40С-д дор хаяж 6 сар хадгална 	Stensigt et al. (2011), 85.
ХАА-д шээсийг ашиглах				
Ашиглахаас өмнө шээсийг хадгалах	Шээсийг хөрстэй холлих эсхүл газарт ойр зайнаас шээсээр услах	ТООЦООЛГОХ БОЛОМЖГҮЙ	<ul style="list-style-type: none"> Ургамлын шим тэжээлийг сайжруулна Ашиглахдаа хувийн ариун цэврийг сайтар сахина 	WHO (2006) Vol. 4, 66, 70.
Ашиглахаас өмнө шээсийг хадгалах		ИХ	<ul style="list-style-type: none"> Хадгалалттай холбоотой зөвлөмжүүдтэй хослуулсан тохиолдолд ХЧА-гүй амьдарсан жилийн хорогдлыг 10-6-аас доош түвшинд эрсдэлийг бууруулдаг 	WHO (2006) Vol. 4, 70.

А1-6 Саарал усыг ашиглах

Хүснэгт А1-6 Саарал усыг ашиглахтай холбоотой хяналтын арга хэмжээ

Хувилбар	Сонгох хувилбар	Үр дүн, лог буюралт	Тайлбар	Нэмэлт эх сурвалж
Саарал усыг Цэвэрлэх				
Ерөнхий зүйл	2006 оны ДЭМБ-ын удирдамжийн 4 дүгээр ботийн Зур. 5.11-с харна уу	ДУНД ЗЭРЭГ – ИХ 1-4 нэгж	<ul style="list-style-type: none"> • Бохир устай харьцуулахад өтгөн ялгадсын бохирдол 3-5 логарифм нэгжээр бага байна • Амархан задардаг органик нэгдэл нь заагуур нян дахин сэргэж ургахад нөлөөлж болно • Бохир усыг цэвэрлэх аргыг саарал усыг Цэвэрлэх эд ашиглаж болно • Саарал ус цэвэрлэх, хадгалах байгууламжид амьтан, шавж нэвтрэхээс хамгаална • Саарал ус ихээхэн бохирдолтой, вектор үржих магадлалтай, цөөрмийг цэвэрлэх боломжгүй үед гадаргүй доогуур усжуулахыг зөвлөмж болгодог 	WHO (2006) Vol. 4, 66, 77, 93-99 & Fig 5.
Саарал усыг ХАА-д ашиглах				
Саарал усыг усжуулалтад ашиглах	Бохир усыг цэвэрлэх аргыг ашиглана	БАГА – ИХ	<ul style="list-style-type: none"> • Өтгөн ялгадсаар бага бохирлогдсон, цэвэрлэсэн саарал усыг ашиглахад үр тарианы хэрэглээнд хязгаарлалт тогтоох шаардлагагүй • Хөрсөнд ойр усжуулах аргыг ашиглахыг зөвлөмж болгоно • Ус тогтонгишиж, вектор үржихээс сэргийлнэ 	WHO (2006) Vol. 4, 78.



А1-7 Ажилчид, орон нутгийн олон нийт, тариаланчид, хэрэглэгчдийг хамгаалах хяналтын арга хэмжээний жишээ

Хүснэгт А1-7 Ажилчид, орон нутгийн олон нийт, тариаланчид, хэрэглэгчдийг хамгаалахтай холбоотой хяналтын арга хэмжээ (эдгээр арга хэмжээний заримыг мөн Хүснэгт А1-1-ээс А1-6-д тогилтуулсан болно)

Ажилчид (A)
<ul style="list-style-type: none"> • Хувийн хамгаалах хэрэгсэл (бээлий, амны хаалт, усны гутал г.м.) • Өргөлтийг багасгах тоног төхөөрөмж, хэрэгсэл (ж.нь, вакуум цистерн) • Аюулгүй ажиллаганы сургалт • Бохир ус зэргийг ашиглахаас өмнө Цэвэрлэх • Байгууламжийн дизайнд бохирыг зайлуулахад тохиромжтой байх • Бохир асгарахаас сэргийлэх • Бохиртай ажиллах тусгай багаж хэрэгсэл • Цэвэрлээгүй бохиртой холбоотой тар ажиллагааг аль болох багасгах • Шистосомозын голомттой газар нутагт бохир усанд өртсөний дараа биеийг саван, аюулгүй усаар угааж хэвших • Вектороос хамгаалах (үргэх тос, хими эмчилгээ, дархлаажуулалт г.м.) • Багнадын эсрэг дархлаажуулалт • Цагаан хорхойн эсрэг эмчилгээг жилд 2-3 удаа хийх • Шистосомозын голомттой газар нутагт түүний эсрэг эмчилгээнд хамруулах • Арьсны зулгаралт, зүсэлтийг эмчлэх

Тариаланчид (I)
<ul style="list-style-type: none"> • Хувийн хамгаалах хэрэгсэл (бээлий, амны хаалт, усны гутал г.м.) • Гадагуйн доогуур усжуулах • Хөрсөнд ойр усжуулах аргыг ашиглах • Өргөлтийг багасгах тоног төхөөрөмж, хэрэгсэл (ж.нь, хувингийн оронд гуурсан хоолойгоор услах) • Бохир усаар усжуулалт хийж байхад тарзан талбайд нэвтрэхийг хязгаарлах • Ажлын талбарт аюулгүй үндэнх ус, бие засах газар хүртээмжтэй байх • Хувийн ариун цэврийн талаар сургалт • Шистосомозын голомттой газар нутагт бохир усанд өртсөний дараа биеийг саван, аюулгүй усаар угааж хэвших • Вектороос хамгаалах (үргэх тос, хими эмчилгээ, дархлаажуулалт г.м.) • Багнадын эсрэг дархлаажуулалт • Цагаан хорхойн эсрэг эмчилгээг жилд 2-3 удаа хийх • Шистосомозын голомттой газар нутагт түүний эсрэг эмчилгээнд хамруулах • Арьсны зулгаралт, зүсэлтийг эмчлэх

Хэрэглэгчид (X)
<ul style="list-style-type: none"> • Эмгэг төрөгч үхэх 1 сарын хугацаа гаргах • Ургац хураахаас 1 сарын өмнө бохирын ашиглалтыг зогсоох • Үр тариаг зарж борлуулахаас өмнө 1 сар халдлагах • Дээрх 2-ыг хослуулах (нийлбэр хугацаа – 1 сар) • Ургац хураасны дараа өргөлтийг багасгах арга хэмжээ: <ul style="list-style-type: none"> • Үр тариаг усаар угааж • Загасны гэдэг дотор ба махыг ялгах боловсруулалтын арга • Үр тарианы халдваргүйжүүлэлт • Үр тариа (жимс, үндсэрхэг ногоо) – гальслах • Чанаж хүнсэнд хэрэглэх • Хувийн ариун цэврийг сахиж – ялангуяа хоол бэлдэх, идэхийн өмнө савантай усаар гараа угаах • Хүнсний захын эрүүл ахуй • Хуадалдагч нарын сургалт • Хүнсний закуудад аюулгүй усаар хангах • Дархлаажуулалт, эмийн урьдчилан сэргийлэлт

Орон нутгийн оршин суугчид (O)
<ul style="list-style-type: none"> • Цэвэрлэх байгууламжийг хашиж • Анхааруулах тэмдэглэгээ хийж (ялангуяа хашаагүй цөөрөм, талбайн орчим) • Оршин суугчдад зориулсан МСС • Аюулгүй үндэнх ус, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх • Векторын үржлийг таслан зогсоох • Ус, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх • Векторын үржлийг таслан зогсоох • Суурьшлын бүсээс 50–100 м зайтай буфер бүс бий болгох • Тариалангийн талбай, бохир ашигладаг усны аж ахуйд нэвтрэхэд хязгаарлалт тогтоох • Цэвэрлэх цөөрмийн орчим амралт зугаалтыг хориглох • Вектороос хамгаалах (үргэх тос, хими эмчилгээ, дархлаажуулалт г.м.) • Өргөлтийг хүн амд цагаан хорхойн эсрэг эмчилгээг жилд 2-3 удаа хийх

Эх сурвалж: Stenstam et al. (2011), 74–78, 93, 100. WHO (2006) Vol. 2, 79–80; Vol. 3, 21, 43–45, 47–68; Vol. 4 74–78.

ХАВСРАЛТ 2

Бохирыг усалгаанд ашиглахтай холбоотой нянгийн эрүүл мэндэд үзүүлэх эрсдэлийн тойм

Хүснэгт А2-1 Бохирыг усалгаанд ашиглахтай холбоотой нянгийн эрүүл мэндэд үзүүлэх эрсдэл

Өргөтгий бүлэг	Нян, вирусийн халдвар	Эгэл биетний халдвар	Цагаан хорхойн халдвар
Тархаланчид, тэдний гэр бүл	Бохир усан дах <i>E. coli</i> -ийн тоошил $100 \text{ мл-д} > 10^4$ бол ийм усанд өртсөн хүүхдэд суулгалт өвчин үүсэх эрсдэл нэмэгддэг Цэвэрлээгүй бохир усанд өртсөн хүүхэд сальмонеллын халдварт өртөх эрсдэл нэмэгддэг Хагас цэвэрлэсэн бохир усанд өртсөн насанд хүрэгчдэд норовирусийн эсрэг ийлдсийн хармуу урвал нэмэгдсэн байдаг	Цэвэрлэсэн ба цэвэрлээгүй бохир усанд өртөхөд <i>Giardia intestinalis</i> -ийн халдварт өртөх эрсдэл нэмэгддэг Пакистанд хийсэн судалгаагаар цэвэрлээгүй бохир ус ашигладаг хүмүүс <i>Giardia intestinalis</i> -ийн халдварт өртөх эрсдэл цэвэр ус ашигладаг хүмүүстэй харьцуулахад 3 дахин их байв Цэвэрлээгүй бохир усанд өртөхөд амьбисазын эрсдэл нэмэгддэг	Цэвэрлээгүй бохир усанд өртсөн насанд хүрэгчид ба хүүхдэд цагаан хорхойн халдварын эрсдэл нэмэгддэг Хөл нүдтэн тариан талбайд ажиллахад аңкилостомозын эрсдэл нэмэгддэг Бохир усан дах цагаан хорхойн өндөгний тоошилыг 1 литрт < 1 болтол цэвэрлэсэн ч хүүхэд халдвар авах эрсдэлтэй (насанд хүрэгчдийн хувьд эрсдэлгүй)
Бохир усаар усар усжуулдаг талбайн ойролцоо амьдардаг хүн ам	Чанар муутай ($100 \text{ мл-д} 10^6-10^8$ колиформ) усыг бороожуулах усжуулалтад ашиглах, түүнд агаар дуслын замаар өртөхөд халдвар авах эрсдэл нэмэгддэг Хагас цэвэрлэсэн ($100 \text{ мл-д} 10^4-10^5$ колиформ) усыг бороожуулах усжуулалтад ашиглахад вирусийн халдварын эрсдэл нэмэгддэг	Бохир усыг бороожуулах усжуулалтад ашиглахад эгэл биетний халдвар тархдаг гэх нотолгоо байхгүй	Бохир усыг бороожуулах усжуулалтад ашиглахад цагаан хорхойн халдвар тархдаг эсэхийг судлаагүй Халиах, гадаргын усжуулалтын хувьд дээрхтэй ижил
Бохир усаар усалж уртлуулсан үр тариа хэрэглэгчид	Цэвэрлээгүй бохир ус ашигласантай холбоотой холер, балнад, шигеллезийн дэгдэлт бүртгэгддэг ба хеликобактерийн эсрэг ийлдсийн хармуу урвал илэрдэг Усан дах <i>E. coli</i> -ийн тоошил $100 \text{ мл-д} > 10^4$ -с их бол өвөрмөц бүс суулгалт нэмэгддэг	Бохир усаар усалсан хүнсний ногооны гадаргуу дээр эгэл биетэн илэрдэг боловч өвчин дамждаг гэх шууд нотолгоо байхгүй	Цэвэрлээгүй бохир ус ашигласан бол хүүхэд, насанд хүрэгчдийн аль алинд халдвар авах эрсдэл өндөр

Эх сурвалж: *Stenstam et al. 2011 (x.91-92)-с нэмэлт мэдээлэл авна уу*



ХАВСРАЛТ 3

Бохирын химийн бодисын хөдөө аж ахуй болон усны аж ахуйд үзүүлэх нөлөө

Бохирын химийн бодисын ХАА-д үзүүлэх нөлөө

Бохир усан дах ихэнх химийн бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтооходоо хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөг биш, харин үр тариад үзүүлэх нөлөөг харгалзан тогтоодог. Учир нь, химийн бодисын ургамалд хортой нөлөө үзүүлэх тун хүний эрүүл мэндэд хортой нөлөө үзүүлэх тунгаас бага байдаг.

Усжуулалтын усан дах химийн бодисын түвшрүүлгийг тодорхойлж, ургамлын усалганд тохирох эсэхийг тогтоодог. Үр тарианы усжуулалтад ашиглах цэвэрлэсэн бохир усны физик-химийн шинж чанар нь НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас тогтоосон лавлагаа үзүүлэлттэй нийцэх ёстой бөгөөд эдгээрийг 2006 оны ДЭМБ-ын удирдамжийн 2 дугаар ботгийн Хавсралт 1-ээс харна уу.

Хүний эрүүл мэндэд хортой эсэхийг тогтооход химийн бодисын хөрсөн дэх түвшрүүлгийг харгалзан үздэг. Учир нь, химийн бодис усаар дамжин хөрсөнд шингэж, хөрснөөс ургамалд шингэж, улмаар хүний биед ордог байна. Хүснэгт А3-1-д химийн бодисын хөрсөн дэх зөвшөөрөгдөх дээд хэмжээг харуулсан бөгөөд үүнээс хэтэрсэн тохиолдолд химийн бодис хүнсний сүлжээгээр дамжин хүний биеийг хордуулах нөлөө үзүүлж болдог. Органик бус химийн бодисын хувьд бохир усаар усалгаа хийх тоолонд хөрсөн дэх агууламж нь аажим нэмэгддэг байна. Харин органик нэгдлийн хувьд бохир усан дах түвшрүүлэг нь маш бага байдаг тул хөрсөнд зөвшөөрөгдөх хэмжээнээс ихээр хуримтлагдах магадлал бага юм.

Хүснэгт АЗ-1 Хүний эрүүл мэндийг хамгаалах зорилгоор тогтоосон хөрсөн дэх химийн хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ

Химийн элемент	Хөрсөн дэх түвшрүүлэг (мг/кг)	Органик нэгдэл	Хөрсөн дэх түвшрүүлэг (мг/кг)	Органик нэгдэл	Хөрсөн дэх түвшрүүлэг (мг/кг)
Сурьма	36	Альдрин	0.48	Полихлорт бифенил	0.89
Хүндэл	8	Бензол	0.14	Пентахлорфенол	14
Барм	302	Хлордан	3	Фталат	13733
Берилли	0.2	Хлорбензол	211	Пирен	41
Бор	1.7	Хлороформ	0.47	Стирол	0.68
Кадми	4	2,4-D (гербицид)	0.25	2,4,5-T (гербицид)	3.82
Фтор	635	ДДТ (инсектицид)	1.54	Тетрахлорэтан	1.25
Хар тугалга	84	Дихлорбензол	15	Тетрахлорэтилен	0.54
Мөнгөн ус	7	Дильдрин	0.17	Толуол	12
Моллибден	0.6	Диоксин	0.00012	Токсафен	0.0013
Никель	107	Гептахлор	0.18	Трихлорэтан	0.68
Селен	6	Гексахлорбензол	1.40		
Мөнгө	3	Линдан	12		
Таллий	0.3	Метоксипир	4.27		
Вагний	47	Ангилин нүүрс-устөрөгч	16		

Эх сурвалж: 2006 оны ДЭМБ-ын удирдажигийн 2 дугаар боть, х.72



Бохирын химийн бодисын усны аж ахуйд үзүүлэх нөлөө

Энэ талаарх дэлгэрэнгүй мэдээллийг 2006 оны ДЭМБ-ын удирдамжийн 3 дугаар ботийн 3.3 дугаар хэсгээс харна уу.

Кодекс бүр Хүнсний эрхзүйн хороо (www.sodexalimitations.org)-оос хүнсний бүтээгдэхүүн дэх химийн бодисын зөвшөөрөгдөх хэмжээг тогтоодог. Хүснэгт АЗ-2-г 2006 оны ДЭМБ-ын удирдамжид ашигласан стандартыг харуулсан болно. Уншигчид эдгээр стандарт шинэчлэгдсэн эсэхийг шалгахын зэрэгцээ үндэсний стандартуудад ашиглах нь зүйтэй юм.

Хүснэгт АЗ-2 Загас, хүнсний ногоон дэх химийн бодисын агууламжийн стандарт (2006 оны ДЭМБ-ын удирдамж)

Химийн бодис	Загас, зягтасан бүтээгдэхүүний стандарт (мг/кг)	Эх сурвалж	Хүнсний ногооны стандарт (мг/кг)	Эх сурвалж
Хүнд метал				
Хүндэл	Стандарт байхгүй		0.2	Кодекс
Кадм	0.05-1.0	Европын зөвлөл	0.2	Кодекс
Хар тугалга	0.3	Кодекс	0.1 0.1 (жимс) 0.3 (навчит ногоо)	Кодекс
Метил мөнгөн ус	0.5-1.0	Кодекс	Стандарт байхгүй	
Органик нэгдэл				
Диоксин	0.000004	Европын зөвлөл	Стандарт байхгүй	
ДДТ, ДДЭ	5.0	АНУ-ын ХЭА	Стандарт байхгүй	
Полихлорт бифенил	2.0	АНУ-ын ХЭА	Стандарт байхгүй	

Эх сурвалж: 2006 оны ДЭМБ-ын удирдамжийн 3 дугаар боть, х.43
Стандарт шинэчлэгдсэн эсэхийг дараах эх сурвалжаас шалгана уу:
Кодекс www.sodexalimitations.org

Европын зөвлөл www.ec.europa.eu/food/food/chemicalsafety/contaminants/index_en.htm
АНУ-ын ХЭА, АНУ-ын Хүнс, эмийн агентлаг www.fda.gov/food/foodborneillnesscontaminants/default.htm

Загас, хүнсний ногоон дэх химийн хортой бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээг баталгаажуулах хөтөлбөрт ашиглах боломжтой. Бохир ус ашигладаг усны аж ахуйн бүтээгдэхүүн дэх химийн бодисын түвшрүүлгийн баталгаажуулах хяналт-шинжилгээг тухайн бүтээгдэхүүнийг зарж борлуулж буй цагүүдэд 6 сарын зайтай хийх ёстой. Бохир ус ашигладаг усны аж ахуйн бүтээгдэхүүнийг бохир ус ашигладаггүй усны аж ахуйн ижил бүтээгдэхүүнтэй харьцуулан судлах нь бохир усанд ямар химийн бохирдуулагч байгааг хянахад тус дөхөм болдог. Өндөр агууламжтай химийн бодисыг сонгон цаашдын тогтмол хийгдэх хяналт-шинжилгээний хүрээнд хянах боломжтой.

